



ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

ШИХИХУТУГ

2004

Сэтгүүлийн зөвлөл:

Д.Лүндээжанцан (эрхлэгч)

О.Амархүү (ерөнхий редактор)

Гишүүд:

Ж.Болдбаатар

Г.Совд

Ч.Энхбаатар

Н.Лүндэндорж

Б.Мандахбилэг

Н.Батболд (нарийн бичгийн дарга)

РЕДАКЦИЙН ХАЯГ: Сүхбаатар дүүрэг 7 дугаар хороо

Шихихутуг ХЗДС-ийн байр

E-mail: shikhi_setguul@yahoo.com

Утас: 323392

91181909

ТАРБИ

Ж.БОЛБАТАР
- монгол дахь уас төрийн өөрчлөлт,
шинэчлэл, гүнзгийрлийн хандлага
шинэчлэл

13
- монгол үгтээх гэмт хэрэг, түүнээс
үргэлжинд сөрийн асуулаа
Б.ГАНБОЛД

16
- гэмт хэрэг зүйлчлэвэлний зарчим
О.АМАРХҮҮ

23
- байгаль хамгаалах монгол уламжлалыг
сэтгэн үзэвчлэл асуулаа
Н.ЛҮНЦЭНДӨЖ

31
- монголчуудын өмнөх эрхийн үзэл
сэтгэлзэний уламжлал, шинэчлэл
Ч.ӨНӨРБАЯР

57
- XIX-XX зууны эхэн үеийн Европын
ундсан хуульчлалтын хөгжил
М.БАТСҮРЬ

63
- "эрх явдал" - т.галтхуу зүйлчлэл асуулаа
ХЗВАГААЖ БОНОН
Ж.НАРАНПүРЭВ

74
- төрийн эрх мэдэл хуульчлалтын орчинд
Б.ГҮНБИЛЭГ

81
- жишээний эрх зүй
О.ХАНДАН

103
- БНХАУ-ын хөдөө тосгоны газрын эрх зүйн
харилцан харилцаа асуулаа
Д.ЯНЖИНХОРОЛ

110
- иргэний эрх зүйн хоёролдогчлолт
Е.П.ТОМБОНАЙ ХАРЬДУУЛААТ

116
- УА ХӨДӨӨХ ХӨРӨГӨН ИЙЛШЭГЭЖ ЭВН ХАМГААЛААТ

123

МАНАЙ ВУЛАЙ

ОНОН АРГА ЗҮЙ

СОЛ ИРЭШЛЭЛ
ТҮҮХ, ҮНЭЖЛЭЛ,
СОЛ ИРЭШЛЭЛ

ПРОЦЕССИН ЭРХ ЗҮЙ

ҮЗЭЛ БОЛОН,
ЧӨНӨӨТ ХАРААХ

ГАРАА ОРИН БОЛОН
ОНОН ҮНЭЖЛЭЛ ЭРХ ЗҮЙ

ИРЭГЛЭХ ХЭРГЭЛЭЭ

ШИНЭ СНИТ
КХУАЙ

ТОЛООЖИЖ УОЛГОЛ
УСЦУУСЦУУ

ШИНЭ СНИТ
КХУАЙ

МАНХАЙ ЗӨВӨЖ ГЭННЭ

МОН СНИТ

МОНГОЛ ДАХЬ УЛС ТӨРИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

Академич Ж.Болдбаатар

“Ардчилал” хэмээх ганцхан үгээр илэрхийлэгдсэн хүмүүн төрөлхтөний хөгжил, оршин байхуйн өвөрмөц хэлбэр, дэлхий дахины хөгжил, дэвшлийн энэхүү үнэт зүйл өдгөө замба тивийн хүн ардын их зонхийн хүртээл, нийгмийн нийтлэг чиг баримжаа болон төлөвшиж байна. XX зууны сүүлчийн мөчлөгт дэлхийн олон улс түмэн олон үзлийн найралт ёсыг хүлээн зөвшөөрч, ардчилсан тогтолцоонд шилжиж, бас хүнд сурталт захиргаадгалтын дэглэмтэй нэлээд улс оронд ардчилал дахин сэргэж, улмаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх түвшинд иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлснээр ардчиллын үйл явц тогтвортой өргөжин тэлсэн юм. Нийгэмд тулгамдаж буй улс төр, эдийн засгийн зорилтуудыг оновчтой шийдвэрлэх угтвар нөхцөл болсон хүний эрх, эрх чөлөөг хангах үр нөлөөтэй, өгөөжтэй арга зам нь ардчилсан засаглал болон улс төрийн ухаалаг бодлого болохыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Монголчууд хэзээнээс “Муу засаг гэдэг төрийн өвчин, төрийн өвчин гэдэг иргэний зовлон” гэж үзэж, ямагт сайн засаглал тогтоохыг хүсэн эрмэлзэж ирсэн юм.

Тийм боломж, сонголтыг түүхэн цаг үе бидэнд хайрлалаа.

Иргэний нийгмийн агуулга нь иргэдийн санал, санаачилга, төрийг удирдахад оролцох оролцоо, төрийн засаглалд үзүүлэх нөлөөллийг аль болохоор нэмэгдүүлэхэд оршино. Иймээс иргэний нийгмийн нэг чухал бүрдэл нь сайн засаглал юм. Хураангуйгаар илэрхийлбэл, сайн засаглал нь ардчилал, хүний эрх, шударга ёс, эрүүд саруул нийгмийн баталгаа билээ.

I. УЛС ТӨРИЙН ШИНЭ СОНГОЛТ

Монгол улс бол зуун зууныг зулсан төр ёсны түүхэн уламжлалтай, бас ч төлөөллийн ардчилалын түүхэн улбаа, үр хөврөл бүхий орон юм. XX зуунд Монгол улс хэмжээгүй эрхт хаант засгаас хэмжээт цаазат хаант засагт, түүнээс Бүгд Найрамдах байгуулалд орсон нь улс төрийн хувьд яах аргагүй томоохон ахиц дэвшил болой. Гэвч хөгжлийн явцад гаднын дарамт шахалтын улмаас монголын нийгмийн чиг баримжаа өөрчлөгдөж, үндэсний ардчилсан чиг шугам алдагдан, ардчилалын тухайд ам, ажил хоёр алд дэлэм зөрөхөд хүрсэн бөлгөө.

Монгол оронд 1980-иад оны сүүлч, 1990-ээд оны эхээр өөрчлөлт шинэчлэл хийхийн босгон дээрх нийгмийн дүр төрхийг тодорхойлбол:

-улс оронд хүнд сурталт захиран тушаах тогтолцоо бэхжин архагшиж, нэг намын хязгааргүй ноёрхол тогтсон байсан.

-өмчийн олон хэлбэр, ялангуяа хувийн өмчийг мөлжлөгийн хэрэгсэл хэмээн үл зөвшөөрч, зах зээлийн механизмыг үгүйсгэн, төвлөрсөн хатуу төлөвлөгөөнд баригдаж байсан.

-нийгмийн оюун санааны амьдралыг зөвхөн марксист үзэл сурталд захируулан дэглэж, олон үзлийн найралт ёсыг үл зөвшөөрч байсан.

-ЗХУ-ыг дагасан үндсэндээ ганц түшигт, түгжигдмэл гадаад бодлого явуулж, хилийн чанд дахь харилцаагаа социалист системийн хүрээнд улам бүр явцууруулж байсан зэрэг болно. Ийнхүү Монголын нийгэмд бүхэлдээ тоталитар дэглэм ноёрхох болжээ. Нэг хэсэг судлаачид 1960-аад оны дунд үеэс тоталитаризмаас авторитари дэглэмд шилжсэн гэж үзэж байхад нөгөө хэсэг нь бүхэлдээ 1990 он хүртэл тоталитари дэглэм ноёрхсон гэж үзэж байна. Ямраар ч үзлээ гэсэн эл улс төрийн дэглэмийн танин мэдэхүйн үндэс нь төвлөрлийг хэтрүүлэн үнэмлэхүй байдлаар тавьж байсан явдал юм. Энэ дэглэмийн нийгмийн үндэс нь ард түмэнд үл итгэн, ардчилсан аргад болгоомжлон хандаж байсанд оршино. Хураангуйлж хэлбэл, Монгол дахь социализм өөдлөн дэвших гарцгүй, мухардалд оржээ. Монголын нийгмийн амьдралыг бүхэлд нь ардчилах дотоод шалтгаан үүнээс урган гарсан юм.

1980-аад оны II хагас гэхэд дэлхийн социалист системийн орнуудын хөгжилд хямралын шинж тэмдэг илт мэдрэгдэж, Польш, БНАГУ, Болгар, Чехословак зэрэг орнуудад нийгмийг ардчилах хөдөлгөөн хүчтэй өрнөсөн билээ. Түүнчлэн дэлхийн социализмын гол түшиг тулгуур болж байсан Зөвлөлт Холбоот Улс “Перестройка” буюу “Өөрчлөн байгуулалт”-ын үзэл санаа дэвшүүлж, социализмыг өөрийн нь хүрээнд шинэчлэн өөрчлөх бодлого, үйл ажиллагааг эрчимжүүлжээ. (Горбачёв. 1988:4) Гэвч социализмын хөгжилд олон жилийн турш бугшсан архаг хууч, ялзралыг тогтолцооных нь хувьд эвдэн өөрчлөхгүйгээр эерэг үр дүнд хүрэхгүй нь тодорхой болов. Коммунизмын их гүрэнд ардчилах үйл явц хүч түрж, ЗХУ задран унажээ. Дорнод Европын социалист орнууд хөгжлийн шинэ замыг баттай сонгон авч байна. Гадаад ертөнц дэх энэхүү ардчилсан үйл явц Монгол орныг өөрчлөлт, шинэчлэлийн зам руу эргэлт буцалтгүй түлхжээ.

МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал: “Эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь нам, ард түмний хойшлуулшгүй зорилт болж байна” (V бүгд хурал. 1988:5) гэж заажээ. Энэхүү шинэ сонголт бол аль нэг улс төрийн хүчин, ямар нэг эрдэмтэн, мэргэн хүний ухаарал биш, монголын түмний эгээрэл сэхээрэл, хүн төрөлхтөний шинэ

сэтгэлгээ, ухаарлын хаялга, түүнийг тосон хүлээж авсан монгол түмний хичээл зүтгэлийн соёлсон үр мөн болой. Бас монголын ард түмэн түүхээс сургамж авч, хүн төрөлхтөний нийтлэг жамыг өнөд ухаарсан хэрэг байлаа. Монгол дахь өөрчлөлт шинэчлэлийн явцыг гадаад ертөнц тун анхааралтай ажиглаж, бодол санаагаа илэрхийлж байлаа. Тухайлбал, Английн монгол судлаач, эрдэмтэн Алан Ж.К.Сандерс нэрт монголч эрдэмтэн Ч.Р.Баудены “Монголын орчин үеийн түүх” хэмээх бүтээлийг 1989 онд дахин хэвлэхдээ бичсэн төгсгөлийн үгэндээ: “Геополитикийн эрхшээлд байдаг ч монголчууд өөрсдийн байр сууриа өөрсдөө ашигтай байдалд оруулах, Горбачевын “перестройка”, “гласность”-ийн найдвар ба ослыг хуваалцан Цэдэнбал, түүний өмнөх Чойбалсангийн үлдээсэн өв уламжлалыг хянаж залруулах, илүү хөгжингүй тэгш эрхтэй, ардчилсан нийгмийг өөрийн бодлоор байгуулах найдлага тавих биз ээ” (Бауден. 1989) гэжээ. Гэвч тухайн үеийн монголын эрх баригчид хөгжлийн шинэ сонголт-нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийг зоримог хэрэгжүүлэхийн оронд хэт хаширлаж, цааргалж, удаашруулж байв. Үүнээс болж, нийгмийн дотор бухимдал бий болж, иргэдийн сэтгэл зүй, үзэл үнэлэмжийн тогтвортой байдал алдагдан, эрх баригчдад итгэх итгэл эрс суларчээ.

1989 оны эцэс болоход айсуу цагийн өнгийг таньсан дэвшилтэт хүмүүс гудамж талбайд ухуулах хуудас нааж, дугуйлан, клуб байгуулан, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийгмийн шударга ёс, ардчилал, ил тод байдал тогтоохыг уриалах болов. Цагийн жам ёсны түрэлт, ардчилал, эрх чөлөөг хүсэн тэмүүлсэн хотол олны тэмцлийг тогтоон барих арга байсангүй. Удалгүй Монголын Ардчилсан Холбоо байгуулагдаж, ХХ зууны түүхнээ анх удаа эрх баригч-МАХН-ыг сөрөн зогсох улс төрийн хүч болон төлөвшиж эхлэв. (Заанхүү эмхэтгэсэн. 2004:27) Түүнчлэн Ардчилсан социалист хөдөлгөөн, Шинэ дэвшилт холбоо, Ногоонтны хөдөлгөөн зэрэг улс төрийн бусад олон хөдөлгөөн ар араасаа цуван бий болж, ардчилал, эрх чөлөөний төлөө хүчирхэг түрлэгт улам хөг нэмж байлаа. Тэд яваандаа олон намын тогтолцооны нийгмийн бааз болж, 1990 оны II сарын 18-нд Монголын Ардчилсан Нам, 1990 оны III сард Монголын Социал-Демократ Нам, Монголын Үндэсний Дэвшлийн Нам, Монголын Ногоон Нам, Монголын Чөлөөт Хөдөлмөрийн Нам гал голомтоо бадрааж, тулгын чулуугаа тулжээ.

Монголын Ардчилсан Холбоо болон бусад нам, хөдөлгөөний шууд идэвхитэй оролцоо, дэмжлэгтэйгээр ард олон урьд өмнө, тэр бүр ёсоор нь амталж мэдрээгүй байсан эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан зохион байгуулах, санаагаа чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөгөө эдэлж эхэлсэн юм. Эрх чөлөөний талбайд болсон нэгэн цуглааныг нээж, ардчилсан хөдөлгөөний удирдагчдын нэг Ц.Элбэгдорж: “Сайн цагийн түрүү ирж байна. Хүн бүр хүний бодлоор, хүний албадлагаар биш, өөрийнхөөрөө амьдрах цаг ирээд байна” (Элбэгдорж. 1999:17) гэж тэмдэглэсэн юм. Тэд олон

Улс төрийн ардчилсан шинэчлэлийн тулгуур цэг бол олон намдын тогтолцоо хүлээн зөвшөөрөх явдал байв. Ийм учраас МАХН-ын Төв Хорооны VIII бүтэц хурал (1990) тэр үед хүчин төгөлдөр үйлчилж байсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 82 дугаар зүйлийн "Улсын ба хөдөлмөрчдийн олон түмний бусад бүх байгуулалтын манлайлагч бөгөөд жолоогч Монгол Ардын Хувьсгалт Нам" (Үндсэн хууль, 1998:68) гэсэн онцгой эрх бүхий заалтуудаас татгалзах саналыг Ардын Их Хурлын ээлжит чуулганд оруулах шийдвэр гаргасан байна. Энэ саналыг 1990 оны III сарын 21-нд хуралдсан АИХ-ын II дэх удаатгийн чуулган ёсоор болгосон билээ. Энэ нь нийгмийн улс

II. УЛС ТӨРИЙН АРДЧИЛСАН ШИНЭ ТОГТОЛЦОО ТӨЛӨВШСӨН НЬ

Төлөвшин бүрэлдэж эхэлсэн байна. Оролдох бусад шийдвэр, харин тогтоолууд нь хувьд бүрмөсөн эвдэн өөрчлөх үзэл үзэл Чухам энэ үеэс Монгол оронд социализмыг өөрийнх нь хүрээнд шинэчлэх гэж эхэлсэн хэвлэл, бидэнд бас ч ардчилсан өв уламжлал байсны нэгэн илрэл байлаа. Монголчууд ардчилсан нийгэм бол нийтээр зөвшилтийн нийгэм гэдгийг ухаарч тайван ухаалаг замыг сонгон, цус асаруулахаас зайлсхийж чадсан юм. Энэ нь монхотгож, хүлээлгэвчээр, зөвшил, нигүүлсэл бүхий хандсан учраас эрс шинэчлэлийн баримталж, тэмцэл оролцох "Монгол хүлээж" -ийг эрхэлсэн, сэтгэлийн дотроогоос үеийн эрх баригчид "хэрхэн хүч хэрэглэж болохгүй" (Батмөнх, 2001) хэмээх зарчмыг тэмцлийн давалгаа түүлдээ хүртэл хуралдсан хаврын "халуун" өдрүүдэд тухайн өөрчлөх практик үйл ажиллагааны эхэллийг тавьсан билээ. Ингэж улс төрийн Төгөөд бүрэлдэхүүнээрээ өнгөрч, нийгмийн улс төрийн тогтолцоо шинэчлэн төрийн өгсгөлөн зогссон юм. Үүний үр дүнд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн байж хамтран ажилласны аяар хоёр талаас хүлээн зөвшөөрсөн шийдлийг олж, улс эхлээд төрийн ширээнд суусан билээ. Ингэж харилцан зөвшилцөж, хүлээлгэвчээр байдал хүндэрсэн ийм үед эрх баригч МАХН асуудалд үнэн хатаан хандаж, шаартгалуудыг дахин гэгшүүлэн тавьсан нь төр, түмнийг погчирдуулав. Нөхцөл төрийн шинэ хүчний төлөөлөгчид оролцсон улс төрийн өгсгөлөн эхэлж, дээр дурьдсан сонгож авсан юм. 1990 оны III сарын 7-нд 14 цагаас Сүхбаатарын талбайд улс тэмцлийн дараатгийн шатны хүрч хэлдэр болох улс төрийн өгсгөлөн зарлах замыг эрх баригчид хангалттай харуу өгөлтэй, алмагирч төлөж, бүлээрүүлж байсан учраас нам, төрийн үүргийг зааглах зэрэг шаардлагыг тавьж байлаа. Гэтэл эдгээр шаардлагад Онц их хүрэм зарлан хуралдуулж, Намын үлсрэх бүрэлдэхүүнийг сэргэн өөрчлөх, ултаар нь бий болгох, ардчилсан үндсэн дээр сонгууль явуулах, эрх баригч-МАХН-НАМН тогтолцоо төлөвшүүлэх, хүний эрхийг дээдэлж, парламентат сэтгэл жинхэнэ

төрийн шинэ ардчилсан тогтолцоог бүрэлдүүлэн төлөвшүүлэх өргөн бололцоог нээж өгсөн юм.

БНМАУ-ын АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн IX чуулган (1990) БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийг баталж мөрдүүлэв. Эл нэмэлтийн хуулинд нам, төрийн эрх үүргийг зааглах, улс төрийн тогтолцооны гол цөм нь төр байх, түүний чиг үүргийг бүх талаар өндөржүүлж, эрх хэмжээг өргөтгөх, цааз эрхэмжийн үүрэг ролийг хүчтэй болгох, парламентын нэгдмэл ардчилсан тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, ардчиллын тулгуур зарчмыг өдөр тутмын хэрэгцээ болгон төлөвшүүлэх заалт орсон юм. Үүнийг шийдвэрлэхдээ БНМАУ-ын Ардын Их Хурлаас гадна байнгын ажиллагаатай парламент-БНМАУ-ын Бага хурал хийгээд төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институтийг бий болгож, тэдгээрийн хооронд эрх мэдлийн харилцан хамаарал, түүнийг зөв тэнцэлтэй хуваарилах явдлыг гол болгосон бөлгөө.

Улмаар тус чуулганаар “Улс төрийн намуудын тухай” Монгол улсын хуулийг батлан гаргасанаар олон намын тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлж чадсан юм. Чингэснээр МАХН болон шинэ залуу улс төрийн хүчнүүд 1990 оны V сард улсын бүртгэлд бүртгүүлж, Монгол Улсын хэмжээнд албан ёсоор улс төрийн үйл ажиллагаа явуулах хууль ёсны субъект болсон байна.

Ардын Их Хурлын IX чуулганаас олон намын тогтолцооны үндсэн дээр бүх нийтийн чөлөөт, ардчилсан сонгууль явуулах шийдвэр гаргав. 1990 оны III сард болсон анхны чөлөөт ардчилсан сонгуулиар улс төрийн намуудаас нэр дэвшүүлсэн санал хураалтанд МАХН нийт сонгогчдын 61,7 хувь, МоАН 24,3 хувь, МСДН 5 хувь, МҮДН 5,9 хувь, МНН 1,2 хувь, ЧХН 1,3 хувийн дэмжлэгийг хүлээжээ. (Ж.Болдбаатар нарын эрхэлсэн. 1999:146).

1990-1992 оны шилжилтийн зурвас үед Монголын парламент нь Ардын Их Хурал, Улсын Бага Хурал гэсэн хоёр танхимтай байв. АИХ нь Монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн, төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага, харин УБХ улсын хууль тогтоох эрх бүхий анхны байнгын ажиллагаатай парламент байсан гэж хэлж болно. Улсын Бага Хурал нь тус улс дахь эрх зүйн шинэчлэлийн эхийг тавьж, Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулж хэлэлцэн, улмаар Ардын Их хуралд оруулж ахархан хугацаанд их зүйл амжуулсан юм.

1990-1992 оны шилжилтийн зурвас үед Засгийн газрыг эрх баригч болон сөрөг намуудын оролцоотойгоор хамтаараа хариуцлага хүлээх танхимын зарчмаар байгуулан ажиллуулжээ. МАХН энэ сонгуульд ялсан боловч, улс төрийн шинэ залуу өрсөлдөгчдийнхөө төлөвшил, хөгжлийг хөхүүлэн дэмжиж, эвслийн Засгийн газар байгуулан, хууль тогтоох дээд байгууллага, бүх шатны төрийн захиргааны байгууллагад олон намын төлөөлөлийг анх удаа бий болгосон байна. Зарим судлаачид үүнийг “хэлэлцээрийн ардчилал” хэмээн томъёолсон байдаг.

БНМАУ-ын Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн II хуралдаан нийт 76 хоног хуралдаж, 1992 оны I сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн Хууль бол ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг гүнзгий тусгасан хууль болсон юм. Энэ мөчлөгөөс эхлэн, манай иргэд үйл үйлдэл, зам мөрөө шинэ Үндсэн хуулийнхаа зүйл, заалт бүрийн шалгуураар хэмжиж цэгнэх эрхэм үүрэг хүлээсэн бөлгөө.

Манай орон ардчилсан сонголт хийсний улс төрийн гол илэрхийлэл бол Монгол улс шинэ Үндсэн хуулийнхаа дагуу төрийн бүтэц, үйл ажиллагааны хувьд парламентын Бүгд Найрамдах Улс хэмээх олон улсын жишигт шилжиж, төрийн шинэ тогтолцоог бүрдүүлсэн явдал юм.

Улиран өнгөрсөн жилүүдэд УИХ-ын чөлөөт ардчилсан сонгууль дөрвөн удаа болж, парламентын тогтолцоог шинээр бүрдүүлж ирэв. 1992, 2000 онд МАХН үнэмлэхгүй олонхийн, 1996 онд “Ардчилсан холбоо” эвсэл олонхийн суудал авч, парламентын эрх баригч нам болсон юм. Эдгээр намууд тухай бүр дангаараа Засгийн газрыг бүрдүүлж, парламент нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлж байв. 2000 онд шинээр бүрэлдсэн Монгол улсын парламент улс орныхоо шинэ зууны гарааг нэр төртэй эхлүүлэх онцгой хариуцлагатай бөгөөд ховорхон аз завшаантай үүргийг өөртөө хүлээж багагүй зүйлийг амжуулсан билээ. Харин 2004 оны УИХ-ын сонгуульд МАХН, “Эх орон-ардчилал” эвсэл тэнцүү санал авч, их эвслийн Засгийн газрыг бүрдүүлэв. Энэ үеийн онцлог бол парламентын намууд улс орны амьдралын амин чухал асуудлыг зөвшилцлийн замаар шийдэж эхэлсэн явдал юм.

Ардчилсан парламентад ёсны төлөвшил хөгжлийн явцад шинэ Үндсэн хуулийн дагуу төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх бүрдлийн тухай хуулиудыг баталж, тэдгээрийн дагуу уг бүтцүүдийг шинээр бий болгож, хэвийн ажиллах нөхцлийг нь хангажээ. Түүнчлэн нийслэл, орон нутаг, хот тосгоны эрх зүйн байдлыг хуульчлан тогтоосноор төрийн удирдлагыг орон нутгийн өөрөө удирдах ёстой шүтэлцүүлэн барилдуулж, шинээр зохион байгуулсан юм. Эдүгээ төвлөрлийг аль болохоор сааруулж, орон нутгийн удирдлагын эрхийг өргөтгөх, өөрөө удирдах ёсны байгууллагуудыг бэхжүүлэх эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх шаардлага тулгарч байна.

УИХ зах зээлийн эдийн засгийн эрх зүйн үндсийг тодорхойлсон нэн шаардлагатай хуулиудыг батлан гаргаж хэрэгжүүлж байна. Түүнчлэн төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхийн байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан болон нийгмийн хүрээ, хүн амын нийгмийн хамгаалалттай холбоотой хууль тогтоомж, хүний эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн үндсийг тодорхойлсон хуулиуд гаргаж, амьдралаар урган гарсан шинэ шинэ харилцааг нэмэлт, өөрчлөлт оруулан зохицуулсаар байна.

Гэвч хууль тогтоох ажлыг улам боловсронгуй болгож, парламентын засаглалын нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах талаар их зүйл хийх шаардлагатай байна.

Үндсэн хуулиар төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институт бий болсноос хойш гурван удаа Ерөнхийлөгчөө бүх ард түмнээр сонголоо. Монгол улсын анхны Ерөнхийлөгчөөр П.Очирбат, сүүлчийн хоёр удаа Н.Багабанди сонгогдон ажиллаж байна. Үндсэн хууль ёсоор Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн. Ерөнхийлөгчийн институт биежин цэгцэрч, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь тус дөхөм үзүүлж байна.

Ардчилсан хөгжлийн 15 жилд манай оронд болсон Ерөнхийлөгчийн болон парламентын, түүнчлэн орон нутгийн сонгуулийн явц, үр дүнг цэгнэн үзвэл, манай иргэдэд улс төрийн соёл эерэгээр төлөвшиж, сонгох, сонгогдох, саналаа өгөх хариуцлага өсч, бусдаас хараат бус бие даасан сонголт хийх талаар харьцангуй хангалттай хийгээд хүрэлцэхүйц дадал, чалвар, туршлага суусан гэж хэлж болохоор байна. Харин сонгуулийн тогтолцооны талаар улс төрчдийн дунд харилцан адилгүй үзэл бодол бий.

Ардчилсан өөрчлөлт, шинэчлэлийг түргэтгэхэд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж байна. Шүүх эрх мэдлийн хэнээс ч хараат бус, бие даасан байдлыг хангах талаар зарим алхмууд хийгдэж байна. Эрүүгийн нөхцөл байдал хүндрэх хандлага бүхий нөхцөлд цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа өргөжиж байгаа нь ардчиллын нэг ололт юм.

Тус улсад анх удаа бий болсон Үндсэн хуулийн цэц хэмээх Үндсэн хуулийн дээд хяналтыг хэрэгжүүлдэг байгууллага парламентаас баталсан цөөн биш хуулийн зүйл заалт, Үндсэн хуулийн заалттай зөрчилдөж байна хэмээсэн дүгнэлт гаргаж, УИХ Үндсэн хуулийг өөрийнхөөрөө ойлгож, бүхнийг дангаараа шийдвэрлэх эрхтэй цорын ганц байгууллага биш юм шүү гэдгийг анхааруулж өглөө

Өдгөө манай улсад улсын бүртгэлтэй 20 шахам нам байна. Тэднээс МАХН, МоАН, МАШСН, Бүгд Найрамдах нам парламентад суудалтай байна. Харин МАХН, “Эх орон-ардчилал” эвсэл УИХ-д бүлгээ байгуулж, зөвшилцөл тэдний хооронд явагдаж байна. Олон түмэн эдгээр нам, эвслийн зөвшилцлийг одоохондоо албан тушаалын “хуйвалдаан” төдийгөөс хэтрэхгүй байна хэмээн шүүмжлэн ярилцаж буй нь нууц биш юм. Гэвч Их эвслийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэрхэн хэрэгжихээс л үнэн зөв дүгнэлт гарах буй заа. Манай улс төрийн намууд үзэл номлолын хувьд бүгд үндэсний ардчилсан чиг шугам барьж, харин үзэл баримтлалаа хэрэгжүүлэх арга, хэлбэрээрээ хоорондоо зөрөлдөөнтэй байна. Намууд шинээр байгуулагдах, салж, нийлэх, эвсэх үйл явц үргэлжилсээр буй. Намуудын хөгжлийн хандлагаас үзвэл Монгол оронд хоёр намын систем тогтох хандлага бүхий байна.

Ардчилсан тогтолцоонд хамгийн гол гогцоо нэгэн зүйл бол иргэдийн нийгмийн идэвхитэй байх суурь төлөвшүүлэх асуудал юм. Үүний нэг тод илэрхийлэл бол төрийн бус байгууллагууд “манангийн дараахь мөөг шиг” олон зуугаар байгуулагдаж байгаа явдал юм. 2004 оны эхний хагасын байдлаар 3400 гаруй төрийн бус байгууллагууд бүртгэгдээд байна. Энэ нь манай улсын 700 гаруй хүн тутамд ТББ нэг байгууллага оногдож байна гэсэн үг юм. Эл байгууллагууд иргэдэд зорин тэмүүлж буй нийгмийнхээ мөн чанар, утга учрыг сайтар ойлгуулж, ардчилсан өөрчлөлт, шинэчлэлийн үйлсэд оролцох илүү ухамсартай сонголт, илүү бүтээлч чанарыг төлөвшүүлж байгаагаараа онцлог бөлгөө.

Иргэдийн нийгмийн идэвхийн нөгөө нэг илрэл нь хэвлэн нийтлэх эрхээ бүрэн дүүрэн эдэлж, хэрэгжүүлж буй байдал юм. Эдүгээ манайд албан ёсны бүртгэлд 1150 орчим сонин, сэтгүүл хэвлэгдэхээр бүртгэгдээд байна. Хэвлэл мэдээллийнхэн хий дэмий хэл амаа билүүдэж, тагнай ташиж шуугиан дэгдээх биш, үнэн магадыг олоогүй хуурмаг сэжигтэй зүйлийг баалан шүүмжилж, ард иргэдэд ардчилсан шинэ сонголтын учир утгыг ойлгуулах, сурталчилахад соргог мэдрэмжтэй байж, үнэтэй санаа, оноогоо түгээж чалаж байвал сая “дөрөв дэх засаглал”-ынхаа үүргийг гүйцэтгэж, иргэний нийгэм ардчилалын үйлсэд нэмэр хандиваа оруулах болно.

Өнөөгийн Монголын улс төрийн тогтолцооны хөгжлийн хандлага нь эрх зүйт төр, сайн засаглал тогтоох, иргэний нийгмийн байгууллагуудын тогтолцоог бий болгох, ард иргэдэд нийгмийн идэвхитэй байр суурь, улс төрийн ухамсар төлөвшүүлэх хандлага бүхий байна.

III. МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГО, ГАДААД ОРЧИН

Монгол орон ардчилал, зах зээлд хөл тавимагц төр засаг, улс төр, эдийн засаг, бизнес, хүмүүнлэгийн хүрээнд орон зайгаа тэлэх шаардлага зүй ёсоор урган гарчээ. Хүйтэн дайн, өрнө-дорины сөргөлдөөн төгсгөл болж, олон улсын харилцаа шинэ агуулгаар хөгжих таатай орчин ч бүрдэв. Ийм нөхцөлд Монгол улс нээлттэй, олон түшигт гадаад бодлого явуулах болжээ. Ийнхүү дэлхий дахин “Монголыг нээх”, “Монгол өөрөө дэлхийг нээх” үйл явц эхэлж, шинэ орчноо танин мэдэх түүндээ зохицсон ухаалаг бодлого, шинэ түншлэл бий болгох шаардлага тулгарчээ.

Шинэ эрин цагийн Монгол улсын гадаад бодлогын гол чиглэл нь 1994 онд УИХ-аар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д тов тодорхой тусгагдсан байна. Эл баримт бичигт: хаяа нийлж, ханын шийр хатгасан хоёр хөрштэйгээ, улмаар дэлхийн бүх улстай найрсаг харилцаатай байхын чухлыг тодорхойлсон байна. Эдүгээ Монгол улс дэлхийн 140 гаруй оронтой дипломат харилцаа тогтоожээ.

Өөрчлөлт, шинэчлэлийн жилүүдэд эн тэргүүнд хоёр их хөрш - Оросын Холбооны Улс, БНХАУ-тай уламжлалт харилцаагаа шинэ агуулга, хэлбэрээр гүнзгийрүүлэн баяжуулах, түншлэлийн шинэ талбар, шинэ гарц хайх, хэрэгжүүлэх чиглэлээр чухал ач холбогдолтой алхмууд хийлээ. Манай гадаад харилцаанд хоёр их хөршөөс гадна АНУ, Япон, БНСУ, Герман болон Баруун Европын орнууд тэргүүлэх байр эзэлж байна. Эдгээр орнуудад болон манай улсад хийсэн төр, засгийн дээд хэмжээний айлчлалууд нь Монгол улсын нэр хүнд олон улсын тавцан дээр ихээхэн өсч, манай орон олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгийг хүлээж байгаагийн илэрхийлэл болж байна.

Шинэ сонголтын жилүүдэд манайхыг дэмжигч, хандивлагч орнууд болон олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудын бүхэл бүтэн бүлэг бүрэлджээ. Гол нь хандивлагчдынхаа итгэлийг дааж, өглөг буяныг нь “чулуу болгох” хэрэгтэй юм. Манай улсын ардчилсан ололтыг дэмжин тусалж хамтран ажиллаж буй, хүнд бэрх цагт сэтгэл харамгүй гараа сунгасан бүх улс орон, олон улсын байгууллагуудад бидний монголчууд талархах ёстой.

Улс орон, угсаатан үндэстнүүдийн соёл иргэншлийн харилцан нэвчилт, найрсаг зохицлын их давалгаан, хүчирхэг түрэлт нь XXI зууны олон улсын харилцааны өнгө төрхийг тодорхойлох болно. Үүнийг бид “даяаршил” хэмээн томъёолох болов.

Бидний монголчууд нийгэм-түүхийн бодит шалтгаанаар хөллөсөн жам ёсны үзэгдэл-даяаршилд нийлэн нэгдэж, хүн төрөлхтний бүтээсэн, бүтээх гайхамшгийн сор дээжээс охьлон хүртэх ёстой. Тэгэж байж сая бид хүчтэй, хүчирхэг болно. Хүчтэй байна гэдэг нь дэлхийн шилдэг ололтыг өөртөө шингээнэ гэсэн үг. Бас ингэж адилсахаасаа дутуугүй ондоосох ёстой. “Ондоосно” гэдэг нь уугуул ёс заншил, унаган соёл төрх, үндэсний өвөрмөц байдлаа хадгалах дархлалтай байна гэсэн үг. Миний энд дурьдан буй “ондоосох” хэмээх томъёололыг зарим судлаачид “дангаарших” гэж томъёолжээ. Доктор Н.Багабанди: “Даяаршлыг сондгой байдлаар өрөөсгөлдүүлэн авч үзэх, хандах нь арга зүйн хувьд алдаатай байх болно. Дангааршилгүй даяаршил байж таарахгүй, даяаршилгүй дангааршил ч оршин тогтнох бололцоогүй. Энэ хоёр үйл явц, тэдгээрийг илэрхийлсэн хос ойлголтууд нь эсрэг тэсрэг байж, бие биеэ үгүйсгэдэг ч нэгдмэл цул болж, бас бие биеэ нөхцөлдүүлнэ. Олон улсын харилцаа, хамтын ажиллагаанд эдгээр ойлголтыг хамтад нь авч хэрэглэснээр асуудалд бодитой, оновчтой хандах зөв байр суурь тогтох болно.” (Багабанди. 2004:47) Ийнхүү даяаршлын нөхцөлд үндэстний хувьд дасаж зохицох үлдэж хоцрох талаар монгол хүн бүр ухаарах хэрэгтэй болж байна.

Ардчилсан өөрчлөлт, шинэчлэлийн өнгөрсөн 15 жил бол нийгмийн хөгжлийн жирийн хэмнэлээр авч үзвэл цар далайцаараа лавтайяа нэгэн жарантай тэнцэх хувьсал, өөрчлөлтийн он жилүүд байлаа. Туулсан замынхаа тоймыг эргэн харахад

монголчууд бид хүн төрөлхтөний соёл иргэншлийн хөгжилд хэр чадлынхаа хэмжээгээр бага боловч түлхэц өгч, тодорхой хувь нэмэр оруулсан гэж хэлж болох байх. Зарим нэг сургамж, онцлог болох зүйлийг базаж дүгнэвэл:

-Нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих чанарын өөр шилжилтийг улс төрийн хүчнүүд хүчирхийлэл, зэвсэгт тэмцлийн замаар бус тайван, ухаалаг зөвшилцлийн аргаар хийж болохыг;

-Улс орондоо улс төрийн болон эдийн засгийн эрс шинэчлэлийг нэгэн хамтад хийх боломжтойг;

-Орчин үеийн дэлхий дахины ардчилалын хэм хэмжээ, сэтгэлгээний сүүлийн үеийн ололтыг тусгасан эрх зүйн цогцолбор шинэчлэл хийх боломжтойг;

-Бага буурай улс орон үндэсний эрх ашгаа дээдэлсэн нээлттэй, олон түшигт, харьцангуй бие даасан талаад бодлого явуулж болохыг нотолж өглөө.

Бидний монголчуудын хөгжлийн энэхүү туршлага, сургамж ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын амьдралд бага боловч дэм болж болох болов уу? хэмээн үүнийг тэмдэглэж байна.

Цаг үе бол түүхийн дуран авай. Цаг үе эзнээ дагуулж ирдэг. Жам ёсоор тийм бүхэл бүтэн шинэ үе өсөн бойжиж, эрийн цээнд хүрч эхэлж байна.

Шинэ зуунд ардчилалыг бататгахын төлөө тал талаасаа хамтран зүтгэх нь иргэний нийгэм рүү дөхөх, урагшлах гол хүчин зүйл мөн. Ардчилал Монгол руу ирж байна. (Kaplonski. 2004:48) Монголчууд ч ардчилал руу тэмүүлж байна. Энэ нь монголын нийгмийн өдгөөгийн улс төрийн амьдралын содон шинж тэмдэг болж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛГ

- Багабаади.Н. (2004) Шинэ зуун: Даяаршин дангааршиж, дангааршин даяаршихын учир. УБ.
- Батмөнх. Ж. (2001) "Хүч хэрэглэж хэрхэвч болохгүй" УБ.
- Bawden Ch.R., (1989) *Modern History of Mongolia*, Kegan Paul International. London, New York.
- Болдбаатар.Ж нарын эрхэлсэн (1999) Монгол улсын түүх УБ.
- Горбачёв. М.С. (1988) Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ. Манай оронд болон дэлхий дахинд. УБ.
- Заанхүү.Ж. эмхэтгэсэн (2004). 1990 оны Ардчилсан хөдөлгөөний түүхэнд холбогдох баримт бичгүүд. Тэргүүн дэвтэр. УБ.
- Kaplonski. (2004) *Truth, History And Politics in Mongolia. The memory of heroes*. Rutgers Cufzon. Taylor and Francis Group. London and New York.
- (1998) Монгол Улсын Үндсэн хуулиуд, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд. (1924-1992). УБ.
- (1988). МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал. УБ.
- Элбэгдорж.Ц. (1999). Үнэний цагаан мөр. УБ.

ҮНДСЭН ХУУЛЬТ ЁСНЫ ХӨГЖИЛ, ОНЦЛОГ

*Монгол Улсын гавьяат хуульч, Хууль зүйн
ухааны доктор, профессор Н.Жавцан*

Үндсэн хуульт ёсны үүсэл хөгжил нь дэлхийг дахинд 200 гаруй жилийн түүхтэй асуудал юм. XVIII зууны сүүлчээр Ардчилалын чухал институт болох Үндсэн хууль хэмээх ойлголт бий болж 1787 онд АНУ-д, 1791 онд Францад, 1793 онд Польшид Үндсэн хууль батлагдснаас хойш эдүгээ бараг дэлхийн бүх улсад дэлгэрээл байна. Энэ хугацаанд Үндсэн хуулийн тухай олон арван онол сургаал, урсгалууд бий болж байсан боловч Үндсэн хууль бол улсын гол хууль хэмээх ойлголтоос хазайж байсан нь үндсэндээ үгүй. Дэлхийн олон оронд Үндсэн хуульд ёс дэлгэрэн хөгжсөн явдал Монгол Улсад нөлөөлсөн бөгөөд бие даасан хуультай болох үзэл санаа манай оронд 1921 оны ардын хувьсгалын дараагаар эхэлсэн болох нь түүхэн баримтуудаар нотлогдож байна. 1921 оны намар анхны Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажил эхэлсэн байна.

Гэхдээ Монгол Улсад Үндсэн хуульд ёс дэлгэрсэн түүхийг 1924 оны Үндсэн хууль баталсан цаг үеэс эхлэх нь зүйд нийцэх юм. Монгол Улсад эзэн Чингисийн их засаг зэрэг үндсэн хуулийн дайтай том хуулиуд үйлчилж байсан боловч тэдгээрийг Үндсэн хууль гэж үзэх боломжгүй бөгөөд Үндсэн хууль хэмээх хүн төрөлхтний сонгодог ойлголт нь шинж төлөв, хамрах хүрээ, хүчин чадлын хувьд харьцангуй тогтсон ойлголт юм.

Үндсэн хууль бол түгээмэл шинжээрээ төр, нийгмийн үндсэн харилцааг зохицуулагч, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан, хуулийн дээд хүчин чадал бүхий эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт мөн. Зарим орны эрдэмтэд Үндсэн хуулийг дээдлэх, чандлан сахих агуулгын үүднээс Үндсэн хуульд ёсны тухай ярьж, бичих болсон байна.

Үндсэн хуульд ёсны тухай асуудал манай улсын Хууль зүйн шинжлэх ухаанд харьцангуй шинэ ойлголт, Үндсэн хууль судлалын эрдэмтэд, судлаачид энэ нэр томъёог өөрсдийн зохиол бүтээлд тун цөөн хэрэглэсэн байна¹.

Америкийн Нэгдсэн Улсын Вирджини их сургуулийн профессор А.Е.Дик Ховард өөрийн бүтээлдээ үндсэн хуульд ёс /конституционализм/ хэмээх ойлголтыг

¹ Т.Сэнгэдорж. Дэлхийн улсуудын үндсэн хуульд ёсны хөгжил, мөн чанар, онцлог. Шинэ тал, 1999, №28
В Улст. Удирдлагын эрх зүй. УБ, 1999, 23 дахь тал

Түүнийг Монгол Улсын шинэ Улсын хуулиар үндсэн хууль ёсыг хэвшүүлэх, хууль ёсны төлөвшилийг охинолгоо болгон ажлаар хэрэгжүүлэх чиглэл хийсэн нэг чухал алхам бол Улсын хуулийн ёсыг даасан

дээрх зарчмыг бүхэлд нь эргэж эхлүүлж, улс төр, эдийн засаг, гэрээ, хууль ёсны төлөвшилийг чухал хэмжээг нь болгон зарчмын шинж төлөвгүй үндсэн хууль ёсны төлөвшилийг чухал хэмжээг нь болгон багцаагаар авч үзжээ, улс төр, эдийн засаг, гэрээ, хууль ёсны төлөвшилийг чухал хэмжээг нь болгон

Төрийн арга барил, албан тушаалтан хуулийн үйлдлийг баримдах нь хууль ёсыг даасан хууль ёсны байх ёстой. Зарим гэж үзжээ болох бөгөөд юуны өмнө эрх зүйн бүх акт, шийдвэр зэрэг хууль ёсоор баримтлахын нэгдсэн хууль ёсны боллоо. Улсын хууль ёсны нэг гол мөн чанар бол хууль ёсыг даасан. Энэ хуулиар хууль ёсыг даасан ахуйн тухай зарчмыг анхлан тунхагласан явдал эрх зүйн төрийн үзэл

1992 оны Улсын хуулийг үндсэн хууль ёсны хөгжил, дэвшилийн шинэ үе шат гэж үзжээ төлөвшүүлэхэд голрохон хувь нэмрээ оруулсан байна. Монгол Улсад үйлчилж ирсэн дээрх үндсэн хуулийн аль аль нь Монгол Улсын

төрийн механизмд бүрдүүлж чадсан үндсэн хууль болсон. Монгол Улсад үйлчилж ирсэн дээрх үндсэн хуулийн аль аль нь Монгол Улсын төрийн механизмд бүрдүүлж чадсан үндсэн хууль болсон.

1992 онд батлагдсан шинэ Улсын хууль бол дэлхийн ардчилсан үндсэн хуулийн хэвдэр хангах зорилгыг дор нэг намьд үзэл суртлын ноёрхлыг баталгаажуулсан хууль болсон.

1940, 1960 оны Улсын хууль бол нийгэм журм байгуулах, социализмыг бүрэн ялалтыг гавьяа гэж үзжээ болно.

1924 оны Улсын хууль бол Бүтэл Найрамдах Улсыг тунхаглаж түүний үндэс суурийг бэхжүүлсэн, колоничлолын тогтоолоог татгалдан орсон Азийн орнуудаас бараг хамгийн

Улсын хууль боловч тэдгээрийн дэвшилийг зоригтой зарчмын алтанууд байдал. Монгол Улсын 1924, 1940, 1960 оны Улсын хуулиуд нь бүхэлдээ социалист хэв маягийн

зэрэг үндсэн асуудлыг түүнд тусгасан байна. Хэвлэлтэй байдал хуульчлагдсан байна, засаглалын эрх мэдэл хуваарилагдсан байх хүрээнд хягаарлагдсан байна, нийгэм бол өөрөө өөрөө хуульчлагдсан байна, хуульчлагдсан байна, засаглалын эрх хэмжээ хуулийн ард түмний хүсэл эрмэлзэл тэнд туссан байна, засаглалын эрх хэмжээ хуулийн голрохонд Улсын хууль бол ард түмнээр зөвшөөрөгдсөн байна, өөрөөр хэлбэл нилээд өргөн хүрээтэй авч үзсэн байдал. Тухайгаар, Улсын хууль ёсны

шүүх буюу Үндсэн хуулийн цэцийг олон улсын жишигт нийцүүлэн байгуулсан явдал юм. Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээнд хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуулинд нийцэж байгаа эсэх, мөн Ерөнхийлөгч, Улсын их хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Упсын Ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянах асуудал тусгагдсан нь хууль дээдлэх зарчмын тусгал, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байхын илэрхийлэл хэмээн үзэж болно. Үндсэн хуулийн эл заалт Үндсэн хуульт ёсны төлөвшилд хосгүй хувь нэмэр болох нь дамжиггүй. Дэлхийн олон оронд өнөөдөр Үндсэн хуулийн шүүхийг ардчилсан ёсны чухал ололт хэмээн үзэж байна.

Үндсэн хуульт ёсны хүн төрөлхтний түүхийн явцад албан тушаалтнууд Үндсэн хуулийг зөрчих, Үндсэн хуульд заасан эрх хэмжээгээ хэтрүүлэх явдал олонтаа гарсныг харгалзан Үндсэн хуулийн шүүхийг одоогоос 80 гаруй жилийн өмнө Австри улсад байгуулснаас хойш эдүгээ дэлхийн олон оронд Үндсэн хуулийн энэ институтын эрх хэмжээг хүлээн зөвшөөрөөд байна. Зарим судлаачид XX зуун бол парламентын зуун байсан бол XXI зуун Үндсэн хуулийн шүүхийн зуун болно хэмээн тодорхойлж байна.

Монгол Улсын Шинэ Үндсэн хууль нь хүчин чадал, хамрах хүрээ, ардчилсан шинжээрээ дэлхий нийтийн өнөөгийн төвшинд хүрсэн хууль болсон төдийгүй Монголын нийгмийн өнөөгийн онцлог, хөгжлийн төвшинд нийцэж байгаа хэмээн өгүүлэгч би бээр үзэж байгаа юм. Энэ нь Үндсэн хуульд өөрчлөлт шинэчлэл хийх шаардлагагүй хэмээсэн үг биш бөгөөд Үндсэн хуульд өөрчлөлт хийх тохиолдолд аль нэг улс төрийн зүтгэлтэн, улс төрийн намын явцуу сонирхлын үүднээс биш улс орны хөгжлийн чиг хандлагыг харсан гарцаагүй чухал өөрчлөлтийг хийж болох юм.

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

Хууль зүйн ухааны магистр Ц.Цэцэгэ

2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлд “хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгийг ашиглах” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг анх удаа хуульчилсан нь хуульч, эрдэмтэд, судлаачдын дунд дээрх гэмт хэрэг нь олон улсын шинжтэй мөнгө угаах гэмт хэрэг мөн эсэх талаар маргаан дэгдэхэд хүргэсэн билээ.

Тухайлбал: Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан. Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлийг тайлбарлахдаа... мөнгө угаах нь гадаадаас хууль бусаар орж ирсэн мөнгө, хөрөнгийг ашиглан хууль бус наймаа хийх хэлбэртэй байна¹ гэж үзэж байхад Хууль зүйн ухааны доктор /ph/ Д.Зүмбэрэлхам мөнгө угаах гэмт хэргийг манай эрүүгийн хуульд хараахан тусгаагүй байна² гэж үзсэн байх жишээтэй.

Бид хуульчид, эрдэмтэн, судлаачид нар оролцсон 100 хүнээс авсан санал асуулгаар тэдний 57 хувь нь Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлийг мөнгө угаах гэмт хэрэг мөн гэж, 28 хувь нь мөнгө угаах гэмт хэрэг биш, манай эрүүгийн хуульд тусгагдаагүй, бусад нь хариулж мэдэхгүй байна гэснээс үзэхэд манай ихэнхи хуульчид, эрдэмтэн, судлаачид “мөнгө угаах” гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлд тусгагдсан гэж үздэг нь харагдаж байна. Тэгвэл Монгол Улсын эрүүгийн хуульд тусгагдсан эсэх дээр маргалдаад байгаа “мөнгө угаах” гэмт хэргийн үүсэл, хөгжил, мөн чанар, олон улсын гэрээ хэлэлцээр, хийж буй тэмцлийн талаар товчхон авч үзье.

“Гэмт үйл ажиллагаанаас олсон орлогыг угаах, илрүүлэх, хураах тухай” Страсбургийн конвенц 1990 онд батлагдаж оролцогч орнууд бохир мөнгө цэвэршүүлэхийг гэмт хэрэгт тооцох, хууль бусаар олж авсан эд хөрөнгийг эрэн сурвалжилж олж авах, хураах журмын тухай, банкны ажилтан нараас үйлчлүүлэгчдийн мөнгөн хадгаламжийн талаархи мэдээллийг задруулахтай холбогдсон хориг, хязгаарлалтыг хүчингүй болгож, эдгээр гэмт хэргүүдийг цаг тухайд нь илрүүлэх бололцоо олгох, банкны ажиллагаатай танилцах, хуулийн байгууллагын ажилтануудын эрхийг бэхжүүлэх үүрэг хүлээжээ³.

¹ С. Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /тусгай анги/, 183-р тал

² Д. Зүмбэрэлхам. “Мөнгө угаах гэмт хэрэг ба түүний мөн чанар” Гэмт илгээлтэй гэмтэх асуудал оюул, арха зүйн сэтгүүл, 2002 он, № 1

³ В.П. Павлов. Международное уголовное право, 1997г, с. 102

Дараа нь 1988 онд НҮБ-аас батлан гаргасан “Мансууруулах болон сэтгэхүйд нөлөөлөх бодисийг тээвэрлэхийн эсрэг” Венийн Конвенц, Италийн Курмайер хотноо 1994 онд НҮБ-с зохион байгуулсан “Гэмт үйл ажиллагаанаас олсон орлогыг ашиглах, мөнгө угааж цэвэршүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудлаархи Олон улсын бага хурлаас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол гаргажээ. 1989 онд Их долоогийн уулзалтаас “Мөнгө угаахын эсрэг санхүүгийн аргаар тэмцэх олон улсын байгууллагын 40 зөвлөмж” /FATF/ нэртэй баримт бичиг гаргасан нь одоогоор тухайн гэмт хэрэгтэй тэмцэхэд хэрэглэгдэж байгаа олон улсын шинжтэй гол баримт бичиг болоод байгаа юм⁴.

1990 онд 26 улс нэгдэж “Мөнгө угаахын эсрэг санхүүгийн аргаар тэмцэх олон улсын байгууллагыг” үүсгэн байгуулсан бөгөөд тус байгууллага нь хууль бус аргаар орлого олох гэмт үйл ажиллагааг таслан зогсоох, эдийн засгийн хууль ёсны шударга ажиллагаанд тэлгээрээс нөлөөлөх явдлаас урьдчилан сэргийлэхэд бодлогоо чиглүүлдэг. Тус байгууллагаас гаргасан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх 40 зөвлөмж нэртэй баримт бичиг нь хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн систем ба түүний зохицуулалт, эрүүгийн хариуцлага, олон улсын хамтын ажиллагаа зэрэг өргөн хүрээг хамарсан ба бүх орнууд нэгдэн ороход нээлттэй, түгээмэл шинжтэй бөгөөд энэ баримт бичигт:

- Улс орон бүр Венийн конвенцийн дагуу мөнгө угаах ажиллагааг гэмт хэрэг гэж хуульчлах
- Угааж буй орлого, түүнд ашигласан ба ашиглахыг завдсан аливаа хөрөнгө ба түүнтэй тэнцэх хэмжээний мөнгийг хууль зөрчөөгүй гуравдагч талын эрх ашгийг хохироолгүйгээр хураан авч байх
- Эрх бүхий байгууллагаас мэдээлэл хүссэн тохиолдолд шуурхай хариу өгөх зорилгоор дотоод ба гадаад гүйлгээний сүүлийн тавиаас доошгүй жилийн бүх бүртгэлийг санхүүгийн байгууллагад халгалж байх
- Хэрэв санхүүгийн байгууллагууд гүйлгээнд орсон мөнгийг гэмт хэргийн шинжтэй гэж сэжиглэвэл эрх бүхий байгууллагад энэ талаар нэн даруй мэдэгдэж байх зэрэг зохицуулалтыг тусгасан байдаг.

“Money laundering” буюу мөнгө угаах гэдэг нэр томьёо Америкаас гаралтай бөгөөд мөнгө угаах гэж гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах болон түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль ёсны болгох үйлдлийг ойлгоно. Мөнгө угаах гэмт хэрэг нь хар мөнгө, бохир мөнгө болон

⁴Д. Эрбэрхдсгэм. “Мөнгө угаах гэмт хэрэг ба түүний мөнгө чөлөөт” Гол явцтай тэмцэх асуудал олох, ард дүйн сэтгүүл, 2002 он, № 1

гэмт хэргийн замаар олсон орлого, эд зүйлийг хууль ёсны эх сурвалжтай болгох үйлдэл бөгөөд хар мөнгө /black money/ гэдэг нь гэмт хэргийн замаар биш боловч тодорхой дүрэм журмаас гажиж олсон орлого, мөн татвар төлөөгүй орлого хамаардаг, эх сурвалж нь ноцтой биш боловч албан ёсны эдийн засагт бүртгэлгүй мөнгийг хэлдэг.

Харин бохир мөнгө /dirty money/ гэдэг нь жинхэнэ хууль бус буюу захиалгат аллага, зэвсгийн хориотой наймаа, хүний наймаа, хүний эд эрхтэний наймаа, далайлган сүрдүүлэлт, хээл хахууль, мансууруулах бодисын наймаа гэх мэт ноцтой гэмт хэрэг үйлдэх замаар олж авсан, хуримтлуулсан орлого юм.

Энгийнээр хэлбэл дээр дурьдагдсан хар болон бохир мөнгийг “цагаан” /white/ буюу “цэвэр” /clear/ болгох ажиллагааг мөнгө угаах гэх бөгөөд хууль бус эх сурвалж буюу орлогыг хууль бусаар ашигласнаа нууж дараа нь эдгээр орлогыг хууль ёсоор олсон мэт болгон хувиргах ажиллагааг мөнгө угаах гэж тодорхойлж болох юм.

Мөнгө угаах ажиллагаа 3 үе шаттайгаар явагддаг ба эхний үе шатанд хар болон бохир мөнгийг бохир бизнест оруулаа, дараагийн үе шатанд тодорхой үйлдэл хийсний дараа уг мөнгөний анхны эх сурвалж бүдгэрч танигдахгүй болох ба ул мөр нь арилаа. Харин 3 дахь шатанд уг мөнгө шинээр хууль ёсны эх сурвалжтай болдог бөгөөд мөнгө угаах олон арга хэлбэрүүд байдгаас дурьдвал :

1. Банкны салбарт мөнгө угаах явдал юм. Банк нь мөнгө угаах хамгийн багтаамж ихтэй, өртөмтгий салбарт тооцогддог ба банкаар дамжуулан мөнгө угаахад бохир мөнгөтэй этгээд банкинд олон данс нээх, эсвэл их биш мөнгөний дүнтэй гүйлгээг олон дахин хийх аргыг ихэвчлэн хэрэглэдэг. Ингэж мөнгөө багасгаж хуваарилах нь сэжиг бүхий их хэмжээний гүйлгээг банкны байгууллага шалгаж болох эрсдэлээс урьтчилан сэргийлэхэд оршино.

2. Бизнесийн салбарт мөнгө угаах явдал ч амьдралд цөөнгүй тохиолддог бөгөөд энэ нь хууль ёсны бизнесийн байгууллагын орлогод бохир мөнгийг цувруулан нийлүүлж холиод дараа нь түүнийгээ орлогын эх сурвалж болгох арга юм. Бас тухайн зорилгоор зориуд аж ахуйн нэгж байгуулаад зөвхөн цаасан дээр нэртэй тэр аж ахуйн нэгжийг зохиомлоор орлогожуулж мөнгөнийхөө өнгийг хувиргах ба дараа нь тухайн нэгжээ татан буулгах, дампууруулах замаар мөнгө угаах явдал байдаг.

3. Хөрөнгийн арилжаагаар дамжуулж мөнгө угаах Машин, байшин, нисдэг тэрэг гэх мэт хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг хямд үнээр худалдаж аваад дараа нь тэдгээрийгээ өндөр үнээр зарж хоорондын зөрүүгээр ашиг олсон хэмээн орлогын татвар төлсөнөөр

мөнгийг цэвэршүүлдэг байна. Үнэн хэрэгтээ бол энэ наймаа нь урьдаас төлөвлөсөн зохион байгуулалттай үйлдэл байдаг ажээ.

4. Гадаадын банкаар дамжуулан мөнгө угаах Бохир мөнгөө ямар нэгэн аргаар хилийн чанадад гарган үйлчлүүлэгчээ нууцалдаг гадаадын банкинд хадгалуулж дараа нь түүнийгээ зээл, туламж, хөрөнгө оруулалтын болон бусад хэлбэрүүдээр өөрийнхөө болон өөр улсруу оруулж хууль ёсны эх сурвалжтай болгох аргыг мөнгө угаагчид нилээд найдвартайд тооцдог байна⁵.

5. Зээлийн хэлбэрээр мөнгө угаах Мөнгө угаагч гадаад оронд тухайн орны иргэний нэр дээр аж ахуйн нэгж байгуулаад дараа нь өөрийнхөө оронд мөн аж ахуйн нэгж байгуулмагц тэрхүү гадаадын байгууллагаас зээл авах нэрээр үнэн хэрэгтээ өөрийнхөө хөрөнгийг оруулж ирдэг. Дараа нь зээлээ төлж байгаа хэлбэрээр мөнгө шилжүүлэх гэх мэтээр бохир мөнгөнийхөө эх сурвалжийг бүдгэрүүлдэг байна.

Энэ бүхнээс харахад “мөнгө угаах” гэмт хэрэг нь дараахь хэлбэрүүдээр илэрдэг гэж дүгнэж болохоор байна.

1. Хууль бусаар олж авсан мөнгийг дахин мөнгө болгох

Жишээ : А гэгч маск зүүж буу барин банкинд орж няравыг буудна гэж сүрдүүлж байгаад 100000 доллар авчээ. Энэ талаар мэдэж байсан В нь уг мөнгийг А-н өмнөөс өөр банкны дансанд хийсэн ба А-н хэрэгцээгээр бага багаар авч түүнд дамжуулж байгаад цагдаагийнханд баригджээ.

2. Хууль бусаар олж авсан мөнгийг бараа болгох

Жишээ : Эрхэлсэн ажилгүй С гэгч нэгэн компаний захирлын 3 настай охиныг А цэцэрлэгээс нь хулгайлан авч утсаар энцэг эхийг нь айлган сүрдүүлж 25000 доллар авсан ба тэр мөнгөөрөө энэ хэргийн талаар мэдэж байсан Б-д автомашин авч өгсөн.

3. Хууль бусаар олж авсан мөнгөний тусламжтайгаар үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх

Мөнгө угаагчид нь голдуу зохион байгуулалттай гэмт хэргийн ертөнцийнхөн байдаг бөгөөд дэлхий дээр хууль бусаар олдог орлогын ихэнх хувийг хар тамхи, мансууруулах бодисын наймаанаас олдог. НҮБ-н мэргэжилтнүүдийн судалгаагаар мансууруулах бодисын наймаа дэлхий даяар жилд дунджаар 500 тэрбум долларын хэмжээнд эргэлддэг гэсэн бол ОХУ-н Төв банкны мэдээгээр ийм замаар жил бүр гэмт хэргийн гаралтай 20 тэрбум ам.доллар Оросоос гадагш гардаг байна⁶.

Мөнгө угаах ажиллагаа нь хуулийн ажилтануудыг төөрөгдүүлэхэд чиглэгдсэн, ойлгоход төвөгтэй олон хэлбэр, хувилбараар үргэлжлэн явагддаг учраас илрүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг.

⁵ Д. Замборачевын “Мөнгө угаах гэмт хэрэг ба түүний мөн чанар” Гэмт явцтай тэмцэх асуудал: онол, арга зүйн сэтгүүл, 2002 он, № 1
⁶ В.П. Павлов. Международное уголовное право, 1997г, с 102

Энэ бүх байдлаас дүгнэж үзэхэд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг “мөнгө угаах” гэмт хэргийн зарим элементийг агуулсан болох нь харагдаж байна. Энэ гэмт хэргийн объект нь аж ахуйн үйл ажиллагаа явуулах талаар хуулиар тогтоосон журам, бусдын эрх ашиг сонирхол байдаг бол халдлагын зүйл нь мөнгө, эд хөрөнгө байна.

Халдлагын зүйлийг хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэж тодорхойлсон нь мөнгө угаах гэмт хэрэг мөн биш гэсэн маргааны үүсгээд байна. Өөрөөр хэлбэл мөнгө угаах гэмт хэрэг нь зөвхөн гэмт хэргийн замаар олсон мөнгө, эд хөрөнгө гэж халдлагын зүйлийг тодорхойлдог байхад дээрх эрүүгийн хуулийн заалт нь халдлагын зүйлийг хэт өргөн хүрээтэй, ойлгомжгүй байдлаар тодорхойлогджээ. Объектив тал нь илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан үйлдэл, эс үйлдэхүй байна. Илт хууль бусаар олж авсан мөнгө эд хөрөнгийг санхүүгийн үйл ажиллагаанд оруулах гэдэгт дээр дурдсан мөнгө эд хөрөнгийг банкинд хадгалах, хадгаламж нээх, бусдын хадгаламжинд шилжүүлэх, төлбөрийн хэрэгсэл болгон ашиглах, эд зүйл, үнэт цаас худалдаж авахыг ойлгоно. Аж ахуйн үйл ажиллагаанд оруулах гэдэг нь хөрөнгө оруулалт хийх, хувьчлалд оролцож үндсэн хөрөнгө худалдан авах, үйлдвэрлэл үйлчилгээ худалдааг хууль бусаар эрхлэхэд ашиглахыг ойлгоно. Хэрэв тухайн олж авсан эд хөрөнгө, мөнгийг хууль бусаар олж авсан гэдгийг тодорхой мэдээгүй, эсвэл хууль бусаар олсон эсэх нь эргэлзээтэй байсан тохиолдолд энэ гэмт хэрэгт тооцохгүй.

Зах зээлийг санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээл гэж ангилж авч үздэг ба санхүүгийн зах зээлд банк банкны үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа хамаарна. Банк нь мөнгө угаах хамгийн багтаамж ихтэй, өртөмтгий салбарт тооцогддог бөгөөд банкаар дамжуулан мөнгө угаахад бохир мөнгөтэй этгээд банкинд олон данс нээх, эсвэл их биш мөнгөний дүнтэй гүйлгээг олон дахин хийх аргыг ихэвчлэн хэрэглэдэг. Ингэж мөнгөө багасгаж хуваарилах нь сэжиг бүхий их хэмжээний гүйлгээг банкны байгууллага шалгаж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хууль ёсны бизнесийн байгууллагын орлогод бохир мөнгийг цувруулан нийтүүлж холиод дараа нь түүнийгээ орлогын эх сурвалж болгох аргыг мөнгө угаагчид хэрэглэдэг. Бас тухайн зорилгоор зориуд аж ахуйн нэгж байгуулаад зөвхөн цаасан дээр нэртэй тэр аж ахуйн нэгжийг зохиомлоор орлогожуулж мөнгөнийхөө өнгийг хувиргах ба дараа нь тухайн нэгжээ татан буулгах, дампууруулах замаар мөнгө угаах явдал байдаг. Хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг учир илт хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсанаар төгссөнд тооцно. Субъектив тал нь шууд

санаатай гол төлөв шунахай сэдэлттэй байх бол субъект нь 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай этгээд байна.

Бохир мөнгө угаах гэмт хэрэг гэж үзэхэд үндсэн 2 шалгуур байдаг ба *нэгдүгээрт*: суурь гэмт хэрэг үйлдэгдсэн байх. Суурь гэмт хэрэг гэж угаах гэж буй мөнгө, гэмт хэргийн замаар бий болсон орлогын эх үүсвэр нь болсон тухайн улсад болон хилийн гадна үйлдэгдсэн гэмт хэргийг ойлгодог. Өөрөөр хэлбэл банк дээрэмдэх нь суурь гэмт хэрэг болох бөгөөд дээрэмдсэн мөнгөө хууль ёсны эх сурвалжтай болгох нь мөнгө угаах гэмт хэрэг болдог. Жишээ нь : ХБНГУ-ын эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийн өмнө захиалгат алага, зэвсгийн хориотой наймаа, хүний наймаа, хүний эд эрхтний наймаа, далайлган сүрдүүлэлт, хээл хахууль, мансууруулах бодисын наймаа, зохион байгуулалттай дээрэм, далайлган сүрдүүлэх зэрэг суурь гэмт хэрэг үйлдэгдсэн байхыг шаарддаг.

Хоёрдугаарт : угааж буй мөнгө, эд хөрөнгө нь зөвхөн гэмт хэргийн замаар олсон орлого байна. Гэмт хэргийн замаар бий болсон орлого гэж татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэгээс бусад гэмт хэргийн улмаас шууд буюу шууд бус хэлбэрээр үүсэн бий болсон аливаа эд хөрөнгө, эдийн засгийн ашгийг ойлгож болно. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн үед уг орлого, мөнгө нь хууль ёсны бизнесийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон байдаг учир гэмт хэргийн замаар олсон орлого гэж үзэхгүй.

Манай Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйлийн бүрэлдэхүүнийг судлан үзэхэд суурь гэмт хэрэг үйлдэгдсэн байхыг шаардаагүй, хууль бусаар олж авсан мөнгө, эд хөрөнгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оруулсан гэж заасан нь гэмт хэргийн замаар олсоноос өөр бусад хууль тогтоомж зөрчиж олсон орлого, мөнгө, эд хөрөнгийг гэж...ойлгохоор байна. Цаашид дэлхийн жишигт нийцүүлэн энэ гэмт хэргийг нэрийг мөнгө угаах гэж өөрчлөх, мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх тухай бие даасан хуулийг УИХ-с батлан гаргах шаардлагатай.

Мөнгө угаах гэмт хэрэг нь зөвхөн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй түүгээр дамжин тухайн улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлэл учруулдаг. Өөрийнхөө нутаг дэвсгэрт мөнгө угаагдах боломж гаргаж өгсөн улс орон юуны өмнө хууль бус ажиллагааныхаа ул мөрийг нуун далдлах бололцоог гэмт этгээдүүдэд олгож байгаа хэрэг бөгөөд дараагийн ээлжинд улс орны санхүүгийн системийн нэгдмэл байдал алдагдаж түүнд мөнгө угаагчид буюу шууд хэлбэл гэмт хэрэгтнүүд

⁷ Д. Зүрбэрэлтсэм. "Мөнгө угаах гэмт хэрэг ба түүний мөн чанар" Гэмт явцтай тэмцэх асуудал оюул, арга зүйн сэтгүүл, 2002 он, № 1

нөлөөгөө тогтоож эхэлсэнээр улс орны эдийн засгийн эрүүл тогтолцоо, түүний найдвартай ажиллах магадлал багасана. Буруу замын хөрөнгө оруулагчид үүдээ нээж өгсөн орноос хууль ёсны хөрөнгө оруулагчид болгоомжилон цэрвэж эхэлдэг нь тэд бохир мөнгө холилдсон эдийн засагтай зах зээлийг найдваргүйд тооцдогтой холбоотой.

Энэ төрлийн гэмт хэрэг нь нуугдмал шинжтэй, илрүүлэхэд бэрхтэй бөгөөд гагцхүү банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, ломбард, үл хөдлөх хөрөнгийн болон үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудад сэжиг бүхий гүйлгээ, нэргүй данс нээх, эсвэл их хэмжээний / 50.000 ам.доллараас дээш/ болон нийт үнийн дүн нь 50.0 \$ буюу түүнээс дээш хоорондоо холбоо бүхий хэд хэдэн бэлэн мөнгөний гүйлгээний талаар хуулийн байгууллагад мэдээлэх үүргийг хуулиар оногдуулах замаар тэмцэх, илрүүлэх, хяналт тавих боломжтой.

Манай улсын хувьд энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байгаа боловч төрийн зүгээс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч эхэлсэн бөгөөд үүний нэг тод жишээ нь саяхан Монгол Улсын Засгийн газраас 2004 онд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх тухай” хуулийн төслийг санаачилж УИХ-д өргөн барьсан явдал юм.

ГЭМТ ХЭРЭГ ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЗАРЧИМ

*Чингис хааны нэрэмжит Их засаг Их сургуулийн
сурвалжны менежментийн албаны дарга, Төр, эрх
зүйн хүргэлжлийн захирал, докторант Б.Ганболд*

Гэмт хэрэг зүйлчлэл /цаашид ГХЗ гэж товчлоно/ гэсэн ойлголт нь *qualis & fasere*¹ буюу зөв үнэлэлт өгөх гэсэн утга бүхий латины чанар² гэсэн нэр томъёоноос эх үндэстэй гэж үздэг.

ГХЗ нь тухайн этгээдийн үйлдсэн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйд гэмт хэрэг гэж зүйлчлэх шинж байгаа эсэхийг тогтоон, эрүүгийн эрх зүйн үүднээс зөв үнэлэлт өгч, Эрүүгийн хуулийг хэрэглэж буй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа юм.

ГХЗ-г буруу хийх нь хүний эрх, эрх чөлөөг зөрчих, гэмт этгээдэд ял завшуулах, төрийн эрүүгийн бодлого алдагдах, шүүх эрх мэдлийн байгууллага, хуульчдын нэр хүндийг унагах, эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчих, эрүүгийн хуулийг буруу хэрэглэх зэрэг хууль зүйн олон талт сөрөг үр дагавар үүсгэдэг бөгөөд нөхөн сэргээхэд зардал чирэгдэл ихээхэн гардаг ба зарим тохиолдолд нөхөх хариуцлага хүлээх боломж ч байдаггүй /Жишээ нь: хэргийг буруу зүйлчлэн цаазаар авсан бол/ аюултай.

Тиймд эл аюулыг гаргахгүй байхын үүднээс ЭЭЗШУ нь ГХЗ-г тусгайд нь судлаж, эрдэмтэн судлаачид гэмт хэргийг буруу зүйлчлэж буй шалтгаан, түүнийг арилгах шаардлагатайг тэмдэглэн ирсэн байдлыг энд дурьдах нь зүйтэй юм.

Энэ бүхнийг нурушин өгүүлэхийн учир нь гэмт хэргийн зүйлчлэл нь тодорхой зарчимтай байхын мөн чанарыг илэрхийлнэ.

Хуулийг хэрхэн зөв хэрэглэх эсэх нь зүйлчлэлийн зарчмын хэрэгжилттэй нягт холбоотой тайлбарлагдана.

Улсын дээд шүүхээс³ аливаа хэрэгт хуулийг зөв хэрэглэхийн тулд нэгдүгээрт, шийдвэрлэх гэж буй хэрэг нийгмийн ямар харилцаанд хамаарахыг тогтоож, хоёрдугаарт, уг тогтоосон харилцааг зохицуулж байгаа хуулийг зөв сонгон авч, гуравдугаарт, сонгон авсан хуулийнхаа зүйл, хэсэг, заалт нэг бүртэй тухайн харилцаа тохирч байгаа эсэхийг нягтлан үзсэний эцэст сая хэргийг зүйлчлэн шийдвэрлэх зарчмыг баримтлана хэмээн тодорхойлсон заасан байдаг нь хууль хэрэглэгч хэн

¹ Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол, УБ, 2001, 10 дaь тaл.

² Г.Совд, БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс, УБ, 1973, 170 дaь тaл.

³ Монгол Улсын дээд шүүхийн тогтоогын эхлэл, УБ, 1999, 365 дaь тaл.

бүхний хувьд хуулийг зөв хэрэглэх явдлыг хангах чухал зарчим болон мөрдөгдөхийн зэрэгцээ ГХЗ-н зарчмын арга зүйн үндсэн хөрс суурь болох юм.

Судлаачийн /ГБД/ үзэж байгаагаар ГХЗ-н ажиллагаанд алдаа гаргахгүй байх, эрүүгийн хуулийг нэг мөр, нэгдмэлээр, зөв ойлгон хэрэглэхийн тулд ГХЗ-д хэд хэдэн зарчмыг бий болгож, улмаар түүнийг баримтлан ажиллах нь ГХЗ-д алдаа дутагдал гаргахгүй байх нэгэн нөхцөл болно гэсэн санал дэвшүүлсэнээ ийнхүү та бүхэнд толилуулж байна.

ГХЗ-г зөв хийхийн үүднээс ГХЗ-н ажиллагаанд удирдлага болгодог үндсэн үзэл баримтлалын нэгдлийг ГХЗ-н зарчим гэнэ.

ГХЗ нь дараахи зарчмаар хэрэгжилтээ хангана. Үүнд:

1. Эрүүгий хуулийг адилтган /төсөөтэй/ хэрэглэхийг хориглох зарчим,
2. Хэргийн бодит байдлын буюу үнэнийг тодорхойлох зарчим,
3. Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэх шинжид тулгуурлах зарчим,
4. Эрүүгийн хуулийг зөв хэрэглэх зарчим,
5. ГХЗ-н бодит байдлын болон хууль ёсны үндэслэлтэй байх шинжийг хослуулан хадаглах зарчим,
6. Гэмт хэргүүдийн өөр хоорондын ялгагдах шинжид үндэслэн гэмт хэргийг зүйлчлэх зарчим тус тус хамаарна.

1. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ АДИЛТГАН /ТӨСӨӨТЭЙ/ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ЗАРЧИМ

Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглох зарчим нь дэлхийн улс орнуудын эрүүгийн хуулийн⁴ ардчилсан шинжийг нотлон харуулдаг. Тиймд гагцхүү тухайн үйлдэл, эс үйлдэхүйг хийхийн өмнө түүнийг гэмт хэрэг хэмээн эрүүгийн хуульд заасан эл цорын ганц нөхцөлд л тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэж болно. Харин тухайн үйлдэл, эс үйлдэхүйг хийсний дараа түүнийг гэмт хэрэг гэж тооцож буюу ял шийтгэлийг нэмэгдүүлэх замаар эрүүгийн хуулийг нөхөн хэрэглэх зарчмыг ГХЗ-д үл хэрэглэнэ. Үүгээрээ эрүүгийн эрх зүй бусад салбар эрх зүйгээс ялгагддаг.

Эрүүгийн хуулийг /адилтган/ төсөөтэй хэрэглэх гэдэг нь тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж заагдаагүй байхад түүнийг гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хуулийн зохицуулалтанд хамааруулан ГХЗ-тэн шийдвэрлэхийг хэлнэ. Үүнийг жишээгээр⁵ тайлбарлавал: Монгол Улсын эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол гэж хулгайлах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг заасан байдлаас үзвэл уг гэмт хэргийн халдлагын

⁴ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Эрх зүй, УБ, 2001, 6-7 дэхь тал

⁵ Төр, эрх зүйн хууль-Эргэжүүлэл, УБ, 1998, 2-рт, 20 дэхь тал.

зүйл нь бусдын эд хөрөнгө гэхдээ биет зүйлс байх нь тодорхой байна. 2002 оны шинэ эрүүгийн хуулиар 1987 оны шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 133 дугаар зүйлд заагдсан **Эрчим хүч ашиглах журам зөрчих нь**⁶ гэмт хэрэгт тооцогдохгүй болсон учир эрчим хүч ашиглах журам зөрчиж цахилгаан хулгайлан хууль бусаар ашигласан үйлдлийг хулгайлах гэмт хэргээр зүйлчлэж болохгүй, хэрэв зүйлчилвэл эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэсэнд тооцогдоно гэсэн утга. 1934 оны эрүүгийн хууль болох Шүүх цаазны бичгийн 10 дугаар зүйлд анх удаа эрүүгийн хууль /түүнийг/-г **төсөөтэй хэрэглэж болохыг хүлээн зөвшөөрсөн**⁷ бөгөөд эл заалтыг 1961 оны эрүүгийн хуулиар хүчингүй болгосон түүхтэй.

2. ХЭРГИЙН БОДИТ БАЙДЛЫН БУЮУ ҮНЭНИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗАРЧИМ

Тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэхдээ хэргийн үйлдэгдсэн бодит нөхцөл байдлыг үнэн зөвөөр тогтоон бэхжүүлэх явдал нь ГХЗ-г зөв хийх эх үндэс нь болж өгнө. Үүний тулд эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминалистик, криминологи, нотлох баримтын онол, шүүх эмнэлэг, шүүх сэтгэц гэм судлал зэрэг бусад салбар эрх зүйн ололт, онолын үндэслэл, тэдгээрийн гэмт хэрэг илрүүлэх арга ухааныг зөв ашиглах шаардлагатай.

ГХЗ-н эцсийн үр дүн нь тухайн гэмт хэргийг үнэн зөв шийдвэрлэхэд орших учир ГХЗ-д гэмт хэргийн бодит байдлын буюу үнэний асуудал шийдвэрлэх нөлөө үзүүлнэ. Хэрэв гэмт хэргийн үйлдэгдсэн нөхцөл байдлыг буруу тогтоох юм уу, буруу үнэлвэл, тэрчлэн гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг хэт хийсвэрлэн түүнд хөнгөн хуудуу хандах, бодит байдлыг нотлох баримтаар тогтоохгүй тодорхойлох тохиолдолд ГХЗ буруу буюу худал болж, хууль зүйн сөрөг дүгнэлтэнд хүргэдэг хор уршигтайг энэ зарчмын агуулгын хүрээнд анхаарах нь зүйтэй.

Хэргийн бодит байдал бол гэмт хэргийн үйлдэгдсэн нөхцөл байдлын бодит үнэн ахуй учир гэмт хэрэг үйлдэгдсэн нь туйлын үнэн, түүний үйлдэгдсэн нөхцөл байдлыг тогтоох нь харьцангуй үнэн, харин уг хэргийг эцэслэн зүйлчлэн шийдвэрлэх явдал нь бодит буюу хууль ёсны үнэн байх ёстой. Эл үнэнийг хэрхэн зөв шийдвэрлэх эсэх нь гэмт хэргийн үйлдэгдсэн нөхцөл байдлыг бодит байдлаар яаж тогтоосноос шууд шалтгаална. Гагцхүү зүйлчлэгч энэ мөчид хэргийн бодит байдал, үнэний хоорондын харьцааг зөв тогтооход анхаарах ёстой.

Эл зарчмын агуулгын түвшинд гэмт хэргийг зүйлчлэхэд гэмт хэргийн болж өнгөрсөн нөхцөл байдлыг аль болох уг хэрэг үйлдэгдсэн тэрхүү байдлаар нь сэргээн

⁶ Эрүүгийн шинэ хуулийг дагаж мөрдөх журмыг тухай, 2002-07-24, УДШ-ийн 264-р тогтоол.

⁷ Legis, 2002 оны 1 дэх дугаар, 27-28 дахь тал.

босгох, эл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн, бодитой, хөдөлбөргүй тогтоон, зөв сэргээн дүрслэж, хууль зүйн хувьд баталгаажуулах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь, бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг ялах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоож улмаар эрүүгийн хуулийн зүйлчлэлд холбогдох хэм хэмжээтэй уг байдлыг зөв адилтган буюу харьцуулан дүгнэлт хийж, шударга ёс, эрх зүйн ухамсарыг удирдлага болгон, дотоод итгэлээрээ ГХЗ-лэх үүрэгтэй. Эл үүргээ хэрхэн биелүүлж байгаагаар энэ зарчмын практик хэрэгжилт танин мэдэгдэнэ.

Эрүүгийн шүүн таслах ажиллагааны практикаас үзэхэд эрүүгийн хэргийн үйлдэгдсэн нөхцөл байдал улам тодорхой болохын хамт уг хэрэгт өгч буй зүйлчлэл өөрчлөгдөх тохиоллол цөөнгүй гардаг нь ГХЗ-г баримжаалж буюу барагцаалсан шинжтэй хийдэг хөшин хооруу, буруу практикын гашуун сургамж юм.

ГХЗ-г анхлан хийж эрүүгийн хэргийг үүсгэх шатанд хэргийн бодит үйлдэгдсэн нөхцөл байдал тодорхой бус байдаг учир тухайн эрүүгийн хэргийн талаарх мэдээлэлд тулгуурлан ГХЗ-г урьдчилан баримжаалж барагцаалсан шинжтэй хийж болох авч хэргийн үйлдэгдсэн нөхцөл байдлыг эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын шатанд бүрэн дүүрэн шинжлэн судалж улам тодорхой болгох боломжтой. Энэ учраас ГХЗ-н асуудлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн аль аль нь анхаарлынхаа төвөөс салгаж үл болно. ГХЗ-н асуудалд тавих эл анхаарлыг ялимгүй ч гэсэн сулруулбал ГХЗ нэр төдий хийгдсэн, хэргийн шийдвэрлэсэн байдал хэлбэрдсэн болохыг илэрхийлэхийн зэрэгцээ бодит үнэн, хууль ёс зөрчигдөн, хүний эрх хохирч, шүүх эрх мэдлийн нэр хүнд суларч, гэмт этгээлд ял завшуулах хууль зүйн сөрөг үр дагавар үүсэн бүрэлдэх аюултай. **Жишээ болгон**⁶: Улсын дээд шүүхийн 2002-05-20-ны өдрийн 167 тоот тогтоолыг үзэх.

3. ҮЙЛДЭЛ, ЭС ҮЙЛДЭХҮЙГ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЗҮЙЛЧЛЭХ ШИНЖИД ТУЛГУУРЛАХ ЗАРЧИМ

Ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэх эсэхийг шийдвэрлэхэд энэ зарчмын агуулга чиглэхгүй, харин үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэх талаар боловеруулсан гэмт хэрэг зүйлчлэлийн онолын эл үндэслэлийг гэмт хэрэг зүйлчлэх ажиллагаанд ягштал баримтлах ёстойд л энэ зарчмын агуулга нь орших болно. Тиймд аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэн шийдвэрлэхдээ:

⁶ С.Савхсүрэн, БНМАУ эрүүгийн эрх, УБ, 1964, С.Нарангэрэл, МУ-ын эрүүгийн эрх зүй, УБ, 1999, Б.Ганболд, МУ-ын эрүүгийн эрх зүйн тойм, УБ, 2003 оны номуудас тусруулж үзэе үү.

1. Тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн агуулга, хэлбэртэйгээр үйлдэгдсэн эсэх,
2. Тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж заагдсан эсэх,
3. Тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь эрүүгийн хуулийг зөрчсөн буюу хууль бус шинжтэй эсэх,
4. Эцэстээ эл үйлдэл, эс үйлдэхүйдээ субъект гэм буруутай эсэхийг нотлох нь гэмт хэрэг

зөв зүйлчлэгдэх, ГХЗ-г хийхэд нэгдсэн арга зүйн үндэслэл бүрдэх, онол болон практик хосолмол чанартай байх, уг этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг үндэслэлтэй шийдвэрлэх зэрэг нөхцлийг хангаж буй байдлаар уг зарчмын ач холбогдол илэрнэ.

Эрүүгийн хэргийг зүйлчлэн шийдвэрлэж байгаа шүүн таслах үйл ажиллагааны практикаас үзэхэд тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэхэд тодорхой шалгуур шинж байх явдал зайлшгүй шаардлагатай нь тодорхой мэдрэгдэж, эл онол, арга зүйн үндэслэл дутан, үгүйлэгдэж буй нь ГХЗ-н онол, арга зүйн үүднээс үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэх шинжид тулгуурлах зарчим бүрэлдэн тогтоход нөлөөлсөн болно. **Жишээ нь:** А нь ууттай хогоо 5 давхарынхаа хогын пункерлүүгээ хийж, гэртээ оржээ. Төд удалгүй тэдний хаалгыг оршны жижүүр өвгөн нүдэж чи хогоо хаяхдаа хүн цохиод алчихлаа гэв. Нэг давхарын хогийн цэгт очиход хог ухааж явсан нэгэн хүн ууттай хогонд цохнулан нас барсан байв.

Эл үйлдлийг эрүүгийн хуулийн 94 дүгээр зүйлд заасан бусдыг болгоомжгүй алсан гэмт хэрэг гэж зүйлчлэн эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. А мэдүүлэхдээ: би гэм буруу байхгүй, миний үйлдэлтэй энэ хүний үхэл холбоогүй, хэн тэрнийг хог ухаад байж бай гэсэн юм, дээрээс хог унаж ирдэг гэдгийг мэддэггүй юм уу, анхааралтай байсан бол үхэхгүй л байх байсан, би хогоо хаяхдаа хүн байна уу, би хогоо хаялаа шүү, холдоорой гээд хаях ёстой юм уу, аль эсхүл бүр нэг давхарт очиж хогоо хаях байсан юмуу, ойлгохгүй байна, хогоо хогын пункерлүүгээ хаях ёстой биз дээ, ийм л дүрэм журамтай гэж ойлгож байгаа, би хууль журам зөрчөөгүй, ердөө хаядаг газар нь л хогоо хаясан гэжээ. Энэхүү амьдралын эгэл хэрнээ амаргүй тохиолдлыг хэрхэн зүйлчлэн шийдвэрлэх ёстой вэ гэсэн асуудал бидний өмнө тулгарч байна. Үүнд үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж зүйлчлэх шинжид тулгуурлах зарчим л гагцхүү хариу өгөх арга зүйн үндэс болно.

4. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ ЗАРЧИМ

Энэ зарчмын агуулгын хүрээнд: Эрүүгийн хуулийн үйлчлэлийг үндэслэлтэй тогтоон эрүүгийн хуулийг зөв буцаан хэрэглэх, эрүүгийн хуулийг буруу хэрэглэхгүй,

Хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн гэж гэмт хэргийг зүйлчлэхдээ эрүүгийн хуулийн өөрийн зохицуулалтын утга агуулгыг зарчмын хувьд зөрүү буюу ташаа ойлгож хэрэглэсэн гэдэг. Жишээ нь: Н-ийн машин дотор байсан гар утсыг Б гэгч хулгайлан авсан байна. Гэтэл машиныг орон байр, агуулах сав гэсэн ойлголтонд багтаан үзэж Б-н үйлдлийг эрүүгийн хууль 145 дугаар зүйлийн 3 дахь хэсгээр зүйлчилсэн явдал.

5. ГЭМТ ХЭРЭГ ЗҮЙЛЧЛЭЛИЙН БОДИТ БАЙДЛЫН БОЛОН ХУУЛЬ ЁСНЫ ҮНДЭСЛЭЛТЭЙ БАЙХ ШИНЖИЙГ ХОСЛУУЛАН ХАДГАЛАХ ЗАРЧИМ

ГХЗ нь бодит байдлын болон хууль ёсны үндэслэлтэй байх мөн чанарыг хослуулан хадгалсан шинжтэй¹⁰ гэхдээ энэ зарчим нь уг хоёр шинжийг урьтал болго гэсэн хэрэг бус харин ГХЗ-н явцад эрүүгийн хэргийн талаар нотолбол зохих байдлууд/-асуудлууд/-ыг¹¹ бүрэн бодитой тогтоох, үүний үндсэн дээр хэргийн жинхэнэ нөхцөл байдалтай нийцсэн, хууль зүйн зөв дүгнэлт хийх үүргийг гэмт хэргийг зүйлчилэгч хүлээдэг, эл үүргээ биелүүлэхдээ ГХЗ-н бодит байдлын болон хууль ёсны үндэслэлтэй байх шинжийг хослуулан хадгалах ёстой болохыг баримтлан ажиллахыг хүсэмжтэн буйг илэрхийлнэ.

Хэрэв ГХЗ-н үндэслэл нь нотлох баримтаар нотлогдохгүй байх, эрүүгийн хуулийн хэм хэмжээнд яв цав нийцэхгүй байх, эрүүгийн хуулийн зарчмын шинжтэй хэм хэмжээг орхигдуулан гэмт хэргийг зүйлчилсэн, ГХЗ-д ноцтойгоор нөлөөлж болох байдлыг анхааран үзэлгүй орхигдуулсан, ГХЗ-д онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авч, бусдыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй, ГХЗ-нь гэм буруугийн асуудлыг шийдвэртэх, эрүүгийн хуулийг зөв хэрэглэх, ялыг зөв оногдуулахад нөлөөлсөн буюу нөлөөлж болох ноцтой зөрүүтэй байвал ГХЗ-нь хэргийн жинхэнэ нөхцөл байдалтай нийцээгүй гэж үзэж ГХЗ-н бодит байдлын болон хууль ёсны үндэслэлтэй байх шинжийг хослуулан хадгалах зарчим алдагдсан хэмээн дүгнэх үндэс бүрдэнэ.

Иймийн учир угтаа эл алдааг гаргахгүй байх, ГХЗ-н хууль ёсны, үндэслэлтэй, бодит байдалд нийцсэн гэсэн нөхцлийг хангахад тус зарчим нөлөө үзүүлнэ. Тухайлбал: А адуугаа эрж яваад нутгийн нэгэн айл болох Ч-н гэрт түр саатан, аяга цай уун, алдсан малаа асуугаад эргэн эрэлдээ мөрьдсон байна. Гэтэл Ч-н 3 үе дамжсан халтар манан хөөрөг эл үеэр алга болжээ. Тиймд уг хэрэгт А-г холбогдуулан түүнд 3

¹⁰ Б.Тавбалд, МУ-ын эрүүгийн эрх зүй дэх гэмт хэргийг зүйлчлэхийн онцол, УБ, 2001., 14-15 дахь тал.

¹¹ ЭБШХ-ийн 80-р зүйл.

жилийн хорих ял оногдуулсан аж. Түүний дараа Ч-ийх нутаг сэлбэн нүүх болж, эл нүүдэл суудлын үеэр уг хулгайлагдсан гэх хөөрөг Ч-н хүүхдийн бойтог /гутал/ дотроос нь олджээ. Энэ тохиолдолд ГХЗ-н эл зарчим алдагдсан тул уг хууль зүйн сөрөг үр дагавар үүссэн гэж дүгнэж болно. Тиймд энэ зарчмыг хэрэгжүүлэхэд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, үүргээ хууль ёсны, бодит үндэслэлтэй, шударгаар, хэлбэрэлтгүй биелүүлэх явдал чухал ач холбогдолтой юм.

6. ГЭМТ ХЭРГҮҮДИЙН ӨӨР ХООРОНДЫН ЯЛГАГДАХ ШИНЖИД ҮНДЭСЛЭН ГЭМТ ХЭРГИЙГ ЗҮЙЛЧЛЭХ ЗАРЧИМ

ГХЗ-н зарчмуудын дотор эл зарчим онцгой байр суурийг эзлэнэ. Учир нь нэг талаасаа нэг гэмт хэрэг нь нөгөө гэмт хэргээсээ заавал ямар нэгэн шинжээрээ ялгагддаг, нөгөө талаасаа ГХЗ нь гэмт хэргүүдийн өөр хоорондын ялгагдах шинжийг олж тогтоох, улмаар тэр шинжил нь тулгуурлан эрүүгийн эрх зүйн хууль ёсны болон бодит үнэлгээ, дүгнэлт өгөхөд чиглэж байдаг ба эрүүгийн хууль түүнд хуульчлагдсан гэмт хэргүүдийн өөр хоорондын ялгагдах шинжил тулгуурлан эрүүгийн хуулийн ГХЗ-н холбогдох хэм хэмжээг хэрэглэн явагдах өөрийн онол, арга зүй, шинж, зорилго, хууль зүйн үндэслэл, практикын учир холбогдол бүхий эрүүгийн эрх зүйн ээдрээ төвөгтэй, нарийн үйл явц, асуудал юм.

Энэ зарчмын агуулгын хүрээнд ГХБ, түүний шинж, ГХЗ-д үзүүлэх учир холбогдол болон ЭХТА-н бүтэц, системчлэл буюу гэмт хэргүүдийн төрөл, бүлэг, зүйлийн хамаарал, эрүүгийн эрх зүйн өрсөлдөгч хэм хэмжээ зэрэг асуудалд анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай болно. Энэ нь тухайлбал, эх орноосоо урвахыг тагнуул хийхээс, дээрмийг булаалтаас, хүн барьцаалахыг хүн хулгайлахаас, гүтгэхийг доромжлохоос, хүнд гэмтлийг хүндэвтэр гэмтэл учруулсан гэмт хэргээс ялган заагдахдаа гагцхүү энэхүү зарчмаар л тайлбарлахад орших юм. Үүнд л мөнхүү зарчмын ач холбогдол, үнэ цэнэ агуулагдана.

Яг адил бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг гэж байдаггүй, байх ч ёсгүй учир гэмт хэргүүд нь өөр хоорондоо ГХБ-нийхээ онцлог хийгээд өвөрмөц хуульчлалын зохицуулалтаараа ялгагдана. Гэмт хэргүүдийн ялгагдах шинжийг олж тогтоохдоо тухайн ГХБ-г хуульчлан тогтоосон ЭХТА-н эх бичмэл, эрүүгийн хуулийн албан ёсны болон албан ёсны бус тайлбар, эрдэмтэн судлаачдын бүтээл туурвил, эрүүгийн хэргийг зүйлчлэн шийдвэрлэж байгаа шүүн таслах үйл ажиллагааны практик зэрэгт дүн шинжилгээ хийвэл зохино.

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МОНГОЛ УЛАМЖЛАЛЫГ СЭРГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ АСУУДАЛД

Хууль зүйн шинжлэх ухааны
доктор, профессор О.Амархүү

I. Уламжлал, түүний ач холбогдлын тухай товч мэдээлэл

Дэлхийн аливаа улс үндэстэн, ард түмэн амьдралынхаа орчин болсон байгалийг хамгаалах, зохистой ашиглах, нөөцөн сэргээх, байгаль орчинтойгоо зохицон амьдрах талаар өөр өөрийн гэсэн өвөрмөц мэдлэг, дадлага, зан үйл, сүнийг бэширэл, хууль цаазтай байсаар ирсэн, одоо ч тэр нь ямар нэг хэмжээгээр халгалагдан үлдсэн байна. Гэхдээ тийм өвөрмөц онцлогийн ихэнх нь цаг хугацааны явцад аажим аажимар бүдгэрэн орхигдож гээгдсээр, зарим нь бүр мартагдан арилсан байдал ч бодитой болжээ.

Улс үндэстэнд байсан, бүр үе үеийн туршид дамжин халгалагдаж, амьдрал ахуйд хэвшин хэрэглэгдсээр, үр дүнгээ өгсөөр ирсэн тийм өвөрмөц онцлог зүйлүүдийг бид өнөөдөр “уламжлал” гэж нэрлэж байгаа билээ.

Улс үндэстэн, нутгийн үндсэн хүн ам, түүний омгууд, орон нутгийн уугуул иргэдийн дунд тэдний оршин суугаа газар нутаг, ахуй амьдрал, соёл, мэдлэг, шашин шүтлэг, дадлагын хүрээнд хэвшиж тогтсон бөгөөд ёсчлон дагаж бие нүүлдэг, өвөрмөц онцлогоороо ялгаран давтагдаж байдаг зан үйлийн нийлбэр цогцол /бичигдээгүй хууль/-ыг байгаль хамгаалах уламжлал гээж нэрлэж болно. Хамгийн товчоор энэхүү уламжлалыг байгаль орчин, оюун ухааны хоорондын шүтэлцээт холбоо гэж үзвэл зохино.

Уламжлал, ялангуяа нүүдэлчин гарлын улс орнуудад нүүдэлчдийн соёл иргэншилтэй шууд уялдаатайгаар илүүтэй хөгжин дэлгэрчээ. Суурин соёл иргэншилд ч бас бий.

Уламжлал бол байгалийг бүхэлд нь, ялангуяа биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах, ашиглалтыг сайжруулахад орчин цагийн нэг чухал хэрэгсэл болж байна. Уламжлалын асуудал Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу олон улсын анхааралд аль хэдийн нь оржээ. *Рио-гийн тунхаглалын* 22 дугаар зарчимд: Хүрээлэн буй орчныг зохистой ашиглах, сайжруулахад уламжлал

амьдралын дадлага, мэдлэгтэйн хувьд нутгийн үндсэн хүн ам амин чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Улс орнууд тэдний өвөрмөц ахуй, соёл болон ашиг сонирхолыг хүлээн зөвшөөрч, зохих ёсоор дэмжих ёстой гэж заасан.

Тогтвортой хөгжлийн талаарх *Йоханнесбургийн Тунхаглалын* 25-д “Тогтвортой хөгжилд уугуул нутгийн ард иргэдийн үүрэг чухал болохыг бид дахин батлаж байна” гэжээ.

“Биологийн төрөл зүйлийн тухай” Конвенцийн 8 дугаар бүлэгт “...биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой ашиглахад ач холбогдол бүхий амьдралын уламжлалт хэвшилтэй уугуул хүн ард, нутгийн бүлэг хүмүүсийн мэдлэг, шинэлэг зүйл, амьдралын туршлагыг хүндэтгэн хамгаалж дэмжих, тэдгээр хүмүүсийн оролцоотойгоор өргөнөөр дэлгэрүүлж хэрэглэх боломж олгох”-ын чухлыг онцлон авч үзсэн юм.

Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн дээрх зарчим, Конвенцийн заалт Монголын төр, олон нийт, ард түмний анхаарлын төвд байсаар байна. Монгол Улсын Их Хурлын 1994 оны 56 дугаар тогтоолоор батласан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын Х хэсгийн 55 дугаар зүйлийн 1-д: “байгаль орчноо хайрлан хамгаалдаг ардын уламжлал, ёс заншлыг сэргээж бүх нийтэд түгээн төлөвшүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд тавина” гэж заасан.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн /1995/ 4 дүгээр зүйлийн 2.2-т: “байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох” нь иргэн бүрийн үүрэг мөн гэж хуульчиллаа.

II. Байгаль хамгаалах Монгол уламжлал гэж чухам юу вэ?

Монгол ямар онцлогтой вэ? Монголчуудын байгалиа, ургамал, амьтны аймгаа хамгаалах, зөв ашиглах уламжлал их арвин баялаг, олон талтай. Монголчууд өнө эртнээс байгаль орчинтойгоо зохицон амьдрах мэдлэг, арга ухааны баялаг түүхтэй. Тэр нь олон зуун жилийн туршид нүүдэлчдийн ахуй амьдрал, соёлд шингэн тогтсон зан заншил, шашин шүтлэг, хууль цаазар илэрч хэвшсэн онцлогтой. Монголчууд

Унасан шороо алт

Угаасан ус рашаан

Өргөн дэлхий эх минь

Өндөр тэнгэр эцэг минь гэж бахархана.

Монголчуудын байгалиа хүндэтгэн хамгаалсаар ирсэн уламжлал нь тэдний оюуны их өв сан юм.

Монголчуудын байгаль хамгаалах уламжлалыг нарийвчлан ажиглахад гурван гол асуудалд төвлөрч ирсэн байна.



Үүнийг уламжлалын объект гэж үзэж болно. Энэ гурав бие биенээс саланги тусгаар биш, өөр хоорондоо харилцан нягт уялдаатай. Жишээ нь, байгалийг хамгаалъя гэвэл ан амьтныг ч, ургамлыг ч хамгаалана, ургамлыг хамгаалъя гэвэл байгаль дэлхийгээ, нутаг усаа ч, амьтны аймгаа ч хамгаална гэсэн үг.

Монголчуудын байгаль хамгаалах уламжлал хэвшиж тогтсон зан үйлийн хувьд *таван төрөлд* ангилагдана.



залбирдаг. Монголчууд цайг таван тансаг идээний дээж гэж хүндэлдэг учир тэрхүү хүндэт идээгээ хан тэнгэр, хангай дэлхийтэйгээ хуваалцан хүртэж буй гэсэн итгэлийг олдог. Тэнгэр, газрыг хүндлэн биширдэгийн учир нь тэнгэр бол хүн, амьтан, ургамлын эцэг нь, газар бол тэднийг төрүүлж, элгэн дээрээ энхрийлэн өсгөж торинуудан, сүү шимээрээ тэжээн амьдаруулдаг эх нь хэмээн үздэгт оршино.

Чингис хаан гэнэт довтолгон ирсэн Тайгчуудын гурван зуугаад нэрэгтэй зургаан сайдынхаа хамт тулалдаж ялан дийлснийхээ дараа "...тэнгэр эцэгтээ мөргөө гэж довтог дээр гарч, тохмоо дэлгэж тавиад бүсээ хүзүүндээ өлгөж залбиран:

Эрэмгий сайнаар
Эзэн эс боллоо, би
Эрхт тэнгэр
Эцгийн хайраар
Эзэн боллоо, би
Эцэг тэнгэрийн ачаар
Эсрэг дайснаа дарлаа, би
Хамрагч сайнаар

Хаан эс боллоо, би
Хан тэнгэр эцгийн
Хайраар эзэн боллоо, би
Хан тэнгэр эцгийн өршөөлөөр
Харь дайсныг дарлаа, би" гэж
өчн мөргөж байжээ.
/Монголын нууц товчоо. Дөрөв
дэх удаагийн хэвлэл, УБ., 1990,
104-р талд/

- Байгаль орчиндоо энэрэл хүндэтгэлтэй хандаж ирсэн зан заншлуудын дотроос нийтийг хамарсан хамгийн илүү хүндэтгэлтэй зан үйл нь уул овоо тайх тахиглах ёслол байв. Энэ ёслол нь овоо тахилгаас илүү өргөн цар хүрээтэй, үлэмж хүндэтгэлтэй зан үйл юм.

Түүхэн баримт сэлтэд тэмдэглэгдснийг үзэхэд Монгол нутагт уул овоо тайх зан үйл бүр XIII зуунд ердийн үзэгдэл боллоо хэвшсэн аж. Хан Хэнтийн Бурхан Халдун уулыг Чингис хааны үед хамаг монгол хийгээд монголын их гүрэн, бүх монгол туургатны сүлд уул болгон хүндлэн тахиж байсан түүхтэй. Энэ ёс бараг тасралтгүй үргэлжилсээр Монгол улсын сэргэн мандлын үед "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг"-ийн "Тайх тахиглах ёслолын хууль"-иар албан ёсоор хуульчлагджээ. Ингэснээр төрийн болон ардын уламжлалын хосолмол томоохон ёслол болон хувирсан байна. Эл хуульд Богд хан хайрхан уул, Хан Хэнтийн Бурхан Халдун уул, Отгон тэнгэр уулыг тайх тахилга үйлдлийг зун намрын дэлгэр цагт хийж байх, уг тайх тахилгын дэг жаяг, төрөөс оролцох оролцоо, гаргах хөрөнгийн тухай нарийвчлан заажээ. Уг ёслол XX зууны 30-аад он хүртэл үргэлжлээд нэг хэсэг тасарч, мөн зууны 90-ээд оны дундуур Монгол Улсын анхны Ерөнхийлөгч

П.Очирбатын зарлиг буулгаснаар дахин сэргэж, улмаар одооны Ерөнхийлөгч Н.Багабанди шинэчлэн зарлиг буулгаснаар батжин дэлгэрэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.Очирбат 1995 оны 5-р сарын 16-ны өдөр 110 дугаар Зарлиг гаргаж, “Монголчуудын эртнээс нааш Богд хан хайрхан уул, Хан Хэнтий уул, Отгонтэнгэр уулыг тайж ирсэн уламжлалыг сэргээн дээрх уулыг Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичигт заасныг харгалзан эдүүгээ цагийн байдалд нийцүүлэн тайх талаар олон түмнээс гаргаж байгаа санаачлагыг дэмжсүгэй” гэжээ

Монгол Улсын Ерөнхийлөгч

Н.Багабанди 2004 оны 4-р сарын 23-ны өдөр 57 дугаар Зарлиг гаргаж, өвөг дээдсийнхээ оно эртний сайхан зан заншил, түүх соёл, төрт ёсны уламжлалыг баримтлан уул овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг эдүүгээ цагийн байдалд нийцүүлэн үйлдэж байх нь зүйтэй хэмээн тэмдэглээд, “Бурхан Халдун уул, Отгонтэнгэр уулын тэнгэрийг тайх, Дарьгангын Дарь овоог тахиx төрийн тахилгын ёслолыг үйлдэх нь зүйтэй хэмээн үзэж дээрхи уул, овоог, Төрийн тахилгатай уул, овоо хэмээн нэрлэсүгэй” гэжээ.

Уг Зарлигт зааснаар Төрийн тахилгатай овоо, уул бүрийн тэнгэрийг тайх тахилгын ёслолыг дөрвөн жилд нэг удаа үйлдэж байх бөгөөд ёслолын журмыг мөнхүү Зарлигийн хавсралт болгон баталжээ.

Төрийн эдгээр шийдвэр амьдралд сайхан хэрэгжиж, зон олныхоо сэтгэл санаа, ажил үйлс, аз хийморийг сэргээсээр байна.

Эртнээс алдартай нутаг усаа тайж тахиx ёслол нь сүсэг бишрэлийн гэхээсээ байгалиа хайрлан хүндэтгэж хамгаалах талруугаа илүүтэй чиглэсэн зан үйл юм. Тэгээд ч гоц үзэсгэлэн тогтоцтой, өвс ургамал өтгөн сахлаг, ой хөвч хөглөгөр арвин, араатан, жигүүртэн, гөрөөс мэтийн ховордсон амьтан шивээлэн сүлжилдсэн үнэхээрийн баян тансаг, ариун нандин шүтээнт хан уулуудаа тайж тахидаг уламжлал нэн эртнээс төгтсон байна.

Ардын хувьсгалын эхэн үеийн нэрт эрдэмтэн Жамсраны Цэцэн 1924 онд “Монголын Дархан, Сүлд, цаазтай газруудын учир” гэсэн ном хэвлүүлжээ. Энэ номд Монгол нутагт маш зрэн цагаас онгон тайлаа бүхий Дархан цаазтай газар маш олон бий. Учрыг ухвал гэгцтүү бөө уданы ёсыг дагасны хэрэг гэж болохгүй, үүнд ард амы ашиг тусад халбогдох учир буй агаад, ус бүлгийг ариун цэвэр авч уртал хэрэглэх, ховор ан гөрөөс оршин шижлэх уул, бүтх бэлэр газруудыг цаазлан онголж, тэдгээрийн ан гөрөөсийн үндэс таслахгүйг хичээх, ой модыг хамгаалж эм, шороо нурж, агрын хорс гэмтэхээс болгоомжилсон мэргэн арга болоо. гэж тэмдэглэж байжээ. /Ч.Арслансүрэн, Д.Мөнхболд. Монгол ёс заншлын их тайлбар томь. III. УБ., 2000,127-р талд./

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр гаргасан 110 дугаар зарлигийн ёсоор Хан Хэнтий уулын Бурхан Халдуньг тайх ёслол 1995 оны 6 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд болж, Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, Батлан хамгаалахын сайд Ш.Жадамбаа нар тэргүүтэй төр, засгийн төлөөлөгчид Хэнтий, Төв аймгийн зарим сүмдэн болон Улаанбаатар хотын зарим сүм хийд, төр, олон нийтийн байгууллагын төлөөлөгчид, сонирхсон ард иргэд машинд өргөнөөр нуглан оролцож, ихэд хүндэтгэлтэйгээр Бүх цэргийн хар сүлдийг залж “Долоон бурхан одны тахилга”-ыг 12-ний өдрийн хулгана цагт /23-24 цагийн хооронд/ үйлдсэнээр уг ёслолын ажиллагаа эхэлж, 13-ний өдрийн өглөөний 05 цагаас үргэжлж, Ерөнхийлөгчийн зарлигийн бичгийг дуудан их уулнаа сонордуулаад, гантиг чулуун бумбанд оршоосон шүншигийг Их овооноо залав. Лам нар Хан Хэнтий уулын сан тавьж, Бурхан Халдунь дээд, дунд, доод овооноо тахилгын уншлага зэрэг зэрэг явж, дөрвөн зүгт дөрвөн лам орон дэлхийдээ хандан юлтгүү/орны угаалга/ өргөж байв, хэмээн захиолч, эрдэмтэн, сэтгүүлч Ж.Саруулбуян бичсэн нь бий. /Монголчуудын байгаль хамгаалах ёс заншил, уламжлал. УБ., 2001, 141-142-р талд/ Энэхүү тахилгын хүндэтгэлийн ёслолд миний бие 9 настай ач хүү Э.Золбоо, Монголын байгаль орчинг хамгаалах холбооны ажилтан, зураглаач Ц.Чултэмнамдаг, “Байгаль” сонины эрхлэгч Б.Монголхүү нарын хамт биечлэн оролцож байсан юм. Бид дараа нь Богдхан уулын тайллагад ч бас очиж байлаа.

- Уул овоо тайх тахиглах ёслолтой гадна хэлбэр шинжээрээ олон талаар адил боловч түүнээс ялгагдах онцлог бүхий энэрэл хүндэтгэлийн өөр нэгэн ёслол бол “овоо тахиx” зан үйл юм. Овоо тахиx нь уул овооны тахигаас үүдэлтэй бөгөөд нутаг нутгийн уугуул иргэд тухайн газар нутгийнхаа хүндэтгэл бүхий уул усыг тахидаг, нэг ёсондоо оршин суугаа газар нутгийнхаа хүн амын дотор үйлддэг ёслолын зан үйл юм. Уг ёслолд өөр аймаг, хошуу сумын ард иргэд тэр бүрийн оролцдоггүй учир “уул овоо тайх тахиглах” ёслолоос ялгардаг гол онцлогтой.

Овоо тахих зан үйл нь мөн л нэн эртний уламжлал юм. Овоо тахидагийн гол утга учир нь уул ус ямар нэгэн ид шидийн хүчтэй эзэнтэй байдаг учир түүнийг аргадаж хүн, мал сүрэг, ан амьтан, ургамалд ямар нэгэн муу ёрын юм тохиолдуулалгүй, үргэлжид сайн сайхнаар хандаж буян хишгээ хүртэж байхыг хүссэн сэтгэлгээний томоохон билэгдэл болдогт оршино. Энэ бол ахуйд маш ойртсон сэтгэлгээ учир амьдралд их амархан хэвшиж тогтдог онцлогтой.

Уул усны ид шидийн хүчтэй эзнийг лус, савдаг гэж нэрлэнэ. Жишээ нь, ургамал, амьтны амьдралын амин шүтэлцээ нь болсон гол, мөрөн, нуур усны эзэн нь лус байдаг. Лус бол үүл үүсгэж бороо хур оруулах ид шидтэн бөгөөд түүнийг могойгоор дүрсэлнэ. Могойгоор оролдох, могойн амийг муулах/алах/ үйлдэл хийвэл лусын хорлол болно гэж үздэгийн учир энэ буюу.

Тахилгын шүтлэг бүхий овоо нь зүгээр нэгэн овоолсон мод, чулуу огт бий. Тахилгат овоо босгох ёсон маш нарийн дэг жаяг, хүндэтгэлийн учир бэлгэдэлтэй. Тахилгат овоог хамгийн өндөр, үзэмжтэй газар босгохоор газраа сонгон авч, тэрхүү газрынхаа төв дунд гүнзгийлэн малтаж, урьдаар бэлтгэсэн бумба саванд алт, мөнгө, шүр, сүлд мэтийн эрдэнэсийн зүйлийг таван тарианы үртэй хамтад нь хийж амсрыг нь битүүлэн ухсан нүхэндээ хийж газрын түвшинтэй чамууруулан булдаг байна. Ингээд чулуу, модоо тойруулан зэрэглэж нэг нэгээр орон дээш өндөрлөнө. Овооны төв дунд сүлд-дог мод гэж тусгайлан зорж бэлтгэсэн модыг босоо байрлалаар байрлуулна. Сүлд-дог модны дээд үзүүрт жад маягийн дөрвөн туг хандсан иртэй төмрийг бат бэхээр суулгаж төмөр цагирагаар модтойгоо бэхлэж, хар хээр азарганы дэлээр хохол хийж төмөр цагирагаас унжуулна. Овоо нь сууриараа уужим талбуу, өндөрлөх тутам шовхрон нарийсна. Овооны зүүн, баруун, хойт талд тусгайлан засч бэлтгэсэн гурван өндөр мод суулгаж, сүлд-дог модноос тус бүрт нь эр хар сураар хэц татаж хадаг яндар, хийморийн дарцаг зүүхэд бэлтгэдэг байна. Хан Лохий нурууны шувтарга үзүүр, Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг "Их Хайрхан"-ны тахилгат овоог тэгж бий болгосон түүхтэй гэнэ. Гэхдээ энэ нь хаана ч хэрэглэдэг нэлээд нийтлэг ёсон бололтой. Харин газар орон бүрт зарим онцлог байж болдог ёсон бас байдаг аж.. "Алтан овоо" буюу "Сүлд овоо" босгоход баруун, зүүн талд нь зургаа, зургаагаар эгнэсэн арван хоёр жижиг овоо бас босгодог гэх бөгөөд тэднийг Хан Лохий нутгийнхан "ээл овоо" гэж нэрлэдэг байна.

/Увс аймгийн Зүүнхангай сумын ахмад настан Т.Дарьсүрэнгийн аман яриа/

Монголчуудын тахидаг овоо олон янз. Нутаг усныхаа хамгийн хүндтэй уулын овоог "Алтан овоо" буюу "Сүлд овоо", давааны орой дээрх овоог "Замын овоо", горхи, булаг шандын эхэнд босгосон овоог "Булагийн овоо", рашаан-усны эхийн овоог "Рашааны овоо" гэх жишээтэй. Овоо бүхэн хамгаалалт, авралын бэлэг тэмдэг болдог. Жишээ нь, "Алтан овоо" нь тухайн нутаг усны хүн, амьтан, ургамал, ой,

Нүүдлийн ачаа голын хувьсаа өмсөж, үс гээгээ цэмцгилтэн самнасан, хуухамдаа баяр ёслол явж буй мэтээр гогсоон гэрлийн эзэлтэй шинэ нүдэл үс хүртэл хөтөн явна. Нүүдлийн зам зүүрт ан амьтан, зэр гөрөөс тааралтай машин олохгүйрхэн

өргөж ачаагаа хөдөлгөнө.

Нүүдлийн ачаа голын хувьсаа өмсөж, үс гээгээ цэмцгилтэн самнасан, хуухамдаа баяр ёслол явж буй мэтээр гогсоон гэрлийн эзэлтэй шинэ нүдэл үс хүртэл хөтөн явна. Нүүдлийн зам зүүрт ан амьтан, зэр гөрөөс тааралтай машин олохгүйрхэн

/Mongolian taxidermy and skin care studio, Ulaanbaatar, 2001, 8-24-p.mad/

Хангайн нүүдлийн ачаа голын хувьсаа өмсөж, үс гээгээ цэмцгилтэн самнасан, хуухамдаа баяр ёслол явж буй мэтээр гогсоон гэрлийн эзэлтэй шинэ нүдэл үс хүртэл хөтөн явна. Нүүдлийн зам зүүрт ан амьтан, зэр гөрөөс тааралтай машин олохгүйрхэн

Хангайн нүүдлийн ачаа голын хувьсаа өмсөж, үс гээгээ цэмцгилтэн самнасан, хуухамдаа баяр ёслол явж буй мэтээр гогсоон гэрлийн эзэлтэй шинэ нүдэл үс хүртэл хөтөн явна. Нүүдлийн зам зүүрт ан амьтан, зэр гөрөөс тааралтай машин олохгүйрхэн

Хангайн нүүдлийн ачаа голын хувьсаа өмсөж, үс гээгээ цэмцгилтэн самнасан, хуухамдаа баяр ёслол явж буй мэтээр гогсоон гэрлийн эзэлтэй шинэ нүдэл үс хүртэл хөтөн явна. Нүүдлийн зам зүүрт ан амьтан, зэр гөрөөс тааралтай машин олохгүйрхэн

баярлаж, шинэ нутаг ус аз хийморьтой, өглөг өгөөж сайтай байхын бэлэгдэл хэмээн дээдэлж ерөөл тавин өнгөрүүлнэ. Гоёж гоодсон бүсгүй хүн нүүдлийн ачаа хөтлөн ирэхэд шинэ нутаг усны эзэн-лус, савлаг харж баярлан өвчин зовлонгүй, гачаал түйтгэргүй нутаглуулж хишиг буянаа харамгүй хайрлана гэж сүшиглэн итгэдэг байжээ.

Шинэ нутагт очоод “Буусан нутаг, суусан хангай минь урдаас утгаж, хойноос түшиж хайрла. умаа хум” гэж цацал өргөдөг заншилтай.

- Мод, өвс ургамал, ан амьтныг эрхэмлэн хүндэтгэж ирсэн монгол хүний уламжлал өнөөгийн шинжлэх ухааны томъёололоор биологийн төрөл зүйлийг эрт цагаас хамгаалах ард олны хүчирхэг арга хэрэгсэл болж тогтсон байв.

Монголын говь нутгийн ард олон заг, хайлаас, сухай модыг эрхэмлэн хүндэтгэдэг бол хангай нутгийнхан хуш, хус, бургас, ари, яргай зэрэг ховор болон ховордсон модыг илүүтэй хүндэтгэн хайрлаж ирсэн түүх, домог олонтой. Нутаг уснаас хамааралгүйгээр нийтлэг хэрэглэдэг нэгэн уламжлал гэвэл, ганц нэгээр ургасан онцгой содон мод, хэсэг бусад бут модыг/ийм модыг ихэнхдээ “Зуун мод”, “Мянган тоорой” гэх мэтээр өргөмжлөн нэрлэдэг/ ихэд хүндэтгэн хайрлаж хамгаалдаг уламжлал нийтлэг байв. Ийнхүү ганц нэгээр буюу хэсэгхэнээр ургасан модыг хүндэтгэн хайрладагийн учир нь дан ганц сүсэг бишрэлийн шинж утгаар байсангүй, тийнхүү ганц нэг буюу хэсэг цөөн мод үрээ ойр орчиндоо хаяж, олшрон үржих байгалийн нөхцөлийг нь хангаж өгөх ала хэтийн бодлого, арга ухааныг давхар хадгалж байсан гэлтэй.

Онцгой содон модыг “Удган мод”, “Ээж мод” гэх мэтээр нэрлэн хадаг яндар уяж нийтэд сэрэмжлүүлэн дохио тэмдэг болгон, үйс холтсыг гэмтээх, мөчирийг хугалах, таслан авахыг болон бүр дэргэд нь ойртож очихыг ч цээрлэдэг байжээ. Зуун мод, мянган тооройгоос мод авах, гишүү мөчир таслахыг ч хатуу цээрлэнэ.

Хуш мод үр самараараа байгаль дэлхийг чимж, хүн ардыг тэжээн тэтгэдэг, мөнх ногооноороо байдаг “бурханы заяат” мод гэж үзэж, түүнийг огтлох, мөчирийг хугалж гэмтээхийг туйлаас цээрлэж, самарыг бүрэн боловсорч гүйцсэн үед нь модны холтосыг гэмтээлгүй түүдэг байжээ. Холтосыг гэмтээхгүйн тулд бөс даавууны зүйлсээр ороож зөөлөлсөн модон мунаар модыг зөөлөн түншиж боргоцойг унаган авдаг заншилтай байлаа. Хан Хөхийн нурууны зон олон самар түүх модон мунаныхаа түншүүр талыг хонь, тэмээний ноосоор зөөлөвч хийж, ямааны элдсэн арьсаар бүрж бэхэлдэг байлаа.

Бургас, хайлаас, хус мод, арцыг хамгийн цэвэр ариун гэж дээдлэнэ. Голын эх, сав газрын бургасыг огтолж авахгүй, зөвхөн хитсан, унасныг түүж бургасан ойг цэвэрлэнэ. Хайлаас модыг галын үүсэл гэж хүндэлдэг. Хайласыг галын тахилгал хэрэглэнэ. Үндсээр нь аяга, таваг хийж хэрэглэнэ. Хус модыг хүн, малд буян заяа сайтай гэж сүсэглэн, түүнийг гэрийн багана, тооно, уурга, эмээл хийх төдий хэрэгцээнд маш гамтай ашиглаж үйс холтсыг гэмтээхийг ихэд цээрлэнэ. Гэтэл өдгөө “хусны шүүс” ууна хэмээн хэнээрхэж, хот суурины ойролцоох хус мод бүхэнд шахам хадаас зоож шил, лааз, битон сав дүүжилж “амьдаар нь борцолдог” болов. Арцыг ариун тансаг ургамал хэмээн заншиж үндсээр нь айраг, сүүний халбага, цэцэг, хурдан морины хусуур хийж хүндэтгэн хэрэглэдэг байв.

Зарим төрлийн ан амьтанд илүү хүндэтгэлтэй хандана. Буга, баавгай, чоно, цагаан шонхор зэрэг ховордсон амьтныг ихэд хүндэтгэн агнахыг тэр бүр хүсдэггүй, хэрэв агнах хэрэгцээ гарвал тусгайлан тогтсон жам ёсны дагуу хүндэтгэлийн ёслол үйлддэг байжээ. Монголчууд өөрсдийгөө чоно, марал бугаас гаралтай гэж төсөөлдөг. Шувууг Хан хурмастаас гаралтай, тэнгэрийн амьтан гэж хүндэтгэнэ. Начин шонхорыг боржигон овгийн шүтээн, ангирыг лам шувуу гэж хүндэтгэн, хун шувууг гоо эрхэмсэгийн бэлгэ тэмдэг хэмээн үздэг. Загасыг хэзээ ч нүдээ анидаггүй, үр төл ихтэй, үржиж төлжих нь нэн түргэн гэж дээдлэн, Монгол төрийнхээ бэлгэдэл Соёмбо тэмдгийн голд эр, эм хоёр загасыг дүрслэн байрлуулсан байдаг.

Мод, модлог ургамлаас өөр ургамалд ч энэрэл хүндэтгэлтэй хандаж, туйлын зөв зохистой ашигладаг зан заншил багагүй байжээ. Хүн орхоодой ургамлыг авч ашиглахыг “Монгол цаазын бичиг” хуулиар хориглож байсан удаа ч буй.

Жимс, самар, эмийн ургамал боловсорч гүйцэхээс өмнө нь түүдэггүй. Эмийн ургамлыг таньж мэдэх хүн шим шүүс бүрэлдэж, боловч гүйцсэнээр дараа хэрэглэх хэсгийг нь номд зааснаар нь авна.

Нялх ногоо, цэцгийг зулгаан тасалдаггүй, ногоон модны мөчрийг огтолдоггүй байв.

Хан хөхий нутгийн суугуул иргэд эмийн ургамалын бүлгэмдэлд зүй ёсоор ордог Шархны шар цэцэг нутгийнхны нэрлэдэгээр Мядагсэрчин, Алтан гагнуур буюу нутгийнхны нэршсэнээр Их өвс, Ягаан мүгээ, Вансэмбэрүү буюу Байгалийн банздоо зэрэг ургамлыг ихэд хайрлаж, шим шүүс нь бүрдсэн үед үрийг нь байгальд үлдээж түүж эмчилгээнд хэрэглэнэ.

- Амьтныг ороо нийлүүлгийн үе, төрөх цаг үед нь агнах, амьтны үүр, ичээнд ус цутгах, үр төлөө дагуулсан буюу цагаан сүүтэйгээ амьтныг болон сүргийн манлайг агнах, аливаа амьтныг сүргээр нь хомороголон буудах зэргийг ихээхэн нүгэл цээртэй үйлдэл хэмээн хориглон хэвшиж заншсан байна. Эдгээр уламжлалаас зарим нь Монголын нэн эртний төдийгүй өнөөгийн хуулиудад ч тусгалаа олж өргөмжлөгдөн үлдсэн нь бий.
- Ус бохирлохгүй байх цээрлэл монголчуудын амьдрал ахуйд гүнзгий шингэсэн юм. Усанд сүү, цагаан идээ оруулбал сүүн тэжээлт бус усны амьтад хорлолтой гэж үздэгийн гадна ус, булаг шандны эхэнд болон гуу жалганд хог новш, сэг зэм хаях, үлдээх, усанд хир буртагтай зүйл угаахыг хатуу цээрлэж ирэв. Энэ уламжлал өдгөө хөдөөгийн малчин ардууд болон хот, суурины ахмад настны дотор л үлдэж, бусдад үндсэндээ арилсан гэхэд хэлсдэхгүй.
- Монголчууд шувууг “Тэнгэрийн амьтан” хэмээн хүндлэн нэрлэж, шувууны үүрийг хөндөх, өндөг, ангаахай, дэгдээхэйд ойртож оролдохгүй байхыг үр хүүхэддээ анхааруулан хориглодог. Шувууны өндөгний үүрэнд ойртож сүүдэрээ тусгавал шувуу өндөгөө голж орхин оддог, ангаахай, дэгдээхэйгээр оролдох, тэднийг бүрэлгэх аваас “төмөр дөрөөний сэнжийг тасартал хараадаг” гэсэн сэтгэлгээнд хэвшсэн байв.
- Монгол хүн могой алахыг маш их цээрлэдэг нь зөвхөн урт настайг нь хүндэлдэг төдийгүй, байгальд тустай, байгалийг зохицуулдаг чанарт нь итгэдэг, уул усны эзэн лус “заларч” явна гэж үздэгт оршдог бололтой. Могой муулсан хүн насаараа “зовлонд” учирна гэж ч сургадаг.

Могойн чуулган нэн сүртэй агаад хэн хүнтэй тэр бүрий тааралддаггүй, тийм чуулгыг үзсэн хүн ховор, хэрэв үзвэл ихэд буян авчирдаг гэх яриа машид дэлгэрсэн. Могойн чуулга үзсэн хүний хуучилсныг сонсоод ихэд гайхаж, сонирхсоноо эрдэмтэн Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл нар ийнхүү бичжээ.

Могойн чуулга болох нь нутаг усныханд мэдрэгддэг гэнэ. Могой олон, цөөнөөрөө иэг зүгт яваад байвал чуулга болохын шинж, Чуулга болсны дараа байгаль дэлхий, цаг агаарт сайхан өөрчлөлт гарна. Чуулсан үед могойг алж устгавал тэр нутаг усанд болон алсан этгээдэд нэн тааламжгүй, бүр гай гамшигт явдал тохиолддог аж. Тийм учрал болсон тухай үнэн яриа бас бий.

Сургаал номлолын уламжлал

Энэ бол энэрэл хүндэтгэл, хорио цээрлэл, байгалийн жам ёсыг танин мэдүүлэх, байгалийг хамгаалж, арвигч хямгагч ашиглах арга ухааныг хүний ой тойнд суулгаж хэвшүүлэх зан үйл мөн.

Онцлог нь эцэг эх нь үр хүүхэд, ах эгч нь дүү нартаа, ахмад буурлууд нь залуучууддаа үеэс үед заан сургаж, тэд хүндэтгэн хүлээн авч сахин дагаж хэвшил болгож ирсэнд оршино. Сургаал номлол танхимд хичээл заадаг одоогийнхтой адил байгаагүй нь ойлгомжтой. Амьдрал ахуйгаас үүдэлтэй олон янз арга ухааныг хэрэглэдэг байжээ.

Гол төлөв хэлж ярих, биеэр үлгэрлэх, зааж сургахын зэрэгцээ үлгэр туульс, ерөөл магтаал, дуу хуур, зүйр цэцэн үг зэрэг арвин баялаг аман зохиол, ардын тоглоом, наадгайгаар хүртэл дамжуулан хүн ардад хүргэж, тэднийг уламжлалт болон шинэ мэдлэгээр цэнэглэж, дадлагажуулан хэвшүүлэх арга, хэлбэрийг өргөн ашигладаг байв.

Үлгэр, туульс, домог гэхэд л ой, ургамал, ан амьтнаар арвин баялаг хангай дэлхийг магтан түүгээр бахархаж аз хийморттой, баян тансаг амьдардаг тухай, мод, ургамал хугалж тасалж, ан амьтныг хамаа бусаар агнаж, хорлож оролдвол гай гамшигт учирч зовж тарчилдаг тухай өгүүлдэгийг хүүхэд ихэд сонирхон сонсож, сайн, муу үйлийг ялган салгаж ухаардаг аж.

Сургаал номлолын уламжлалын хүрээнд өрх гэрийн хүмүүжлийг илүү чухалчилдаг байсан нь судалгаанаас ажиглагддаг. Энэ нь *сургаж мэдүүлэх, арга билэг эзэмшүүлэх* хоёр аргад тулгуурлаж байжээ.

Сургаж мэдүүлэх нь монголчууд ямар заншилыг илүүтэй эрхэмлэдэг, нийтийн хорио цээр юу юу байдаг, ан агнах, мод түлээ, жимс, сонгино, самар, ургамлыг хэрхэн түүж ашигладаг тухай уугуул нутгийнхны мэдлэг, яриаг үр хүүхэддээ хэлж ярьж сургадаг бол арга билэг нь аав ээж нь үр хүүхэддээ биеэр үлгэрлэх явдал байжээ. “Арга” нь аавын үлгэрлэл, “билэг” нь ээжийн үлгэрлэл гэж үздэг.

Монгол Алтайн ураанхайчуудын дунд байгаль эхээ магтан дуулсан ардын олон сайхан дуу бий. Дууны нэр нь хүртэл тэр аяараа байгаль дэлхийн эгшиглэн. Жишээ нь, “Баянцагаан нутаг”, “Хан уулын орой”, “Гурван зүгтээ сантай гурвалжин их алтай”, “Үлэмж баян нутаг” гэх мэт. Эдгээр дуунуудыг хуримын ёслол мэт хүндэтгэлийн их найранд дуулдаг. Тэр нь амьдрал ахуй, аз хийморио байгалтайгаа хуваалцаж, байгаль эхдээ даатгаж байгаа сэтгэлгээний нэгэн илрэл ажээ.

Монголчууд ургамлыг сайтар таньж мэддэг, ургамлыг эвшил, бүлгэмдлээр нь ялгах их мэдлэгтэй, түүнийгээ үе залгамжилж нэрийг нь хүртэл самуурч солихгүйгээр дамжуулдаг сайхан чанартай. Энэ талаараа мэргэжсэн эрдэмтэдээс ч огт дутдаггүй хашир туршлагатай хүмүүс ахмад үеийн дотор олон байдаг. Энэ утгаараа ургамлын эвшил, хэвшлийнх нь нэрээр, бүлгэмдлийн нэрээр нь нэрлэсэн газар усны/газар зүйн/ нэр олон бий. Жишээ нь, Харганат, хайлааст, улиаст, бургаст, хуст, яргайт, хармагт, сонгинот, моност, хушт, нарст, бүйлэст, гүйлэст, тооройт, дэрст гэх мэт.

Сүсэг бишрэлийн уламжлал

Эртний шүтлэгийн хэлбэрүүдээс эхлээд бурхны шашны номлол, ёс жаяг ардын зан заншилтай харилцан сүлбэлдэж байгальд хандах эерэг сэтгэлгээ суулгах арга ухаан юм.

Энэхүү уламжлал нь байгаль дэлхийн бүх жам ёсыг цаанаа харсан эзэн бүхий далдын их хүчний ид шид хэмээн итгэж, түүнд амь амьдралаа залбирал, мөргөл, тарни шившлэгээр хүргэж чадваас өлзий буянаа хайрлаж, амар сайхан аж төрж болно гэсэн итгэл, сэтгэлгээний зан үйлүүдээр илэрч байжээ. Тиймээс ч өмнө өгүүлсэн зан үйлүүд бүгд л сүсэг бишрэлтэй хосолж байсан байна.

Бишрэл итгэлийн хоёр гол зангилаа байсан, нэг нь сайн үйлээр сайн сайхныг олж авах, нөгөө нь муу үйлээр хорлолд өртөх. Илэрч байсан түгээмэл зан үйл гэвэл:

- залбирал хүндэтгэл үзүүлэх
- тайллага, тахилга үйлдэх
- ном судар бүтээх
- судар, тарни унших, шившлэг үйлдэх
- бөө бөөлөх
- мэрэг төлөг тавих
- нүглийг тэвчих гэх мэт

Онцлог нь ямар нэг шашин шүтлэггүй гэж өөрийгээ үздэг хүнээс эхлээд бүх нийтээрээ энэ зан үйлийг дагаж хэвшсэнд оршино. Ганцхан жишээ л гэхэд тахилгат овоонд очсон хэн ч гэсэн чулуу өргөж сэтгэл санаагаа ариусгана, төрөлх уул усандаа залбирна, төрсөн бууцан дээрээ хөрвөөнө, угаасан усаа амсана, толгойдоо хүргэнэ, алс хол одохдоо нутгийн чулуу, шороо авч явна. Ингэж уул, усаа байгаль дэлхийгээ шүтэх ёс эртнээс дэлгэрчээ. Шүтэх ёсон шашны сургаал номлолд уусан шингэж сүсэг бишрэл болсон холбоостой.

- Монголчууд амьтан, ургамалаа адуу мал шигээ шүтэн хайрлаж хамгаалсаар ирсэн түүх домог, баримт жишээ тун арвинтай. Ялангуяа буга, баавгайг туйлаас бишрэн цөөн нэг хоёрыг ашиглах бол шашин шүтлэгтэйгээ хослуулсан зан үйл үйлддэг.

Дархад ястанууд буга намнасан бол эврийг нь газар хүргэлгүй авч ондор модон дээр залан тавьж гурав, дараа нь хангай дэлхийдээ гурав тус тус мөргөөд ерөөлийн үг хэлдэг, эврийг гартаа барьж морио унаад гэртээ харьдаг, гэрийн эзэгтэй нэхрийгээ ирж явааг хараад морины уяаны дэргэд очиж хормойгоо дэвсэн, малгайгаа авч сахрон сууж хүлээдэг. Нөхөр нь ирж эврийг эхиртээ өгөхөд тосч аваад:

Ай Айтай хангай минь

Хайнаг шар юм билүү

Монгол шар юм билүү

Нэг шараа хайрлажээ гэж хэлээд эвэрт гурав мөргөж, түүнийг авч гэртээ орж баруун талаар өгсөж хоймортоо босоо байдлаар тавьдаг тухай Угсаатны зүй судлаач-эрдэмтэн С.Бадамхатан агсан бичсэн байдаг билээ. /Хөвсгөлийн дархад ястан. УБ., 1965, 112-р талд/

Буга хайрлан хүндэтгэх энэ уламжлалт зан үйл өдгөө хаана ч гэсэн ор мөргүй арилж, бугаар ашиг хонжоо эрэлхийлэгчид түүнийг хэригийгээр хядах арга сүвэгчилдэг болсон нь туйлын харамсалтай хэрэг.

- Баавгайг ойн эзэн, ойгоо өсөн үржихийн билэгдэл гэж мөн л шашин шүтлэгтэйгээ хослон бишэрдэг. Баавгай агнасан анчин:

Хайрхан минь агнах гэж алсангүй билээ

Сум тэнгэж оносон байна

Цаг үе хүйтгэрч

Бие махбодь маань даардаг боллоо

Илчээ хайрлана уу гэжт ерөөл хэлж, мөн л хангай дэлхийдээ дөрвөн зүг гурав гурав мөргөдөг байжээ.

Ургамал ашиглах, хамгаалах арга ажиллагааг мөн л шашин шүтлэгтэй хослоно.

Зэрлэг сонгиныг үр нь гүйцэд боловсорч гүйцээгүй байхад үндэс, булцуугаар нь ухаж түүхийг цээрлэнэ. Зөрчвөөс лус хилэгнэнэ, догширно гэдэг.

Зуны дэлгэр цагт /жасааны үед/ жамъянмядаг цэцгийг бумбанд хийж бурханы өмнө тавихад цэцгийн тоогоор зул өргөсөн адил буян болно гэдэг.

Вансэмбэрүүг хосоор нь авдаг, өнчин үлдээдэггүй. Үрийг нь унаж дуусахыг алсаас дурандаж байгаад намрын адаг сард тусгай өдөр ойролцоо очиж хоноод дээр нь майхан /жодгор/ барьж хурмастаас нууж, ном уншиж өглөгөө өгөөд тусгай ухах модон ухуураар газраас салгаж хосоор нь авна.

Уул овоо тайх тахиглах, овоо тахих ёсон шашин шүтлэгийн зан үйлгүйгээр хийгдэнэ гэж ерөөс байсангүй. Алтай ханы сан тахил өргөх ёслолын сударт:

Онгон модыг огтлох, догшин газрыг малтах хийгээд

Олон гөрөөсний амь бүрэлгэх, тангаргын үг алдах, сүр хиншүү тавих

Дээрхийн бурхны таалалд харшилсаныг үтэр түргэн чин зүрхнээсээ залбиран

Дээдийн эндэл болсон гэмийн бараан үүлсийн чуулганыг

Зориуд гэмшихүй сэтгэлээр боомтлон, хуй салхиар үлдэн хөөж

Зоригдол үгүй сацралаас хагацсаны агаарт наминчлан үйлдсэнээр

Зохилдлогогүй доройтлын орноос ялгуун болтугай хэмээн ургамал, амьтан сүйтгэсэн нүгэлээ цагаатган өршөөж өгөхийг ном судраараа уламжлан гуйдаг сэтгэлгээг илэрхийлжээ.

Байгальтайгаа ханьсан нөхөрлөж, ижилдэн дасаж, сүслэн эрхэмлэж ирсэн монголчуудын сүсэг бишрэлийн уламжлалт зан заншил бүхэлдээ хүн гэгээрэхийн сургаал, арга ухаан байсаар ирсэн, цааш. Ч байх болно.

"Гэгээрэхийг тэмүүлсэн хүн сургаал зарлаг, сэтгэл төвлөрүүлэх ёс, овоун ухаан хэмээсэн гурван эрдмийг өөрийн болгах хэрэгтэй" гэж Бурхан багш сургаал, цааш нь энэхүү гурван эрдэмд сурах таван хүчийг сүсэгтэх, итгэх, үйл хэрэгээ бодож эргэцүүлэх, бясалгах, овоун ухаанаа гэгээрүүлэх явдал мөн хэмээжээ. (Бурхан багшийн сургаал, Анхдугаар хэвлэл, 1996 он., "Косайдо" Со., Ltd. Токио, Япон улс. 175, 180-р талд)

Ус ашиглах арга ажиллагаагаа мөн л сүсэг бишрэлтэй уялдуулана.

Өвөг дээдэс булаг шандыг ариун ус, лусын орон гэж хүндлэн дээдэлж юм угаах; бохир саваар ус хутгах нь цээртэй, хэрэв усаар нь юм угаах болвол саванд ус ивч хол зайдуу нам доор газарт аваачиж угаадсыг усанд эргэж орхооргүй урсгаж угаал

хөдөлгөөнийг ажиглаж цаг уурын байдалд үнэ шинэ хийлгэж байсан.

- Монгол хүн мал сүргийнхээ болон шувуу, бусад амьтан, өвс ургамлын үйл хөдөлгөөнийг ажиглаж цаг уурын байдалд үнэ шинэ хийлгэж байсан.
- Нар, сар хүрээдэйг нас орж салхи ширүүсэхийн тэмцэг гэх мэтээр сэтгэж
- Салхи урд зүгтээ уриал байвал тэнгэр муухайрахыг дохио,
- Тэнгэрийн хаяа улайж нар шингэвсээс маргааш салхан өдөр болохыг шинж,
- баримжаагаж өвөлжилт, хаваржилтаа пэхээс бэлтгэл,
- Намрын дунд сарын арван тавны сарыг шөнө дурвдаж ирэх өмийн цаг уурын байдалыг
- цаг агаарын өөрчлөлт хувиралыг шинжиж иржээ.
- Монголчууд нар, сар, од эрхис, салхины авсрын шинж төрхөөр байгаль

Энэ эртнээс амьдрал ахуйн нөр их түршлэл, мэдлэгээрээ байгалийн ашиглан танин мэдэж хүрмэлтгүүрсэн мэдлэгийн сан нь баяжин арвижсаар сүүдэр олон зурахийн ухаанаар даяар батлалсан нүүдэлчин аж байлмын өөрчлөлтийг ургамал бишрэхгүй байхыг артай. Монгол хүн байгалийн хувьсал өөрчлөлийг тэнгэр эрхийн байдал, мал сүрэг, ан амьтан, өвс ургамлын үйл хөдөл, өөрийн бие сэтгээр шинжин дүгнэж алахаасаа үнэн илүүтэй хүрээг ирсэн сонирхол татахуйц мэдлэгтэй хувьд суурин соёл иргэний бүхий хүн ардаас ялгарах онцлогтой. Энэ нь мунхаг харанхуйн шинж биш, ахуйд илүү ойртсон уламжлалт мэдлэг мөн.

Ажиглалт, танин мэдэхүйн уламжлал

Цаг агаарын хувьсал өөрчлөлт, байгалийн гэмжилт үзэгдэлт ажиглалт, танин мэдэхүйн арга ухаанаар урьдаас мэдэрч, амьдрал ахуй, амьт төрлөө тохируулж, байгальтай зохицон аж төрөх нүүдэлчин аргын баялаг мэдлэгтэй өвсөн юм.

үйлдэнэ. Рашаан, булаг шандын усанд сүү, цагаан идээ оруулж цус/улай/, савс, бүртгэл дусаахыг ихэд жигшинэ. Тэгэхээр ус авах шанага саваа сайтар угаах пэвэрлэгт ёс заншил ард түмний дотор хууль ашиг тогтоосон байдал.

Монголчуудын байгаль орны уламжлалын ач тусыг тална орны эрдэмтэд үзэгдэн бичсэн нь бас бий. ОХУ-ын Монгол судлалын эрдэмтэн А.С. Железняков “Нүүдлийн мал аж ахуй хүрээлэн буй орныг бохирдоггүй, цэвэр байх нөхцөлд л хөгжиж болох юм. Монголчуудын... хэрэгцээнийх нь хэмжээ хязгаартай байсан

болит байлалын нэрхнийгээ болж байдалт оршино.

Ажиллагт, танин мэдэхүйн уламжлалын онцлог нь хүн гээч амьтан

байвал пас, бороо орохын шинж гэж үздэг аж.

Хөтшгийн хүзүү сээр хөтш, гар хөл дарах, бэртэнг өвдөх байдал илрээд

нь тэнгэр мүүхэйрхын дохио,

Ганс бөтлөр бөх шоржигдох, тэрийн хялгасан бүслүүр, оосор бүр чивэрэх

байвал хүр бороо элбэгшин шинж,

Тэрийн улаа элбэгээр гарч байвал тэнгэр сайхан байхын, гар хавьтаа хортоолол

Тоононы хөө улайрч ямаараал байвал тэнгэр зохиурч дулаарахын шинж

урьчинлан таамаглаг заншилтай.

хөтшгийн биег гарах өөрчлөлтөөр ч байгал, цаг агаарын байлалт

• Монголчууд өдөр тутмынхаа амьдрал ахуйн ердийн үзэгдэл, өвдөл

улахгүй болохын дохио гэж мэддэг.

хөтлөх, хүчтэй салхи шүүртэ тавих, үер болох зэрэг байгалийн гамшиг, аюул

мөөрөлдөх мэтний хэвийн бүс байдал өдөр дараалан давтагдвал байвал газар

Нохой, мүүр гийнаж гасгах, гэр орноосоо дайжин хөндийрөх, мал сүрэг майлах,

эрт эхэлж, хахир хатуу өвөл болохын шинж,

хулан лав толгол, уулархаг нутаг барагдал байвал өвлийн улирал цагаасаа

Өвс урмаг эрт гантаж эхэлбэл, мөн говь хээр талын амьтал, цагаан зээр,

Хулана зурам хөөсө их хураавал хүйтэн өвөл болохын сүр,

шинж,

Хөхөө шүүр эрт донтоловол зүйн богино болж, үрт сайхан намар болохын

Хараахай шүүр дээгүүр ниссэж байвал тэнгэр сайхан байхын тэмдэг

Үхэр бэлгээрт гарах дүртэй хотондоо хортоолол байвал улахгүй хүйтэрхний дохио,

байвал тэнгэр дулаан сайхан байхын шинж,

Саргал үхэр үзлэн хир өндөр газар, адуу бол талар тавиан бэлгээрээд

боловч байгаль хамгаалалтын нааштай байдал илүү чухал байлаа. Монголчууд хосгүй ландшафт байгуулсан нь хамгийн тэргүүний соёл иргэншлийн ололт амжилтуудтай харьцуулж болох явдал юм. ...дэлхий ертөнцийн тал болон цөлийн бүс нутагт экологийн тэнцвэртэй байдлыг хангахад шаардлагатай монголчуудын хөдөлмөрийн арга барил, уламжлалт мэдлэг нийт хүн төрөлхтний хэмжээнд чухал ач холбогдолтой” гэжээ. /Mongolia an international annual of Mongol studies. Vol. G[27], 1995, p.513/

III. Уламжлалт хууль цааз

Уламжлал хэвшин тогтноход зан үйл, шашин хүчтэй нөлөө үзүүлсэний зэрэгцээ хууль цааз бас чухал үүрэг гүйцэтгэсэн нь судалгаанаас ажиглагддаг. Монголын төр нэн эртнээс хууль цаазны уламжлал арвинтай. Тэр дотроо эртний Монгол хаадын хууль цаазад байгаль орчин, ургамал, ан амьтнаа хамгаалах, зохистой ашиглах эрх зүйн олон тооны хэм хэмжээ агуулагдсан байх юм.

Тэрхүү хууль цаазны хамгийн гол онцлог нь өмнө өгүүлсэн байгаль хамгаалах уламжлалт зан үйлүүдээс нэлээдийг нь хуулийн хэм хэмжээ болгон тогтоож, зөрчсөн тохиолдолд хатуухан шиг шийтгэл оногдуулж байхаар заасан явдалд оршино. Өөрөөр хэлбэл Монголын эртний их, бага хаадын үеийн хуулиуд монголчуудын зан заншил, ёс суртахууны шилдэг охийг уламжлан авч төрийн зүгээс эрх зүйн хэм хэмжээ болгон хуульчилж амьдралд хэрэгжүүлж чадсан юм. Энэ нь уламжлалт зан заншилд тулгуурласан хууль хүн ардын ухаарал, сэтгэлгээнд хамгийн ойр байж зөрчигдөх нь ховор төдийгүй уламжлалыг хууль цаазтай хослосон цагт аль алиныхаа хүч чадлыг харилцан шүтэлцэж чадлагийн үлгэр дуурайлал гэж хэлж болно. Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалахад энэ нь бүр ч тодорхой харагдаж байв. Зарим жишээг авч үзвэл:

Уламжлалыг бүхэлд нь хураангуйлан хэлбэл, Монгол улс байгаль дэлхийгээ цогцлоор нь төдийгүй, түүний онцын чухал бүтэц болж байдаг газар хөрс, өвс ургамал, ан амьтан, амьд бүхний ундаа болсон усыг хамгаалах, хамгийн зохистой ашиглах талаар нэн эртнээс зан заншил, шашин шүтлэг, хууль цаазны *маш нарийн, өвөрмоц тогтолцоо бүрдүүлсэн* орон мөн. Ийм улс орон цөөн, магадгүй монголоос өөр байгаагүй ч байж мэднэ.

IV. Уламжлалыг дэмжин сэргээж дэлгэрүүлэх ажлын өнөөгийн байдал

Байгаль хамгаалах уламжлалын үнэ цэнийг зохих ёсоор үнэлж, сэргээх, дэлгэрүүлэн түгээх асуудлыг Монголын төр, засаг түүний удирдлагууд, ард олон ихээхэн дэмжиж байна. Бүр төрийн бодлого болгон дэлгэрүүлэх тухай хуульд ч зарим заалт оржээ.

Харин хэрэг дээрээ уг ажил нэлээд хойрго, хүсэн хүлээсэн хэмжээнд хүрэхгүй байна. Уламжлал алдагдсан, мартагдсан, эс хайхарсан зэрэг сөрөг үзэгдлээс шалтгаалан түүнийг хэрэглэх, дэлгэрүүлэх, сургаж хэвшүүлэх арга ажиллагааны хувьд дутагдал их байна. Байгалийн баялагт, тэр дотроо биологийн төрөл зүйлд ашиглалт, хамгаалалтын зохисгүй ажиллагаа газар авч, хууль тогтоомж зөрчигдөх нь ч их байна. Байгаль орчны төлөв байдлын тухай Засгийн газрын 2001, 2002 оны тайланд орсон зарим баримтаас:

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МОНГОЛ УЛАМЖЛАЛЫГ СЭРГЭЭН ДЭНГЭРҮҮЛЭХ АСУУДАЛД

Газар	Байгалийн ургамал	Амьтны аймаг
<p>Бэлчээрийн 70 гаруй хувь нь талхлагдвалд орж, ургамлын номрог хомсдоор байна. Сүүлийн 40 гаруй жилийн хугацаанд зарим нутгийн бэлчээрийн ургамлын ургалц 5 хүртэл бахир буурч, нэгж талбайд оногдох ургамлын зүйлийн тоо 6 хүртэл бахир цөөрчээ.</p> <p>Газар тариаланд ашиглагдаж ирсэн 1,3 сая га талбайн 565,0 мянган га газар атаршиж ашиглалтаас хасагджээ. Сүүлийн жилүүдэд 1 сая гаруй га талбай бүхий газар хөрсний элэгдэл, эвдрэлд оржээ.</p>	<p>Ой, хээрийн түймэрт олон сая га талбай нэрэгдсэний дотор 300 орчим мянган га талбайн ой ургах чадвараа алджээ.</p> <p>Монголд устгах аюулд орсон, ховордсон 400 гаруй зүйл ургамал байгаа.</p> <p>Манай оронд элсний нүүдэл ихэсч, цөлжиж буй газрын талбай жилээ жилд улам нэмэгдэж, ойн сангийн эзлэх талбай 30 жилийн өмнөхөөс 1,44 сая га-аар буурчээ.</p> <p>Нийт нутаг дэвсгэрийн 42,5 хувьд цөлжилт нүүрлээд байна.</p>	<p>2001 оны байдлаар 100 гаруй амьтан устгах аюулд ороод байна. Хавтгай 400 толгой, мазаалай ердөө 20-25 толгой үлджээ.</p> <p>Монголд 30 зүйл шувуу ховордон устгах аюулд ороод байгаа аж.</p>

Байгаль орчны хуулийн зөрчил

2001 онд гарсан зөрчил өмнөх оньхоос 17,5 хувиар өссөн байна. Хуулийн байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн байгаль хамгаалалын эсрэг хэрэг зөрчлийн тоо 2001 онд өмнөх оньхоос 36,7 хувиар нэмэгджээ.

Дээрх сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгахад эдийн засгийн хүндрэл нөлөөлж байгаа нь мэдээж. Гэхдээ уламжлалыг сэргээх, сургах, хэвшүүлэх ажиллагаа хоцрогдож байгаа нь нэлээд жин даран шалтгаан гэж үзвэл зохино.

Байгаль орчныг хамгаалах монгол уламжлалыг судлах ажил сүүлийн жилүүдэд түүх, хэл шинжлэл, хууль зүй, шашин судлалын хүрээнд өргөжих хандлага ажиглагдаж байгаа нь маш сайн хэрэг. Гэвч эхлэл төдий байна. Хэрэгтэй, үр ашигтай зүйл гэдэгт судлаачид, эрдэмтэд, практик ажилтнууд ч санал нэгдэж байгаа учир судалгааны ажлыг улам гүнзгийрүүлж, сургах, дэлгэрүүлэх явдал тулгамдсан асуудал гэдэг нь ойлгомжтой.

Монгол Улсын Засгийн газар 1997 онд 255 дугаар тогтоолоор “Бүх нийтийн экологийн боловсрол” үндэсний хөтөлбөр баталж, бүх нийтэд экологийн боловсрол олгох арга, хэлбэрийн хувьд шинэ механизм бүрдүүлэх, хүн амын эрэлт, хэрэгцээг хангах бүтэц, удирдлага, зохион байгуулалтыг бий болгох, үйлчилгээний хүрээ, чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилт тавьж түүнээ хэрэгжүүлэх олон арга хэмжээг төлөвлөсөн

боловч биелэлт тун хангалтгүй хөтөлбөрийн хугацааны эхний үе шат /1998-2005он/ дуусах дөхөж байна. Энэхүү хөтөлбөрт байгаль хамгаалах уламжлалын асуудлыг үндсэнд нь орхигдуулсан. Зүй нь бүх нийтийн экологийн боловсролын хүрээнд уг асуудал чухал байр суурь эзлэх ёстой. Гэтэл орхигдуулсан нь уламжлалыг эзэмшүүлэх, түгээх, төлөвшүүлэх ажлыг төрийн бодлогын хэмжээнд тавьсан хуулийн болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг Засгийн газар хэрхэн анхааралдаа авч байсны баримт гэлтэй.

Уламжлалыг сэргээх, дэлгэрүүлэх ажил өнөөгийн төвшинд ярихаас хэтрэхгүй байна. Ерөнхий боловсролын сургуулиудад заавал судлах “Экологи” хичээлийн үлгэрчилсэн хөтөлбөрийг хэдэн жилийн өмнө гаргасан боловч уламжлалын тухай бараг дуугарсангүй. Одоо түүнийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай. Багш нарт заах аргын зөвлөмж ч өгөх хэрэгтэй байна.

Ер нь Монголын боловсролын бүхий л тогтолцоонд дороос нь дээр нь хүртэл байгаль хамгааллын уламжлалыг сэргээн сургах, дэлгэрүүлэх тухайд үнэхээр харагдахуйц үсрэлт хийх цаг болжээ. Цаг алдвал улам ихийг алдана.

Уламжлалыг сэргээх, дэлгэрүүлэх хамгийн ойрын бөгөөд тааламжтай орчин бол улсын тусгай хамгаалалттай газар нутаг, түүний хамгаалалтын захиргаа гэдэгтэй санаа нийлэх хүн олон гэж бодном. Тэнд үлгэр жишээч ажил үйлс оргилж байх учиртай. Их ажлын эхлэлийн цэг болох ёстой.

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт биологийн төрөл зүйлийг хамгаалах менежментийг уламжлалтай холбох боломж асар их бий. Гэтэл Байгаль орчны яам ер дуугарахгүй байгаагийн учир шалтгааныг хэн тайлах вэ? хууль, төрийн бодлогын бусад баримт бичгийн заалтаа юунаас эхлэж, яаж биелүүлэх гээд байгаагийн хариуг хэн өгөх вэ? Бид чухам үүнийг л хүсэж сууна.

V. Уламжлалыг дэлгэрүүлэх, дэмжих ажлын цаашдын чиг хандлага

Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалж зохистой ашиглах, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулахад уламжлалт зан заншил, шашин шүтлэг, мэдлэг, арга технологийг нийтэд нь төдийгүй, нутаг нутгийн онцлогоос хамааруулан хэрэглэх нь багагүй үр дүнтэй арга хэрэгсэл болно. Төр, засгийн бодлого ч тийм байна. Шилжилтийн эдийн засагтай манай орны нөхцөлд байгаль хамгаалах

хүмүүсийн сэтгэлгээг одоогийн хүрсэн мэдлэг, чадвар дээр нь шинэ мэдлэг, мэдээллээр нэмж өгөх зайлшгүй хэрэгцээтэй.

Байгаль хамгаалах уламжлалыг дэмжих, дэлгэрүүлэх ажлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсноор төрийн бодлогын төвшинд тавьсан, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар иргэн бүрийн үүрэг болгосон, ач холбогдлыг нь олон улсын хэмжээнд өндрөөр үнэлсэн байдлаас үүдэлтэйгээр энэ ажлыг зохион байгуулан хэрэгжүүлэхэд одоо чухам ямар асуудлуудад анхаарал төвлөрүүлбэл зохих вэ? Бид зарим зүйлсийг санал болгох нь судалгаа шинжилгээ, практикийн ач холбогдолтой гэж үзэв. Үүнд:

1. Уламжлалд оюуны өмчийн хамгаалалт тогтоох. Энэ ажил нарийн түвэгтэй байж болно. Учир нь уламжлалт зан үйл бүр оноосон тодорхой зохиогч байхгүй. Өнөөгийн байдлаар Монголд төдийгүй, аливаа улс оронд уламжлалыг оюуны өмчийн хамгаалалтад авсан арга ажиллагаа төдийлэн мэдрэгдэхгүй байна. Оюуны өмчийн хамгаалалтад авахын тулд юу хийх вэ? гэвэл:
 - Нийтийн амьдрал ахуйд хамгийн их түгэн дэлгэрсэн,
 - Тухайн нутаг оронд хамгийн их хэрэглэгддэг гэсэн хоёр шалгуураар уламжлалаас сонгон авах ажлыг эхлээд хийх.

Дараа нь тэдгээрээс хамгийн илүү үр ашиг өгдөгийг шилж агаад улсын хэмжээнд дэмжин дэлгэрүүлэх, тухайн орон нутагт нь дэмжин дэлгэрүүлэх гэсэн төрлөөр Оюуны өмчийн газарт бүртгэх ажлыг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах. Ингэсэн нөхцөлд “уламжлал” гэж ерөнхий ярихгүй, хаана, юут, хэрхэн дэлгэрүүлэх тодорхой зүйлтэй болж, тодорхой зүйл дээр ярьж, үр дүнг нарийн тооцох боломж бүрдэнэ.

2. Уламжлалыг дэмжих, дэлгэрүүлэх арга ажиллагаанд материаллаг урамшуулал олгох арга хэмжээг Засгийн газраас тусгайлан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх. Энд уламжлалын судалгаа, сургалт, практикт хэрэгжүүлж буй ажил, үзүүлж буй үр дүн гэх мэт бүх талыг хамарсан, өндөр шагнал урамшилтай байх нь зохистой.
3. Уламжлалын судалгаа, сургалт, түгээлтийг зохион байгуулж, хэрэгжүүлэх ажил өнөөгийн байдлаар үндсэнлээ эзэнгүйшж байгаа нь ноцтой дутагдал болж байна. Иймээс уг ажлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хариуцдаг, хийдэг эзэн хэрэгтэй. Тэр нь төрийн байгууллага биш, харин байгаль орчныг хамгаалах төрийн бус байгууллага, Бурханы шашны байгууллагын хослол дунд хариуцуулах нь зохимжтой. Олон улсад ийм туршлага байдагийг ч бодолцох нь зүйтэй. Ийм байгууллагаар тухайлбал Монголын байгаль орчныг хамгаалах холбоо, Гандан тэгчилэн хийдийг сонгон

авах нь зохистой гэж санагдана. Зохион байгуулалт, санхүүжилт зэрэг зайлшгүй асуудлыг шийдвэрлэж Засгийн газар тусгайлан шийдвэр гаргах шаардлага ч тулгарна.

4. Уламжлалын асуудлаар тусгайлан төсөл боловсруулж, хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг олох арга хэмжээ авах. Ер нь Улсын Их Хурлаас баталсан үндэсний хөтөлбөртэй байх асуудлыг бодож санаачлан зохион байгуулахад болохгүй гэх газаргүй гэж үзэж байна.
5. Албан болон албан бус боловсролын тогтолцоонд байгаль хамгаалах уламжлалын сургалтыг зориуд тусгайлан авч үзэх нь зүйтэй. Тэгэхдээ:
 - Хүүхдийн цэцэрлэгт байгаль хамгаалах уламжлалын сургалтын хөтөлбөртэй болгож, багаас нь эхлэн мэдлэг дадлага, хэвшил суулгах,
 - Ерөнхий боловсролын сургуульд тусгай хичээл үздэг болох, түүний сурах бичиг зохион гаргах,
 - Зайнаас сургах сургалтад сургалтын хөтөлбөр боловсруулж, гарын авлага хэвлүүлэх,
 - Их, дээд сургуульд үздэг “Экологи, байгаль хамгаалал” хичээлийн хөтөлбөрт уламжлалын асуудлыг тусгайлан оруулж зааж байх,
 - Уламжлал заах багш нарын сургалтыг богино хугацаагаар хийх,
 - Өрх-гэр бүлийн дотор уламжлалын сургалт явуулдаг хөтөлбөр, аргачлал гаргаж хэрэгжүүлэх.
 - Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаалад орчны бүсэд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрийг газар нутгийн онцлог байдалд зохицуулан боловсруулж хэрэгжүүлэх зэрэг тулгамдсан асуудлыг хамааруулах шаардлагатай.
6. Уламжлалыг радио, телевизээр сурталчилдаг нэвтрүүлгийн цагийг өдөр бүр хэд хэдэн удаагийн давталттайгаар богино хугацаатай байхаар бий болгож тогтмолжуулах нь зүйтэй.
7. Нийслэлтээс эхлээд аливаа хот, сууринд оршин суудаг иргэдийг ахуйн хог хаягдлаар хөрс, ургамал, ус бохирдуулдаг хамгийн зохисгүй зуршлаас нь салгаж, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийг сайтар хэрэгжүүлэхийн тулд уламжлалын самбар, реклам бий болгож хэрэглэх нь тийм ч жижиг зүйл биш гэж бодож байна.

шийдвэрлэх асуудал олон байхаас гадна Пано Карпини ажиглаж тэмдэглэснээр Дунай мөрнөөс алс наран мандах зүг хүртэл үргэлжлэх Скифи нутгийг эзэмшиж байсан монголчууд гэхэд л байнгын суурьшсан нутаг газар гэж байгаагүй, цаашдаа тэнд энд суурьшина гэдгийг мэддэггүй³ байсан учраас ус ургамлын төлөөх тэмцэл, зөрчил ч мөн байнга гарч байсан байна. Байгалийн энэ нөхцөл байдал нь газар төрийн өмчлөлд байх нэг шалтгаан болж байсан мэт санагдана. Тийм учраас ази дорно дахинд өмчлөлийн агуулга хамтын хөдөлмөрийн үр дүнгээс хамаарч байсан учраас газар дахь төрийн өмчлөл нь төрийн эрх мэдлийн гол үүрэг, үзэгдэл нь гэж хэлж болохоор байна.

Хэмжээгүй эрхт ёс өмчлөгчидгүй бүтцэд л оршдог бөгөөд тийм тогтолцоонд өмчлөх эрхийн үзэл хэрэг дээрээ байдаггүй ажээ. Харин хүн ард нь багтаж буй нийгмийн бүлгийнхээ хүрээнд баялгийг ашиглах эрхийн төсөөллийг л бий болгож байсан байна. Тийм ч учраас орчин үеийн иргэний нийгмийн онолоор дарангуйллын тогтолцоог хаах үндсэн арга- өмчийн олон хэлбэрт суурилсан ашиг сонирхолоороо задран хуваагдсан иргэний нийгмийн бүтцийг бүрдүүлэхийг ардчиллыг хамгаалах, хөгжүүлэх гол арга хэрэгсэл гэж үзэж байна.

Азийн үйлдвэрлэлийн аргын энэ онцлогоос хамаарч ази-дорно дахины орнуудад өмчлөх эрхийн сэтгэлгээ нь европ дахин шиг хөгжөөгүй учраас хувийн өмчид тулгуурлан хөгждөг хүний эрхийн бусад институтууд ч удаан хөгжсөн, хожим хөгжиж эхэлсэн билээ.

Монголчуудын хувьд тэнгэр эцэг, газар эх хэмээх эрхэмийн дээд их ёсыг дагаж газар нутгийг хүн бүрийн халдашгүй дархан эзэмшилд хадгалж, дээд өмчлөгчдийг төр засаг хэмээн дээдэлж ирсэн уламжлалтай. Энэ тухай Академич Ш.Нацагдорж асан "...монголд газар нь дорно зүгийн орон лугаа нэгэн адил гол төлөв улсын өмч байжээ"⁴ гэж тэмдэглэсэн байна. Чухам үүний улмаас өргөн уудам нутагт цөөн тооны нүүдэлчин монголчууд эв зөийн ёсыг сахиж, төр ёсоо бадруулж ирсэн түүхтэй билээ. Монголчууд түүхэндээ газар нутгийг хэн нэгэн өмчилдөггүй байсан нь *нэгдүгээрт*, төвөөс зугтах хүчийг сааруулж төрийн нэгдмэл байдлыг хадгалах шаардлага, *хоёрдугаарт*, нүүдлийн мал аж ахуйн технологи нь газар нутгийг өмчлүүлэхийн эсрэг бодлого явуулахыг нөхцөлдүүлсэн гэж үзэж болно. Нөгөө талаас хөрсний бүтэц, ургамлын даац ч нүүдэллэн амьдрахыг нөхцөлдүүлсэн нь лавтай.

Гэвч түүхийн явцад газар нутгийг хувь хүмүүст өмчлүүлэх явдал Чингис хааны насан өөд болохын өмнөөс эхэлсэн байна. Чингис хаан таалал төгсөхийн өмнө ууган монголын газар нутгийг ууган хөвгүүн Тулуйд, эзэлсэн бусад нутаг орныг бусад хөвгүүддээ соёрхох

³ Н.Луцкисарж "Төр, эрх зүйн сэтгэлгээний чиг хандлага" УБ, 2002, 261-262 дугаар тал

⁴ Ш.Нацагдорж "Сум, хэмжээ, шавь ард". УБ, 1972, 53-р тал

буюу хувь өмч болгон хуваан өгсөн тухай түүхийн баримт бий. Үүнээс өмнө монголчуудын түүхэнд ийм явдал гарч байгаагүйг төрийн их зөвлөх Елюй Чуцайгийн үг нотолдог. Тэрээр Чингис хааныг хөвгүүддээ газар нутгийг хуваан өмчлүүлэх шийдвэр гаргасанд ихэд харамсан газар нутгийг үе улируулан эзэмшүүлж болохоос биш, хувь өмч болгож яаж болох вэ? Ингэхлээр л яваандаа төвөөс тэмүүлэх хүчин давамгайлж, улс гүрэн задархын үндэс тавигддаг юм хэмээн хоолой нь зангирч, нулимс дуслуулан хэлж байсан гэдэг. Үнэхээр ч үйл явцын цаашдын өрнөл Елюй Чуцайгийн урьдчилан харсанаар болсныг монголын түүх нотолдог билээ⁵. Гэхдээ газар өмчлөлийн энэ эхлэл нь зөвхөн Чингисийн удмын дээд угсааныханд буюу үр хүүхдэд нь холбогдож байсан бололтой. Харин Чингисийн төрд онцгой гавьяа байгуулсан хүмүүст газар нутгийг хувь өмч болгон өгч байгаагүй, харин эзэмшүүлэх онцгой эрх олгож⁶ байсан бололтой. Хэрэв урьд өмнө газар нутгийг хувь өмч болгож өгч байсан бол Елюй Чуцай Чингис хааныг үр хүүхэддээ хувь өмч болгон өгсөн үйлдэлд яахан харамсах билээ. Тийнхүү азийн үйлдвэрлэлийн аргын нөлөө, нүүдлийн соёл иргэншлийн онцлогоор монголчуудын хувьд газрыг зөвхөн төр, дээд угсааны цөөн тооны хүмүүс өмчилж байсан нь монголчуудын өмчлөх эрхийн үзэлд өвөрмөц үл мөр, үзэл, сэтгэлгээг нөхцөлдүүлсэн нь дамжиггүй. Өвөрмөц гэдгийн утга нь өмчлөх эрхийн үзэл, сэтгэлгээ сул хөгжсөн болохыг илэрхийлэхийн зэрэгцээ өмчийг эрх, эрх чөлөө, бие даасан байдлын үндэс гэсэн утгаар ойлгож, сэтгэж байсангүй. Харин ашиг сонирхол нь туссан хэрэглээний зүйлийн хүрээнд ойлгож мэдэрч байсан бололтой.

Монголчуудын өмчлөх эрхийн сэтгэлгээнд тэгш ёсны үзэл санаа төдийлөн бүрэлдээгүй бололтой. Харин нийгэмд болон тухайн овог аймаг, гэр бүлд давуу байдалтай, эрх мэдэлтэй хэн нэг нь өмчлөлийн давуу эрхийг эдэлж байсан байна. Энэ нь азийн үйлдвэрлэлийн аргын онцлогийн дагуу эрх мэдэл нь өмчлөх эрхийн баталгаа, илрэх үзэгдэл болж байсантай холбоотой юм. Тийм учраас Их засаг хуульд эцгийг насан өөд болсоны дараа өмч хөрөнгийг хуваахад ахмад хөвгүүн бусдаас илүү хэмжэний өмч авах тухай заасан байдаг⁷. Нөгөө талаас Их засаг хуулийн энэ заалт бол хэрэглээний эд зүйлсийн хүрээнд өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээ нийлтээд төлөвшсөнийг мөн илтгэж байгаа юм.

Монголчуудын хууль цаазын дурсгалуудад үл хөдлөх хөрөнгийг эзэмших эрхийг нээгээгүй бөгөөд зөвхөн хөдлөх хөрөнгийг ашиглах эрхийг 1640 оны

⁵ Н.Ишжамал. "Улсын бага хурлын дарга, гишүүдэд бичсэн хөндөг". Ерөнхий ажлын талын газрын архив: ХН-52, III том, 246-247-р тал

⁶ Ж.Болдбаатар, Н.Лундзэжиганцан "Монголын төр, эрх зүйн түүхэн удмал" УБ, 1997, 74-р тал

⁷ В.А.Резванский. Монголчуудын хууль цаазын дурсгал Их засаг хууль

өмчийн эрхийг улс нийгмийн эрх ашигт харш ашиглаж үл болно” гэж заасан байна. Гэхдээ хувийн өмчийг өмчийн бие даасан хэлбэр гэдгийг эдгээр хуулиудын алинд нь ч заагаагүй юм. Тухайлбал, 1940 оны Үндсэн хуулинд улсын өмч, хөдөө аж ахуйн нэгдлийн нийтийн өмч, 1960 оны Үндсэн хуулинд социалист өмч нь улсын, хоршооллын гэсэн хоёр хэлбэртэй гэж заасан байна.

1990 онд шинэчлэн найруулсан БНМАУ-ын Иргэний хуулийн 59-дүгээр зүйлд “БНМАУ-д хувийн болон нийтийн өмч байна” гэж зааснаар социалист өмчийн сэтгэлгээ төгсгөл болж эхэлсэн юм. Хэдийгээр өмнөх үндсэн хуулиудад /1924, 1940, 1960/ өмчлөх эрхийн үзэл санаа бүдэг бүрхэг тусгагдаж, хэрэгжих эрх зүйн баталгаа бүрэн тодорхойлогдоогүй байсан нь К.Маркс, Ф.Энгельс нарын “Коммунист намын тунхаг” зохиолд дурдагдсан “Коммунизмын онцлог шинж чанар, нийт өмчийг устгах биш-харин хөрөнгөтний өмчийг устгах явдал мөн”⁹

гэсэн марксизмын тулгуур үзэл санаатай шууд холбоотой байсан нь мэдээж юм. Гэвч амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхтэй байх нь Ж.Локкийн тодорхойлсноор хүний салшгүй жам ёсны эрх, оршихуй учраас тухайн үеийн үзэл суртал хувийн өмчийн үзэл санааг үлдэн хөөхийг хичээж байсан хэдий ч өмчлөх эрх өөрөө амьдралтай хамт оршиж байсан юм. Иргэд хувийн өмчтэй байх амьдралын энэхүү зайлшгүй үнэнийг 1952 оны БНМАУ-ын иргэний хууль, 1960 оны Үндсэн хуулиар амины өмч нэртэйгээр хуульчилсан юм. Энэхүү амины өмч нь *нэгдүгээрт*, социалист өмчийн хэрэгжилтийн явцад үүссэн, *хоёрдугаарт*, үйлдвэрлэлийн хэрэгслийг хамардаггүй, зөвхөн хэрэглээний эд зүйлсийг хамардаг, *гуравдугаарт*, хувийн өмч биш¹⁰ гэсэн үзэл санаанд тулгуурлаж байснаараа иргэдийн өмчлөх эрхийн агуулга, үзэл санааг бүрэн илэрхийлдэггүй байсан юм. Нөгөө талаас амины өмчийн өмчлөх эрхийн агуулга нь эрх зүйн тусгай дэг журамд хүлэгмэл байснаараа онцлогтой. Тухайлбал, амины өмчийн зарим объект тусгайлан бүртгэгдсэн байх, эзэмших, ашиглах, захиран зарцуулахад тогтоосон журам баримтлах, иргэдэд байх эд хөрөнгийн тоо хэмжээг тогтоож өгөх /хангайн бүсэд 50 толгой малтай байх, үүнээс 33 бог, 17 бод байх, говийн бүсэд 75 байх, тавааралаг шинжээр илүү бодын тоо тогтоосон тооноос хэтэрч болохгүй гэх мэт/ зэргийг дурдаж болно. Төр засгаас өмчлөх эрхийн талаар ийм бодлого, эрх зүйн дэг журмыг хэрэгжүүлж байсан нь өмч бол хүний эрх, эрх чөлөөний үндэс гэсэн жам ёсны шинжтэй үнэт зүйлсээс хөндийрүүлж, пролетари сэтгэлгээг төлөвшүүлэх, ядүү зөдүү, ахар тарчиг байдлаараа бахархах, түүнийгээ энгийн даруухан

⁹ К.Маркс. “Коммунист намын тунхаг” УБ, 1947. 63-р тал

¹⁰ “БНМАУ-ын иргэний эрх зүй”, УБ, 1988, /Ред. Д.Зундуй, Н.Чинбат/ 167-168 тал

амьдарч байна гэх үзэл бодлыг бүрэлдүүлж, өмч хөрөнгөө арвижуулах овсгоо самбай гаргасан хүмүүсийг амин хувиа хичээгч, хувийн ашиг сонирхолыг нийтийн ашиг сонирголоос дээгүүр тавигч гэж элдэв нэр хоч зүүж, ад үзэж, нүд үзүүрлэж байсан нь иргэдийн өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээнд таатай үр дагавар авчраагүй нь ойлгомжтой юм.

Тэгэхлээр, монголчуудын хувьд өмчлөх эрхийн үзэл, сэтгэлгээ монгол үндэстэн бүрэлдэж, монгол төр ёсон тогтсон тэр цагаас азийн үйлдвэрлэлийн аргын нөлөө, нүүдлийн соёл иргэншлийн онцлог, нүүдлийн мал аж ахуйн арга, технологи, түүнийг нөхцөлдүүлсэн байгалийн хүчин зүйл, өмчлөгчидгүй нийгэмд тогтдог төрийн дэглэм зэргийн нөлөөгөөр хувийн өмчийн үзэл сэтгэлгээ монголчуудад хэрэг дээрээ хөгжиж төлөвшөөгүй шахам юм. Хэдийвээр иргэдийн өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээ объектив, субъектив хүчин зүйлсийн нөлөөгөөр ийнхүү хөгжих бололцоо хязгаарлагдмал байсан хэдий ч өмчлөх эрх өөрөө хүний жам ёсны эрх учраас уг үндэс нь тасралгүй оршиж, өөрчлөгдөж, аажим алгуур боловч хягаарлагдмал орчинд хөгжсөөр ирсэн юм. Гэхдээ 1992 оны Үндсэн хуулиар хувийн өмчийн хэлбэрийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, өмчлөх эрхийг хуулиар хамгаалж, өмчлөх эрхийн үндэс болсон үл хөдлөх хөрөнгийг өмчлөх эрх нээгдэх хүртэл өмчлөх эрх ахуйн хэрэгцээг хангах нөхцөл төдий байсан болохоос хүний эрх, эрх чөлөөний гол үндэс болж чадаагүй байсныг тэмдэглэж байна.

Шинэ үндсэн хууль монголчуудын өмчлөх эрхийн үзэл сэтгэлгээнд ноо шинэ үеийг эхлүүлээ. Цаашид хэрхэн өрнөж, хөгжихийг түүх харуулах биз ээ.

XIX-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН ЕВРОПЫН ҮНДСЭН ХУУЛЬТ ЁСНЫ ХӨГЖИЛ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирлын туслах,

Хууль зүйн ухааны магистр Ч.Оюунбаяр

Өрнө дахины эрх чөлөөнд тэмүүлэх үзэл санаа нь түүнийг хэрэгжүүлэх арга, механизмыг эрж хайхад зүй ёсоор хүргэсэн нь мэдээж юм. Энэ механизмыг хэрэгжүүлэх арга зам нь Үндсэн хуульт ёс, түүний төлөвшилийн асуудал бөлгөө.

Өнөө үед Үндсэн хуульт ёс нь эрх зүйт төрийн үзэл санааг хэрэгжүүлэх хамгийн шилдэг, зохистой арга хэмээн үзэж байна. Тиймээс “Үндсэн хуульт ёсыг хууль бол эцсийн бөгөөд дээд хүчинтэй, төр засгийн эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй, засгийн үйл ажиллагаа хууль, эрхээр хязгаарлагдсан, хууль нь хүний эрхэнд үндэслэгдсэн байхыг хэлнэ”¹ хэмээн тодорхойлох нь түгээмэл байна. Тиймээс би Үндсэн хуульт ёсны асуудлыг эл ойлголтоор хязгаарлан түүнийг үзэл баримтлал, эрх зүйн философи хийгээд хэм хэмжээнийх нь утгыг хослуулах замаар авч үзсэн болно.

Хүний амьдралын дээд зорилго аз жаргалтай, баян чинээлэг амьдрах ёстой гэсэн эвдемонист философид тулгуурласан цагдаажсан төрийн халааг XIX зуунд хүлээн авсан эрх зүйт төрийн үзэл санаа эл үеийн эрх зүйн үзэл, сэтгэлгээг тодорхойлж эхлэв.

Учир нь XIX зуунд өдгөө монголчууд бидний хөгжүүлэхийг зорьж буй Ром-Германы эрх зүйн бүл нь Англи-Америкийн эрх зүйгээс “The rule law” хэмээх ухагдахууныг авч хэрэглэн түүнийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн түүхэн цаг үе юм. Энэ үед Европын улс орнуудын санхүүгийн хүчтэй өсөлт, хөгжилтэй холбогдон ард олны материаллаг сонирхол, санал, санаачлага, хувь хүний дотоод сэдлийг өдөөх хэрэгцээг төрүүлсэн явдал нь нийгмийн баялагийг зөвхөн хүчирхэг төрийн аппаратын тусламжтайгаар бий болгох тухай цагдаажсан төрийн үзэл санааг бүхэлд нь өөрчилөхөд хүргэсэн байна.

Энэ тухай хууль зүйн шинжлэх ухааны доктор Н.Лүндэндорж “Цагдаажсан төрийн үзэл баримтлалын эсрэгээр хувь хүний аминч үзэлд зориулагдсан сургаал шинжлэх ухаанд бий болж, бодгаль бүр хамгийн их хэмжээний үнэт зүйлийг үйлдвэрлэх арга барилаа өөрөө хамгийн сайн олох агаад энэ нь нийгмийн ашиг сонирхолд ч нийцнэ гэсэн бодгальчлах үзэл шинжлэх ухаан улс төрийн бодлогод орж ирснээр

¹The New Encyclopedia, Vol. 25, P. 979

эрх зүйт төрийн үзэл санааны үндсийг улам гүнзгийрүүлэв”² гэжээ. Тэгэхлээр Европын эрх зүйн сэтгэлгээг тодорхойлж эхэлсэн эрх зүйт төрийн үзэл санаанаас эл үеийн Үндсэн хуульт ёсны хөгжлийг авч үзэх нь зүйд нийцнэ.

Германы философич И.Кант эрх зүйт төрийн үзэл санааг эрх зүйн философийн үүднээс нилээд цогц байдлаар судалсан сэтгэгч мөн боловч тэрээр *rechtstaat* гэх нэр томъёог хэрэглээгүй. Харин эрх зүйгээр удирдуулсан иргэний нийгэм буюу *allgemein das Recht vorwaltenden burgerlichen Gesellschaft* гэх ойлголтын хүрээнд хувь хүний хүсэл зориг, эрх чөлөөний хэмжээ хязгаар хамгийн яв цав тодорхойлогдож бас хадгалагдаж байгаа тэр цагт, тэгэхлээ нийгмийн эрх чөлөөний үндэс болсон ёс суртахуунт хуулийн хүрээнд бусдын хүсэл зориг эрх чөлөөтэй хослон нийлэх, таарч тохирох тэрхүү хэмжээгээрээ тодорхойлогдож байх тэр үед эрх чөлөөг хангаж, хамгаалах эрх зүйт иргэний нийгэм дэх түүхэн үүрэг хуульд ногдох бөгөөд гагцхүү энэ үед л нийгэмд эрх зүй-ёс суртахууны зарчим ноёлох ёстой³ бөгөөд энэ нь нийгмийн янз бүрийн хүсэл зориг, ашиг сонирхлуудыг тэгш ёсны үүднээс өөр хооронд нь түлхэлцүүлэх замаар өдөөн турхирч, тэдгээр ашиг сонирхлуудын мөргөлдөөний огтлолцол дээр хувь хүн болон хэсэг бүлгийн эрх ашиг, хүсэл зориг субъектив нөлөөллөөс ангид априори зарчмаар хөглөгдсөн түгээмэл хуулийн тухай үзэл санааг дэвшүүлсэн юм.

Цагдаажсан төрийн үзэл суртлаар иргэд ч, төр ч аз жаргал, элбэг хангалуун, сайн сайхан амьдралд хүрэх арга зам нь захиргааны дүрэм, журам, заавар байх бөгөөд төрийн үйл ажиллагаанд хувь хүн хөндлөнгөөс оролцох, хяналт тавихыг хориглодог бол эрх зүйт төрийн номлолоор төр иргэдийн хүсэл зоригт өөрийн хүсэл зоригийг тушаах болсон байна.

Энэ тухай эрх зүйт төрийн үзэл санаа буй болоход их үүрэг гүйцэтгэсэн төдийгүй энэхүү ухагдхууныг анхлан бүтээлдээ хэрэглэсэн хүмүүсийн нэг Франкфуртын Үндэсний хурлын гишүүн Роберт Моль 1840 онд дараахь зүйлийг бичиж байв. “Эрх зүйт төрийн, өөрөөр хэлбэл ард түмний төлөөлөлтэй хязгааргүй ноёрхлын мөн чанар нь иргэн хүн төрийн тэргүүний ашиг сонирхлын төлөө хэрэгсэл биш, төрийн тэргүүний өмнө зөвхөн үүрэг хүлээдэг бус харин иргэн хүнд бас үл зөрчилгөх эрх байдаг, тэрээр өөрөө өөрийнхөө төлөө байдагт оршино. Үндсэн хуулийн жуух бичгийг төрийн тэргүүн ба иргэд хоёрын хоорондын харьцааг нэг бүрчлэн тодорхой тусгаж үйлдвэл зохино. Ингэснээр уг харьцааны агуулга ба хэлбэрийн талаар маргаан үүсэхээс урьдчилан сэргийлж, шаардлага тавих ба шаардлагыг үл биелүүлбэл нөхцөл байдлыг тодорхой тусгасан байна”⁴ гэсэн бол парламентийн гишүүн Spatz

²Н.Лундэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002. 97 дахь тал.

³И.Кант. Религия в пределах только Разума, /часть 3/. Введение

⁴R.v. Mohl. Das Staatsrecht des Königreichs Württemberg. 2. Aufl. Tübingen 1840. Bd. 18 S. 323

Meier P., Das Rechtsabstrakt in der Weimarer Republik // *Zeitschrift für Rechtswissenschaften*, Berlin, 1976 / *ЭНЭ ТӨГӨӨЛӨГЧИЙГ ИЛГЭЖ ХҮЭЭЖ ХҮЭЭ*

Greif R., *Das Rechtswort*, Berlin, 1872, S. 12-13

Saehle F.-J., *Rechtswort und die Grundfrage der Sprache*

Meier P., *Rechtswort und die Grundfrage der Sprache*, Berlin, 1871, S. 15

K. Hesse, *Rechtswort im Verfassungssystem des Grundgesetzes*, Tübingen, 1902, S. 557

“Гэхтээ энэ дан ганц нэгэн санаа биш бөгөөд анхлан Ш.Л.Монтескье “аливаа төрд гурван төрлийн эрх мэдэл оршдог. Эхнийх нь хууль тогтоох эрх мэдэл бөгөөд энэ нь пат үеийн буюу байнгын хуулиудыг тогтоож, үйлчилж буй хуулиудыг засаж, өөрчилж, хүчингүй болгож байна. Хоёр дахь эрх мэдэл нь дайн энхийн асуудлыг шийдвэрлэж, эзний харилцаат эрхлэж, энэ төлөөлөгчийг илгээж хүлээн

байна.

хууль зүйт сэтгэлтээ, эрхийн ухааралын салшгүй хэсэг-эрх зүйт төрийн үзэл санаа болж байлаа”
 Өөмөөний дээр нөлөөх бололцоо бүрдэх тухай санааг илэрхийлсэн хэсэгт. Тиймээс ч өрнөдийн буюу эрх мэдэлтэй эрх мэдэлтэй, нийгмийн бүлэгт, үлс төрийн хүчин бүлэг зорогчид эрх мэдэл мөн “хэсэгчлэн төлөөлөгчид эрх мэдэл хуваарилагдай төр үргэлжсэн нөхцөл, суурь зарчим нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бие даан сэтгэл бол Германы эрдэмтэн Р. Гнейст юм. Тэрээр “эрх зүйт төрийн төлөөллийн эрх мэдэл цааш эрх зүйт төрийн төлөөллийн асуудлыг илгээх үүсний, үл суурьтай авч үзсэн үндэр шалтгааныг тайлбарласан хэсэг.

Ханга үүснээс бус хүний эрхийг хамгаалах механизмийг бүрдүүлэх хэрэгтэй шаардлагаас үүснэ гэсэн нь үзлээ эрх зүйт төрийн үзэл санаа нь төрийн удирдлагын боловсролгүй тогтооногч иргэдийн эрх чөлөөний хүрээг хязгаарлах, түүнийг эргэлт болгохгүйг яв тав тодорхойлох ёстой”
 Түүнийхээр: “Эрх зүйт төр-шинэ үзлээ бөгөөд өөрийн үйл ажиллагааг яв хязгаарлахаар “Эрх зүйт төрийн үзэл санааг шийтгэн, гүн ухааны үүснээс Ф.Ю.Штайв хөгжүүлсэн буюу.

Төрийн үүсгэс болох тухай санаа юм.

Иргэдийн эрх чөлөөний асуудал нь төрийн эрх мэдлийн хувиараат хийгээ эрх зүйт холбоотой” гэсэн нь үзлээ эрхийг хамгаалах нь төрийн үйл үүрэг бөгөөд төлөөлөгч үйл хэрэгт оролцох гэсэн иргэдийн гурван эрхтэй салшгүй хувиар эрх чөлөөний юу төлөөлөгчид юу хорилогсныг мэдэх оршихуйн үндсийг: -нийгмийн зорилго хэрэгжүүлэхийг төрөөс шаардах

Р.Моль “Төрийн ухааны нэвтрэхийг гол хэмээх бүтээлтэй эрх зүйт төрийн зүйлийг и хийж болно гэсэн зарчим үйлчилж ирээ” гэжээ.

Нэмэлтийг оруулах шаардлагатай байна “патлажсан төрд зөвхөн зөвшөөрөгчдөө үйлдэх эрхтэй... бид өнөөт хүртэл патлажсан төрд аж төрж байсан үндэр үндэр гэсэн Паулын сурт хэлсэн үгнээс: “...хувиар хориглохгүй бүх зүйлийг хэл ч

авч, улс орны аюулгүй байдлыг хангаж үйл ажиллагаандаа олон улсын болон иргэний эрхийг удирдлага болгоно. Гурав дахь эрх мэдэл гэмт явдлыг цээрлүүлэх, хувь хүмүүсийн хоорондын зөрчилдөөнийг шийдвэрлэдэг эрх мэдэл мөн¹⁰. Хэрэв зээ хууль тогтоох хийгээд гүйцэтгэх засаглалыг нэг гарт төвлөрүүлбэл эрх чөлөөний тухай ярих ч аргагүй... нэгэнт эрх чөлөөгүй нөхцөлд хараат бус шудрага шүүх мөн оршихгүй. Шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдэлд нэгтгэвэл иргэдийн амьдрал эрх чөлөө дур зоргоо золиос болно. Хэрвээ гүйцэтгэх эрх мэдэлд шүүхийг нэгтгэвэл шүүх дарангуйлагч болох бололцоотой¹¹ гэх үзэл санаа 1787 он АНУ-ын үндсэн хууль, 1791 оны Францын Үндсэн хууль, 1789 оны “Хүний ба иргэний эрхийн тунхаглал” –д тусгалаа олсон төдийгүй баруун европын бусад орнуудын эрх зүйн соёл, сэтгэлгээ, Үндсэн хуульд ёсны хөгжилд чухал нөлөө үзүүлсэн юм.

Энд нэг зүйлийг тэмдэглэхэд, төрийг иргэний дээр бус харин иргэний эрхийг хуульд шингээн төрийг хуульд захируулахыг номлосон эрх зүйт төрийн үзэл баримтлалтай холбогдон XIX зууны дунд үеэс XX зууны эхэн хүртэл бүхний дээр засаглах хууль түүний уг үндэс болсон эрх зүйг хэрхэн ойлгох тухайд хүн төрөлхтний үзэл сэтгэлгээнд тэсрэлт гарсан гэж хэлж болно. Тодотговол, энэ л үед Л.Дьюги “Хаана нийгэм байна тэнд эрх зүй оршино... гээд эрх зүйн утганд төрийн хүсэл зориг нийцэж байх тухай бичиж, Е.Эрлих, Р.Паунд нар эрх зүйг нийгмийн үзэгдэлтэй нь холбон тайлбарлахыг эрмэлзэж, Германы социологич М.Вебер төр бол хүчирхийллийг хууль ёсоор эзэмшигч, Л.Петражицкий эрх зүйг хүний сэтгэл хөдлөл түүний объектив бодит илрэл мөн хэмээн үзэж, орос оронд Г.Ф.Шершеневич, П.А.Покровский нарын төр, эрх зүйн үзэл санаа ид хүчээ авч байсан юм. Гэхдээ төр, эрх зүйг ингэж олон талаас нь авч үзэж, тодорхойлох гэсэн оролдлого нь эцэстээ хууль зүйн шинжлэх ухаанд шинэтгэл хийх хэрэгцээ шаардлагыг төрүүлсэн юм.

Тиймээс XX зууны эхэн үеэс шинэ Кантч үзэлд тулгуурлан Австрийн их сургуулийн профессорууд болох Кельзен, Фердросс, Меркль нарын боловсруулсан эрх зүйн цэвэр онол хууль зүйн шинжлэх ухааны томоохон ололт болон гарч ирсэн бэлгөө. Тодруулбал, Кельзен эрх зүйг хэм хэмжээнийх нь хувьд эрх мэдэл бүхий эрэмбэ зиндаанд хуваарилж, нэр томъёоны цэгцгэй логик бичиглэлд оруулах тухай боловсруулсан өөрийн онолыг “Эрх зүйн цэвэр онол” хэмээн нэрийцсэн юм.

Энэ онол нь хууль зүйн системээс улс төр, эдийн засаг, нийгмийн бусад дайвар хүчин зүйлийг шахан гаргах замаар түүнийг эрх зүйн бус үзэл баримтлал, хандлагаас ангижруулан

¹⁰Монтескье. Ш. О дуге законев, Избранные произведения, М., 1955. С. 289-290

¹¹Н.Луццансдорж. Төрийн онол. УБ. 1997., 66 дугь тал

гагцхүү хууль зүйн хэм хэмжээний логик бичиглэлд эрх зүйн утгыг хадгална гэсэн нь хууль зүйн позитивист сургаалиас эхээ авсан хэрэг.

Гэхдээ Кельзений “нормативизм” нь эрх зүй бол төрөөс тогтоосон буюу зөвшөөрсөн, зөрчигдөх явдлаас төрийн албадлагаас хамгаалагдсан хэм хэмжээний цогц гэх XIX зуунаас эх аван хөгжиж улмаар 1930-аад оноос Вышинскийн үзлээр гажуудсан манайд саяхныг хүртэл амь бөхтэй оршин байсан позитивизм хараахан биш юм.

Тодотговол, Кельзен шинэ Кантч үзлийн үндсэн дээр шалтгаалцлын хуулинд захирагдах бус, харин байх ёстой хуулинд захирагдахыг чухалчилж байсан нь “ёс зүй болон хууль зүйн шинжлэх ухаан нь байх ёстой зүйлийн шинжлэх ухаан болохоос биш хэн нэгний хүсэл зоргийг агуулсан мулгуу хэм хэмжээг дээдлэх шинжлэх ухаан биш”¹² гэсэн нь дээрхийн нотолгоо буй за.

Эрх зүйн утгыг цэврээр нь судлах, ойлгох, тайлбарлахыг эрмэлзсэн хууль зүйн нормативизм нь маш их эсэргүүцэлтэй тулгарсан бөгөөд түүнийг зарим нийгэм судлаачид хуульчидын өөрийн шинжлэх ухааныг аварч үлдэх гэсэн оролдлого мэтээр үзэх нь эл онолыг тэр хэрээрээ нарийсан хөгжих хөшүүрэг болж, улмаар өнөөдөр эрх зүйн философи, хууль зүйн дотоод системчлэлийн арга зүйг өргөжүүлэн тэлэхэд томоохон нөлөө үзүүлсэн болой.

Нормативизм нь хуулийн асуудалд нийгэм судлалын чиг баримжаатай хандах нь зохисгүй бөгөөд угаас эрх зүйн илэрхийлэлд улс төр, болон ямарваа үзэл суртал нөлөөтэй байх ёсгүй гэж үзэхийн хамт эдгээр нөлөөлөлөөс ангижирсан хэм хэмжээний мөрдлөгөө нь sollen-д баримтлагдсан логик дараалалд захирагдах тухай үзэл санаанд тулгуурлагдаж байв. Кельзений үзэж буйгаар sollen нь нийгмийн үзэгдэлтэй холбоогүй бөгөөд цэвэр онолын категори болох ба тэрээр Кантын трансценденталь логикт холбогдох ухамсар, танин мэдэхүйн гадна орших норм бөгөөд энэ үүднээсээ хуулийн уг чанар эрх зүйн утгыг тэрээр утгал-эхэнлэг орчноос эрэлхийлсэн юм¹³.

Тэрбээр эрх зүйн цэвэр сургаалийнхаа үүднээс төрийг тодорхойлохыг эрмэлзсэн нь эдүгээ ч ач холбогдлоо алдаагүй байна. Тодруулбал, Кельзений “жинхэнэ эрх зүйн дэг журамд тооцогдож болох тэр хэм хэмжээлэгдсэн албадлагын дэглэмийг эрх зүйт төр гэж нэрлэж болно”¹⁴ гэснийг судлаач Х.Тэмүүжин “энэ хандлагаас нь бид төрийг хуулиар тогтоолдож буй дэг журмыг хамгаалж, хуулийг үйлчлэх ёстой газар нь, үйлчлэлд хамаарагдах субъектэд хэрэгжүүлж чадах тогтолцоо хэмээн ойлгохоос гадна тэр өөрөө бас хэм хэмжээлэгдсэн зүйл гэж ойлгох зайлшгүй

¹²Н.Луцкедорф. Төр, эрх зүйн системчлэлийн хөгжлийн чиг хандлага. УБ. 2002. 76 дуг. тал.

¹³Х.Тэмүүжин. Эрх зүйн цэвэр онол буюу нормативизмыг бэлтгэлтэйгээр харуулж. УБ. 2001., Эрх зүй. №4-5. 134 дэх тал.

¹⁴Kelsen, H. Allgemeine Staatslehre. Berlin. 1925. S. 45

шаардлагатай болж буй юм”¹⁵ гэх тайлбарт хачир нэмэхэд нэгэнт орчин үеийн төр нь норматив арга зүйн үүднээс эрх зүйн дэг журам бүхий систем юм бол аливаа улсын төрийн дэглэм нь ямар загвар /модель/-ын төрийн тухай үзэл баримтлалыг тулгуур зарчим, үнэт зүйлээ болгон эрхэмлэж буйгаас шалтгаалах нь зүйн хэрэг.

Эрх зүйт төрийн зайлшгүй шаардлагаар нөхцөлдөн хүний эрх, эрх чөлөөг төр, нийгмийн дээр товойлгон тавьж, түүнийг хамгаалан хөхиүлэн дэмжих тухай асуудал мөн энэ л үед гарч ирсэн бөгөөд энэ нь ч зүйн хэрэг байв. Учир нь аль нэг хүчний ашиг сонирголоос ангид оршигч түгээмэл хуулинд захирагдсан төрийн загварын тухай ярихын тулд түүний үндсийн үндэс болсон хүний эрх, эрх чөлөөний тухай бичихгүй, бодохгүй, ярихгүй, хэлэхгүй байх аваас энэ нь хоосон цэцэрхэлээс өөр юу ч биш болно.

Тиймээс Ж.С.Милль эл цаг үед “Эрх чөлөөний тухай” хэмээх өөрийн эссег бичсэн нь эрх зүйн соёл, сэтгэлгээний хувьд дөнгөж шилжилт хийн чухам юуг эрхэмлэхээ мэдэхгүй байсан Европын ард түмэнд том өгөөш болсон юм. Миллийн утилитаризм¹⁶ төр бол хувь хүний эрх ашгийг хамгаалагч бөгөөд төрийн зорилго нь нийтийн аз жаргалыг ихэсгэхэд чиглэх ёстой гэсэн үзэл баримтлал руу өөрийн эрхгүй аваачдаг. Тэрээр эрх чөлөөний тухай эссэндээ: “Иргэншсэн нийгмийн аливаа гишүүнийг зүй ёсоор дарамталж, түүний хүслийн эсрэг эрх мэдэлтнээс хийх үйлдлийг зөвтгөх цор ганц шалтгаан бол бусдад хор хохирол учруулах явдлыг зогсоох. Бие бялдрын болоод ёс суртахууны үүрэг нь цагаатгах хангалттай үндэслэл болохгүй”¹⁷ гэсэн нь төрийн үйл ажиллагаа гагцхүү хувь хүний зүгээс бусдын эрхийг зөрчихөд чиглэсэн үйлдлийг таслан зогсооход оршино гэсэн санаа буй за.

Милль ардчилалыг хамгаалагчдын нэг байсан. Тодотговол, Платоноос эхлэн Локкийг хүртэлх бүх сэтгэгчид төрийг тусгайлан бэлтгэгдсэн цөөн хүн барих тухай номлож түүнийгээ батлахыг оролдож байсан бол Локк, Милль нар олонхи жолоодвол зохино. Яагаад гэсэн асуултад милль хариулахдаа нэг эсхүл цөөн хэсэг нь төрийг барьснаас олонхи засаглах нь хүн төрөлхтөнд аюул багатай¹⁸.

Гэсэн хэдий ч ардчилал нь олонхийн дарангуйлалыг тогтоож магадгүй болохоор төрийн эрх мэдлийн зарим хэсэг нь хувь хүний эрх ашгийг олонхийн дарамтаас хамгаалахад чиглэх ёстой гэсэн нь А.Токвиллийн хувь хүний эрх ашгийг олонхийн засаглалаас хамгаалах, төрийн

¹⁵Х.Тэмүүжин. *Jus fiat* буюу ёст үг. УБ, 2004, 123 дахь тал

¹⁶Утилитаризм- хувь хүн болон хууль батлан гаргадаг төр засаг ч гэсэн ер нь хэн болонч хэзээ ямагт аль болох олон хүнд, аль болох их аз жаргалыг эдлүүдэх ёстой гэж үздэг ёс суртахууны онол юм. Уг онолын хөгжилд Ж.Бентам, Ж.С.Милль нар үзэмж хувь нэмэр оруулсан гэдэг

¹⁷Mill On Liberty. 135

¹⁸Энэ санааг John Stuart Mill. *Utilitarianism*. 1863. *Representative Government*. 1861-ын номууд мөн On Liberty-гээх үзэх боломжтой.

эрх мэдлийг орон нутгийн засаг захиргаанд шилжүүлэх тухай ардчилалын онолтой нь ямар нэг сэжмээр холбогддог.

Мөн энэ үеийн эрх зүйн сэтгэлгээ тэр дундаа парламентат ёсны үзэл санаанд гарсан томоохон хувьсал, өөрчлөлт бол хууль тогтоох үйл ажиллагааны үндэслэлүүдийг нарийвчлан боловсруулсан бөгөөд энэ нь Ж.Бентамын “Парламентын үйл ажиллагааны тактик”, Ж.С.Миллийн “Representative Government” зохиолуудад тусгалаа олжээ. Үлгэрлэвэл, Ж.Бентам дээрхи бүтээлдээ хууль тогтоох үйл ажиллагаа түүний үе шатууд, санал хураалтыг илээр болон нууцаар явуулах журам, парламент дахь чөлөөтэй болон хязгаарлагдсан маргааны тухай мөн хуралдаан явуулах дэг зэрэг парламентат ёстой холбоотой олон санаануудыг системчилсэн юм.

Ж.Бентамын үзлийг цааш хөгжүүлсэн сэтгэгч бол Милль бөгөөд түүний хувьд төлөөллийн ардчилал нь орчин үеийн ертөнцөд байж болох цорын ганц хувилбар юм. Милль яагаад ийм бодолтой байсныг тодруулахад төрийн эрх мэдэл ямар үүрэгтэй болох тухай түүний үзэл санаа тусална. Түүнийхээр эрх мэдлийн зорилго нь нэгдүгээрт: иргэдийг сайжруулах, хоёрдугаарт: иргэдийн нийтийн үйл хэргийг зохицуулах бөгөөд Миллийн үзсэнээр хувь хүнийг ёс суртахуун, оюун санааны хувьд хэр зэрэг боловсронгуй болгов, нийтийн үйл хэргийг хэр зэрэг үр дүнтэй явуулсан гэсэн хоёр зүйлээр эрх мэдэл хэмжигддэг.

Тэрбээр төлөөлөх ардчилалын зайлшгүй чухал болохыг “Representative Government” зохиолдоо: “Оролцоо нь олон нийтийн хүсэл шиг тийм агуу зүйл байх ёстой, эцэстээ төрийн эрх мэдлийг хуваалцах эрмэлзэл шиг хүсэм зүйл байхгүй. Гэхдээ жижиг хотод л нийтийн үйл хэрэгт хүн бүрийг оролцуулдаг шиг хүн бүрийг тэр бүр оролцуулж чадахгүй, тиймээс төгс засаглалын хамгийн сайн хэв маяг бол төлөөлөл байх ёстой”¹⁹ хэмээн бичсэн нь парламентат ёсны мөн чанарыг бүрнээ илтгэсэн хэрэг.

Ж.С.Милль парламент дахь цөөнхийн төлөөллийг хангах асуудалд нилээд анхаарч байсан юм. Түүнийхээр эхний тойрогт ялагдсан нэр дэвшигч авсан саналаа өөр тойрогт шилжүүлэх замаар цөөнх парламентад нилээд хэдэн төлөөлөлтэй болж болох юм гэсэн нь сонгуулийн хувь тэнцүүлэх системийн нилээд эрээвэр хураавар системийг буй болгохыг оролдсон бололтой. Гэхдээ төлөөлөл гэдэг бол нэг хэрэг, харин цөөнхийн эрхийг хамгаална гэдэг бол бүр өөр хэрэг билээ.

Нийтийн ашиг сонирхолыг илэрхийлэгч хүрээнд хэрвээ парламентийн засаглал-"тай" улсын хувьд гүйцэтгэх эрхийн байгууллагыг төлөөлөгчидийн томилгоо хэмээн үзэж тэднээр онцгой тохиолдолд хуулийг бүтээлгэхээр эрхээ шилжүүлж буй нь асуудалгүй /хүлээн зөвшөөрөгдөж болох хэдий ч "муйхраар"/ боловч нөгөө талдаа элдэв төрлийн амбиц, хүчин зүйлийн нөлөөлөл бүр цаашилбал хувийн /энд намын үзэл/баримтлал, бүлэг хүмүүсийн хүрэхийг эрмэлзэж буй үр дагаварыг ойлгож болно. Ж.Н/ ашиг сонирхол, түүнтэй холбоотойгоор хуулийг "туушиндах" үзэл баримтлал дэлгэрч тухайн актын /хуулийн/ концепцийг нь үндсэн хуулийн хамааралд наалдуулахгүйгээр хэрэгжүүлэх гэсэн оролдлого гарч болохыг үгүйсгэх аргагүй. Үүнийгээ зохицуулах үндсэн хуулийн гарч байдаггүйгээс /нийтлэгдээ/ энэ нь нэг хэсэгтээ /ямар нэгэн асуудалтай үед/ ярианы гол сэдэв болох авч тэгсгээд намждаг²⁴ хандлагатай бололтой. Үүнийг л "...өдгөө хүртэл онолын хийгээд практикийн хувьд шийдэгдээгүй"²⁵ байгаа асуудал хэмээн хэлж болох юм.

Харин илүү чөлөөт "вакуум" орчныг баримталдаг ерөнхийлөгчийн засаглал-"тай" улсын хувьд энэхүү эрхийг хэрэгжүүлж буй явдал нь хариуцлагын хувьд нилээд нэр төрийн хэрэг болж ухамсарлагддаг, түүнчлэн хариуцлагын систем нь парламентаас бүрдэх бололцоо харьцангуй нээлттэй байдаг боловч тухайн захиргааны байгуулалаас гаргаж буй эрхийн хэм хэмжээ нь парламентийн өмнө ажлаа хариуцан тайлагнадаг, цаашилбал илүү нэр хүнд хөөцөлдсөн, өрсөлдөгчид ажлын амжилтаараа дарамт үзүүлэх гэсэн сонирхолын хүчин зүйлийг үндсэн хуульд зохицуулалт нь сааруулж чаддаггүй, тиймээс явцуурал, гажуудалд төдийлөн ойр очих боломжгүй байдаг нь харагддаг.

Энэхүү хууль тогтоох эрх нь бусад институтад шилжүүлэгдсэн байдлыг тандвал:

Францын үндсэн хуулийн 38-р зүйл:

"...Засгийн газар нь өөрийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн тулд парламентаас хууль тогтоох эрх олгохыг хүсэх эрхтэй ба парламент нь төрийн зөвлөлийн саналыг үндэслэн зөвшөөрөл /ордонас/ олгох бөгөөд тэрхүү зөвшөөрөл нь тодорхой хугацаагаар хязгаарлагдсан байна"²⁶ гэсэн нь хууль тогтоох эрх мэдлийг гүйцэтгэх эрхийн байгууллагад тодорхой нөхцөл, хугацаатайгаар шилжүүлж буй сонгодог жишээ мөн.

Италийн үндсэн хуулийн 76-р зүйл: "...Хууль тогтоох эрх мэдлийг Засгийн газарт зөвхөн хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлэх нөхцөл, зарчим тодорхойлогдсон тохиолдолд шилжүүлэх ба тодорхой хугацаанд, тодорхой хүрээний асуудлаар шилжүүлнэ"²⁷ хэмээн заасан байна. Эндээс анзааран дүгнэхийг оролдвол дараагийнх нь зүйл илүү тодруулга болно.

²⁴А.Шайбо. Самоограничение власти. М., 1999. Ст 168.

²⁵Н.Луцкедорж. Эрх мэдэл хуваарилалтын орчин үеийн онолын зарим асуудал. Эрх зүй сэтгүүл. УБ, 6-7/2001, 15 дахь талд

²⁶В.В.Маслаков. Конституции зарубежных государств. М., 1997. Ст 117.

²⁷В.В.Маслаков. Конституции зарубежных государств. М., 1997. Ст 258

Италийн үндсэн хуулийн 77-р зүйлд:

“...Засгийн газрын баталсан хууль нь парламентийн зөвшөөрөлтэйгөөр хүчин төгөлдөр болно. Хэрвээ зайлшгүй шаардлагын үүднээс Засгийн газар хууль гаргавал тэр өдөртөө парламентад батлуулахаар оруулна. Парламентийн чөлөөт цагт ийм асуудал хөндөгдвөл таван хоногийн дотор парламентийг цуглуулан хуулийг хэлэлцэнэ. Хэрвээ зөвшөөрөл авч чадаагүй бол тэрхүү хууль нь хүчингүйд тооцогдоно, үүнтэй холбоотой эрхийн харилцааны үр дагаварыг парламент зохицуулна”²⁸ гэсэн нь хуулийг хүлээн зөвшөөрөгдсөн субъект тогтоох агуулга илэрхийлэгдэж цухалзах боловч эрх зүйн бодлого, түүний үр дагавар, хуулийн санаачлага, түүний зохицуулалтын зарчим нь илүү төлөөллийн шинжийг агуулах бололцоогүй, хэдийвээр өөр субъект хууль тогтоож буй боловч түүнийг үндсэн хууль ёс болон хуулиудын эсрэг чиглэсэн өөрөөр хэлбэл эрх зүйн системийн гажилт үүсгэх аюултай нөхцөлд аваачихгүйн тулд түүнд зөвшөөрөл олгодог хэмээн дүгнэж болох юм.

Испанийн үндсэн хуулийн 86-р зүйлд:

“...онцгой болон яаралтай тохиолдолд засгийн газар нь үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууллагуудын үйл ажиллагааны журам, тэдгээрийн бие даасан байдал, бүх нийтийн сонгуулийн эрхийг хөндөөгүй түр зуурын хуулийг тогтоож болно”²⁹ буюу нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудал тулгарсан үед засгийн газар нь үндсэн хууль ёсыг хөндөхгүйгээр, өөрөөр хэлбэл бүх ард түмний эрхийн үндсэнд бүрэлдсэн төрийн байгуулалыг хүндэтгэн, түүнд халдахгүйгээр тодорхой хугацаагаар, тодорхой асуудлаар /онцгой, яаралтай хэмээх ухагдхуунаар илэрхийлэгдэх тухайн үеийн асуудлыг шийдвэрлэх Ж.Н/ л хуулийг тогтоох санаа илэрхийлэгдэнэ.

Японы үндсэн хуулийн долдугаар зүйлийн 1.1-д:

“...Эзэн хаан нь кабинетынхаа зөвлөмж болон өөрийн тааллаар, ард түмний нэрийн өмнөөс дараахь асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй”. Үүнд:

1. Үндсэн хууль болон бусад хуульд өөрчлөлт оруулах...³⁰ гэсэн нь Японы гүйцэтгэх эрх мэдлийг кабинет хэрэгжүүлэх бөгөөд кабинетийн тэргүүн ерөнхий сайд нь парламентийн гишүүдээс нэр дэвшиглэн эзэн хаан томилж, тэрхүү томилогдсон ерөнхий сайд нь сайд нарыг томилож, огцруулах эрхийг хэрэгжүүлэн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх үндсэнд хууль тогтоох эрх нь гүйцэтгэх эрх мэдэлд шилжүүлэгддэг байна.

Германы Үндсэн хуулийн 80-р зүйлд: “...холбооны засгийн газар, холбооны яам, муж улсын засгийн газарт тогтоол, шийдвэр гаргах эрхийг хуулиар олгож болно. Ингэхдээ олгож буй эрх мэдлийн агуулга, зорилго, болон хэр хэмжээг хуулиар

²⁸В.В.Маклаков. Конституция зарубежных государств. М., 1997. Ст 259

²⁹В.В.Маклаков. Конституция зарубежных государств. М., 1997. Ст 320

³⁰www.oefro.unibe.ch/law/cl

тодорхойж өгнө" гэсэн нь гүйцэтгэх эрх мэдэл нь хууль тогтоогоос шүүд хараат,
 өөрөөр хэлбэл ард түмэн ямар эрхийн хязгаарын дотор гүйцэтгэх ажиллагааг өрнүүлэх
 эрхтэйг нь илэрхийлнэ. Хууль тогтоогч нь гүйцэтгэх эрхийн хязгаарыг тогтооно буй
 явдал нь өөрөө хэт төвлөрөлтийг үүсгэж буй мэт харагдах боловч энэ нь Европын
 холбооны хууль, Бундестаг, муж улсуудын парламентийн хууль тогтоох ажиллагааг
 үндсэн хуулиар хязгаарласан байдал, цаашлаад засгийн газрын бүрэн эрхийн
 зохицуулалтын өрнөлтөөс энэ байдал нь заринх тогтолцоотой гэж хэлж болно.
 Түүнчлэн Холбооны төвшинд хуулийг бундсрат тогтоох онцгой тохиолдол бол
 Канцлерт итгэл үзүүлэх тухай түүний хүсэлтийг бундсратийн гишүүдийн олонхи
 зөвшөөрөөгүй тохиолдолд Холбооны ерөнхийлөгч бундсратийг тараах шийдвэр гаргах
 эрхтэй бөгөөд харин Бундестаг нь ларатийн Канцлерийг сонгосон тохиолдолд
 Холбооны ерөнхийлөгчийн бундсратийг тараах эрх хүчингүй болж энэ үед Засгийн
 газраас хойшгууламшгүй тооцсон хуулийн төслийг бундсрат буцаасан тохиолдолд
 холбооны ерөнхийлөгч нь тухайн төслийн талаар хууль тогтоох онц байдал зарлах
 эрхтэй. Үүний үндсэнд бундсрат тухайн хуулийн төслийг баталж холбооны хэмжээнд
 үйлгэх хуулийг тогтоох бөгөөд тэр хууль нь Үндсэн хуулийг өөрчлөх, түүнийг бүхэлд
 нь болон хэсэглэн хүчингүй болгох, эсхүл дуусгавар болгох акт байж болохгүй
 тухай зохицуулсан нь хууль тогтоох эрхийг онцгой тохиолдолд Мэжүүлд гүйцэтгэх
 байгуулалтын төлөөлөгч байгаа гэж үзэх үндэстэй юм. Эцэст нь, энэ нь нэг
 талаас канцлерт итгэл үзүүлэхгүйтэй холбоотойгоор хууль тогтоох байгууллага
 "дэнжигэж" байх үед хийгдэж буй нийтийн ашиг сонирхолыг хэсэглэсэн бус
 бүхэл нь илэрхийлэн гарч ирсэн холбооны ерөнхийлөгчийн шийдвэрээр хийгдэж
 буй тухай үзсэн зөвшөөрөлөө авч нэгэн талаас аль нэгэн канцлерт итгэл үзүүлэхээс
 татгалзсан гэлтэй үндэслэлээр хуулийг тогтоох эрхийг автоматгаар шилжүүлж буй гэж
 үзэх үндэстэй юм.

Дээрхи үед орнуудын төрийн эрх мэдэл хуваарилааг, түүн дэх хууль тогтоох
 бүрэн эрхийг шилжүүлэх ажиллагааг бүхэл нь дүгтэж хэлбэл:

- Хууль тогтоох ажиллагааг шилжүүлж буй явдал нь үндсэн хууль ёс, түүний
 пөм болсон хууль эрх, эрх чөлөөлөгч хязгаарлагд тогтоохгүйгээр зөвхөн үлс
 төрийн тухайн нөхцлийн шийдвэрлэх зорилгоор хийгддэг.

- Хуулиар зохицуулалтааг харилцааг, зохицуулах шаардлагатай салбарыг
 нарийвчлан тогтоож өгснөөр хууль болж төрж гарах ёстой байж лээ гэсэн
 харуулалт хүргэхгүйн сапуу тэрхүү хуулиар зохицуулалтааг харилцааны
 шагуур, үзүүлэлт нь өөрөө хүний эрх, эрх чөлөөнөөс уртай гарч байгаа тухай
 гүйцэтгэх засаглалын байгууллагын гаргасан алив шийдвэр нь хүний эрхийг

зөрчлөө хэмээн тооцогдохгүй харин ч илүү тэрхүү хуулийг хэрэгжүүлэхэд тогтвортой шинжтэй

- Хамгийн гол нь хууль тогтоох эрх мэдлийг шилжүүлж буй тохиолдолд Үндсэн хуулиар хэнд шилжүүлэх болон түүнийг тодорхой хугацаагаар, тодорхой асуудлаар хязгаарлаж, эрх мэдлийн баланс алдагдахаас урьдчилан сэргийлдэг

Үндсэн хууль болон парламентат ёсны уг мөн чанарыг алдагдуулахгүй байх эрх зүйн бодлого баримталж түүнийгээ элдэв янзын хууль тогтоогчидийн болон нийтийн ашиг сонирхолыг дангаар илэрхийлэгчийн давхар хяналт, эсвэл хууль гаргах замаар илэрхийлж буй

Энэ үндсэнд ямар нэгэн асуудал гарвал би чи хэмээн таталцаж түлхэлцэхгүйгээр хариуцлагыг тодруулан, тэр дагуудаа улс төрийн соёлыг бий болгож хувийн хариуцлагыг дээшлүүлдэг зэрэг байдлуудыг дурьдаж болохоор байна. Эцэст нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас тогтоож буй хууль нь парламентийн зөвшөөрөгдсөн хэмжээнд хуулиар эрх олж авдаг бөгөөд тэрхүү засгийн газрын гаргаж буй хууль нь хүний үндсэн эрхийг хамгаалахад оршдог тул хүлээн зөвшөөрөгдөж байгаа,³² тэр дагуудаа хэрэгжих үндэсээ олж авдаг гэж дүгнэж болох юм.

Эрх мэдэл шилжүүлэх тухай асуудлыг социалист гэгдэх орчинд ярих нь туйлаас утгагүй юм. Учир нь тогтолцооны хувьд төргүй нийгэмд оруулах үзэл санаанам, түүний мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгсэл нь төр, намын мөрийн хөтөлбөрийг амьдралд ёсчлон буй болгож, гүйцэтгэн биелүүлэгч нь төр болон хувирсан нь өөрөө илүү гажуудлын систем болсон байлаа. Энэ үед институцийн төвшинд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг зааглан тусгаарлан байсан нь төлөвшил, цаашдын хөгжилд зохих хэмжээгээр нөлөөлснийг бас үгүйсгэх аргагүй юм. Тухайлбал, Монгол Улсын хувьд хууль тогтоох эрхийг УИХ,УБХ, хууль тогтоомжийг гүйцэтгэх ажиллагааг Засгийн газар, шүүн таслах ажлыг хэрэгжүүлэх шүүх зэрэг хэлбэрийн хувьд тусгаарлагдсан нь ажиглагддаг.

Тиймдээ ч барууны үзэл /өрнийн соёл, эрхийн зүй ёсны онол сургаалийг сурталдсан/-ийг дэмжигчидийг “баруунтан” хэмээх хаяг зүүлгэж нам-төрийн удирлагаас шахан зайлуулж Монголд социализм байгуулах туршилтыг³³ бий болгох нөхцөл тавигдаж байсан тул туйлшрал гэж хэлэх үндэстэй.

Тэгэхээр хууль хэний хүсэл зоригийг тусгаж байх тухай асуудал түүхэн цаг үе, хүмүүсийн шинжлэх ухаанч мэдлэгээр боловсролын төвшингөө дээшлүүлсэн

³²А.Шайо.Самоограничение власти. М., 1999. Ст 171.

³³Ж.Болдбаатар, Д.Лувдзэвэчин. Монгол улсын төр, эрх зүйн түүхийн үндэсний судал. УБ. 1997. 234 дэх тал

байдал, тухайн улс орны хөгжлийн хүрсэн төвшин зэргээс хамааран харилцан адилгүй байна. Үүнд:

хууль-нэг хүний хүсэл зоригийг илэрхийлэгч буюу төрийн хүсэл зоригийг илэрхийлэх. Энэ нь нэг хүний хүсэл зоригийг биелүүлэх хэрэгсэл болж байсан бөгөөд хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг /нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, үнэлэгдсэн шудрага ёс/ хангаж чадаагүй байсан учраас төдийлөн удаан хугацаанд оршин тогтнож чаддаггүй байнга хувьсан солигдож өөрчлөгддөг байна. Энэ тохиолдолд удирдагч субъект /хаан, баатар, тэргүүн, шашны тэргүүн/-ийг төр гэж ухамсарлагддаг. /энэ нь дотроо хууль тогтоох эрх мэдлийг олж авч буй аргаараа хоёр ангилагдаж болох юм/

а/ хууль-хүч хэрэглэх замаар хүний эрхийг зөрчих, гажуудуулах, дарангуйлах нэг хүний хүсэл зоригийг илэрхийлэх

б/ хууль-уламжлал, зан заншил, шашин суртлын нөлөөгөөр хүч үл хэрэглэж итгэл-бишрэл, хүндэтгэл, далдын ид шид, тогтсон дэг жаягыг дагах явдалд дулдуйдсан байдлаар нэг хүний хүсэл зоригийг тусгасан байх хууль-хэсэг бүлгийнхний хүсэл зоригийг илэрхийлэх. Нэг үзэл суртал, нэг ашиг сонирхолыг дөвийлгөн чамгүй хүчийг ашиглан энэ бололцоог өөртөө авч чадсан байна. Гэсэн хэдий боловч нийтлэг ашиг сонирхолыг тусгаж чадаагүй байдаг учраас мөн л албадлага хэрэглэдэг нь хүлээн зөвшөөрөгдөх үндэсгүй бөгөөд төдийлөн бат бөх оршиж чаддаггүй.

Хууль-тухайн нутаг дэвсгэрийн нийт хүмүүсийн нийтлэг зүй ёсны хүсэл зоригийг илэрхийлсэн байхын зэрэгцээ цөөнхийн ашиг сонирхолыг хамгаалахад чиглэсэн шинжийг илэрхийлэх учиртай. Энэ нь ямар нэгэн албадлага, хүчирхийлэл хэрэглэж хуулийг биелүүлэх тухай асуудал бус харин түүнийг дээдлэх тухай үзэл санаа бөгөөд нийгмийн гишүүд хэн аль нь адил тэгш боломж бүхий эрхийн орчноор хангагдсан, мөн төрийн хэрэгт оролцох бололцоо нээлттэй байдаг тул хууль өөрөө дээдлэгдэн хэрэгжих үндэс болдог.

Гуравдахь хандлага нь Бастиагийн тэмдэглэн бичсэнчлэн “хялбар дөт замаар өөрийнхөө хүслийг биелүүлэхийн тулд өөрт нь илрэн гарч ирэх харанхуй, бүдүүлэг, төрөлхийн бөгөөд номхотгохын аргагүй долдойч төрх нь чухам үүнд түлхдэг”³⁴ төдийгүй хүний энэ мөн чанар арилсан тохиолдолд л хууль бүрэн утгаар ард түмний хүсэл зоригийг илэрхийлэх тухай асуудал юм. Түүнчлэн бүх нийтийн хүсэл зоригийг тусгасан байх хувьдаа нэг бол системлэг бус эрээвэр хураавар авцалдаа муутай байх эсвэл нэг л загварын хэт ерөнхийлсөн хүсэл зоригийг тусгасан байх тухай асуудал хөндөгдөх юм. Ийм л учир шалтгаанаар эхний хоёр нөхцөл XX-р зууны хоёрдугаар хагасын

³⁴МОН ТЭНД. 7 ДАХЬ ТАЛД

хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьт явах эрх, итгэл тохилолгод Улсын хууль, бусад хууль заасан хүний эрх, эрх зөлөөт галхүү хуулиар

Улсын хуулийн 19-р зүйлийн 2-т: "Олс болон дайны байдал зарласан мэдэл улсын хуулийн төвшинд хуваарилагдсан байна гэж хэлж үндэстэй юм. зарчмыг агуулсан байх хувьцаа түүнээс салж болгийгээр сэтгэлт төрний эрх заагтуудаас харахад ариг түүнээс эх сурвалжтай гэр нь ардчилсан, шүүдэгт ёсны зүйлийн 1-д: "Монгол Улсад шүүх эрх мэлхийн галхүү шүүх хэрэгжүүлэгч" гэсэн "Монгол Улсад шүүх эрх мэлхийн галхүү шүүх хэрэгжүүлэгч", мөн хуулийн 47-р бол төрний гүйцэтгэх дээд байгууллага мөн", улсын хуулийн 47-р зүйлийн 1-д: хадгала", мөн Улсын хуулийн 38-р зүйлийн 1-д: "Монгол Улсын Засгийн газар дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэлхийн галхүү Улсын Их Хуралд Улсын хуулийн 20-р зүйл: "Монгол Улсын Их Хурал бол төрний эрх барих

Тодруулах нь:

байгалийн нэгдсэн асуулыг энэхүү нийтлэлээр тодруулахыг эрмэлзэ. Улсын хууль нь ололтой ая эрэг харж, няглан тодруулмаар зүйлүүд төөнгүй шалгуурыг хангасан байлаар илрэх юм. Гэвч өдгөөгөө эрэгн харахад 1992 оны туулураасан, хүндэг, эсрэнгүй, тэгш, шүүдэгт ёсыг наад зах нь агуулсан байх" тусган, зохицуулалтын гол арга, механизм нь зөвшөөрөл бүс хориглолгод бусад эрхийг хамгаасан, байгаа, нийгмийн хөгжлийн болит зүй тоглыг зөв

"Хууль хүлээн зөвшөөрөгдөхүйц байхын гол үндэс нь хүний жам ёсны бөгөөд хууль өөрөө зөвшөөрөгдөхүйц байх явцыг хангаснаар илрэх юм. байхын сагуу/зөв зүй тогтолыг тусгасан/хамгийн гол нь хууль дээдлэгдэх үндэс оршин байх аргагүй" нөхцлийн дагуу 1992 оны Улсын хууль маань бүтээгдсэн төрөлч яанараас үргэн гарсан байлийн улмаас хуульгүйгээр хүн өөрөө нийгэмд эсэхийг тогтоохыг оролдов: "...эрх зүй нь хүний дотоод навчин шинэсэн, түүнийг илэрхийлэх, тодорхойлохыг төрүүлсэн бололтой. Нийгмийн хөрсөнд бүжч ядсан хууль өөрөө нийгмийн хөрсөнд "гаараж" бусан нь эрэг холбоогоор нийгэм/масс-д хууль болсон хэмээн түүнийг хүлээн зөвшөөрөхгүй нь энэхүү Улсын хууль маань Монгол Улсын 1992 оны Улсын хуулийн шинэ, ардчилсан, дэвшилтэт Улсын хандалтаг үлс орнуулын хувьд түгээмэл болжээ.

80-аад он хүртэл байсан бөгөөд зүй ёсны шаардлагаар гуравдахь шатанд шилжих

үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулаах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө¹⁷.

Мөн хуулийн 20-р зүйлд: Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэсэнээс;

- ард түмний төлөөлөл, өөрөөр хэлбэл ашиг сонирхолын сонголтын үр дүнд бий болсон төлөөллийн ардчилалаар иргэд хуулиа бүтээж, тэр хувьдаа түүнийг дээдлэн хэлбэрэлтгүйгээр мөрдлөг болгон хэрэгжүүлэх, өөрсдийн нийтлэг ашиг сонирхолын хүрээгээр хязгаар тогтоон хүлээн зөвшөөрөгдсөн субъект эрхийн хамгаалалтыг тогтоох нь зүй ёсны асуудал болон тавигдсан гэсэн санаа цухалзаж байх хэдий ч өдгөөгийн бодит байдал тийм бус нь доорхи байдлаар тодруулагдана.

Дээр дурьдсанчлан зөвхөн хоёр л тохиолдолд /онц болон дайны байдал/ хүний эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлах гэсэн текстийн агуулга байх авч үндсэн хуулийн 16-р зүйлийн 18-д: ... улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно, үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-д: ... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно, Үндсэн хуулийн 5-р зүйлийн 3-т: Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно, гэсэнд тал өгч анхаарвал;

- нэг талд нэг нэгнээ малгайлан захирсан агуулга, системчлэл үгүй, тиймээс ч үндсэн хуулийн 19-р зүйлд заасан хоёр нөхцөлөөр л хүний эрхийг хязгаарлах юм хэмээн хүрээг нь хумиж ойлгох боломжгүй, өөр хоорондоо ойлгомжгүй байдал, зохицуулалтын сөргөлдөөнийг текстийн төвшинд агуулсан байх бөгөөд нөгөө талаар хүний эрх, эрх чөлөөг гагцхүү төлөөлөлийн байгууллага болох парламент /УИХ/ хуулийн хүрээнд л хязгаарлах гэсэн санаа илэрхийлэгдэж буйг дурьдах нь зүйтэй. Хуулийн хүрээний гол агуулга бол төрийн бодлого /улс түмнүүдийн өөрийгөө засан тогтнох хийгээд гадаад улс орнуудтай харилцах зан төлөв/, түүнийг илэрхийлэх төлөөлөгчид, төлөөлөх хувьдаа хуулийг дээдлэх механизмаар тодорхойлогдох хүлээн зөвшөөрөгдсөн субъектүүд нийтийн хүсэл зоригийг урьдчилан тандаж, түүнтэй өөрийн хүсэл зоригийг уялдуулах /мөрийн хөтөлбөрийн танилцуулга/ үндсэнд түүнийг чөлөөт сонголтоор утгажуулан энэ дагуудаа хийгдсэн үйлдэл /энд хууль батлан гаргах ажиллагааг ойлгоно Ж.Н./ байх бөгөөд энэ нь Монгол Улсын үндсэн хуулийн 25-р зүйлийн 1,1-д: ... Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг

¹⁷Монгол Улсын Үндсэн хууль, УБ, 1992.

санаачлан хэлэлцэж болох бөгөөд дармаах асуудлыг төрийн онцгой бүрэн эрхэд халгалж шийдвэрлэнэ.

1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, ... хэмээн биелэлээ олсон нь бий. Эндээс үзэхүл:

Монгол улсад хууль тогтоох ажлынхааг УИХ хэрэгжүүлдэг юм байна, хүний эрхийг дээр дурьдсан тодорхой тохиолдолд л хязгарладаг юм байна, нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтын хүрээний агуулгыг хууль л тодорхойлдог юм байна, эдгээрийн гол цогц агуулга нь хүний эрхэнд үндэслэсэн эрхийн орчныг бүрдүүлж хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чигт агуулагддаг юм гэдэг нь үндсэн хуулийн бусад эрх мэдлийн функциональ зохицуулалтаас илхэн харагддаг. Тухайлбал үндсэн хуулийн 38-р зүйлийн 1: ... Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн, гээд засгийн газрын бүрэн эрхэнд тусгахдаа энэ талаар илүү дэлгэрэнгүй тодорхойлсон, мөн хуулийн 45-р зүйлийн 1-д: ... Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоод, захирамж гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна гэсэн нь засгийн газар бол институтийнхаа хувьд ч тэр, функциональ хувьдаа ч тэр төлөөллийн байгууллагын бүрэн эрхийн илэрхийлэл хуульд нийцүүлэн дотоодод /захирааны эрх зүйн хувьдаа Ж.Н/ чиглэсэн зохион байгуулалт, даалгавар, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхийн актыг гаргах “боломж” бий нь харагддаг. Гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд: “...УИХ бол ард түмний итгэлийг авч төлөөлөлийг хэрэгжүүлэх үндсэнд хууль тогтоох онцгой бүрэн эрх бол хууль тогтоох эрх мэдэл бөгөөд энэ эрхийг өөр бусад ямар ч байгууллага, албан тушаалтан төлөөлөхгүй, ...төр, засгийн бусад байгууллага, албан тушаалтнуудын гаргаж байгаа актууд нь УИХ-аас гаргасан хуульд нийцэж байх учиртай”²⁸ хэмээсэн нь шударга төлөөлөлт, нийтийн хүсэл зоригийг илэрхийлэх хувьд нь хууль зүйн хүчин чадал хийгээд түүгээр тодорхойлогдох нийгмийн харилцааны шинж, төлөвийг тодорхойлсон явдал яах аргагүй мөн.

Дүгнэн хэлэх нь:

Үндсэн хуульд заасны дагуу хүний эрхийг тодорхой дурьдсан тохиолдолд зөвхөн хуулиар хязгаарлаж болох тухай заасан байдаг нь хэрэг дээрээ хэлбэр төдий хоосон “лоозон” болж хувирчээ. Хууль гэдэг агуулгал ардчилсан, чөлөөт, бүх нийтийн сонгуулиар сонгогдсон УИХ-аас тогтоож буй улс төрийн томъёолол-бодлого байх ёстой атал хэрэг дээрээ УИХ-аас батлагдан гарсан хууль байгаа боловч түүний

²⁸Монгол Улсын Үндсэн хуулийн тусбар, УБ, 2000. 136-дүгээр тал

дотоод дахь хуулийн зохицуулалт шаардлагатай, хууль зүйн хүчин чадлын хувьд дээгүүр байх эрхийн актаар зохицуулах харилцааг засгийн газарт мөнөөх хуулиар нь эрх олгон нийгмийн харилцааг зохицуулах нийтлэг хэм хэмжээ тогтоох эрхийг шилжүүлж, энэ дагуу хуулийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай хэсгийг нь "хаа гуяар нь салгаж" засгийн газрын шийдвэрээр зохицуулж байна. Тиймээс хууль нь хэсэг бусад эрх мэдэлтний гарт шилжүүлэгдсэн, тархай, бутархай хэлбэртэй, өөр хоорондын утга агууламж, авцалдаа муутай, эсрэгцсэн, нэг харилцааг засгийн газрын олон акт, хуулиас бүрдэх хэм хэмжээний цуглуулга зохицуулах болсон байна. Гол төлөв эрүүгийн хуулийн аж ахуйн эсрэг, улс төрийн эрх болон бусад эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, хүн амын аюулгүй байдал, хүн амын эсрэг, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг зэрэг болон захиргааны харивцлагын тухай хуулийн хариуцлагын үндэс нь бүгд гэж хэлэхэд нэг их хилслэхгүй байх засгийн газар, түүний харьяа төв, орон нутгийн захиргааны байгууллагаас баталсан дүрэм, журам, заавар байна. Өөрөөр хэлбэл засгийн газрын эрх зүйн актын үндэс нь хууль байх ёстой атал хуулийн үндэс нь захиргааны акт болон тогтжээ.

Нийгмийг бүхэлд нь эрх зүйн бодлогоор бус улс төрийн ашиг сонирхолын илэрхийлэлээр удирдах гэсэн санаа цухалтаж үүнтэй холбоотойгоор хуулиар эрх олгосны дагуу нийгмийн тодорхой харилцааг хэм хэмжээний актын дагуу зохицуулж байгаад нөхцөл байдал өөрчлөгдөхөд урьд үйлчилж буй дүрэм журмыг халж солих нэрийдлээр тухайн нөхцөлд тохирсон улс төрийн ашиг сонирхолоо шинэ актаар бий болгох боломжтой, энэ хүрээнд тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтын шаардлагыг засгийн газрын акт хангаж чадахгүйгээр үл барам үүндээ дулдуйдан нэг нэгнээсээ гинжин урвал мэт "цувруулсан" олон эрхийн актыг эх адаггүй гаргаж энэ нь эцэстээ эмх цэгцгүй, эрээвэр хураавар хэм хэмжээ болон тогтлоо. Засгийн газрын 1993 оны 162-р тогтоолоор баталсан "аймаг нийслэлийн засаг даргаас нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянах журам"-г баталсан нь онолын хийгээд практик хувьд асар их аюултай нөхцлийг дагуулж бүхэлдээ захиргааны нарийн дэг журам нийгмийн харилцааг зохицуулах үндэс болов. Өөрийнхөө гаргасан шийдвэрийг өөрөө хянадаг, эсвэл засгийн газрын үүрэг даалгаварыг биелүүлсэн тохиолдолд хэн нь хэнийгээ хянах гээд байгаа, системийнхээ хувьд өөртөө хязгаар тавих тийм "боломж" байхгүй, хяналт тавих тухай заасан эрх зүйн акт нь ядаж хууль биш зэрэг ноцтой алдаа үзэгдэх болов.

Эрх зүйг дээдлэх үзэл, иргэний нийгмийн тогтолцооны үед эдийн засаг, түүний өсөлт хөгжилтийг хангах арга механизм нь өөрөө илүү нээлттэй байж, ардчилсан зарчимд үндэслэж, ард түмний эрх ашигт нийцэмжтэй байх шалгуурыг хангасан хуулиудын бие биесээ тэтгэж, өрсөлдсөн, уян хатан, хоорондоо эсрэгцэх байдлыг

агуулаагүй байх ёстой. Гэтэл засгийн газраас эдийн засгийн бодлого, түүний хэрэгжилтийг хуульд "...энэ асуудлыг засгийн газар тогтоол гаргаж шийдвэрлэнэ, батална, тогтооно" хэмээн хязгааргүй өргөн эрхийг олгож засгийн газар ч энэ эрхээ дуртайхан хэрэгжүүлж бүх л газрын төсөв санхүүг яам агентлагуулаадаа эдийн засгийн үндсийг нь барих болж, ээлж дараалан шил шилээ даган гарсан актууд гаргах болов. Засгийн газрын 1997 оны 178-р тогтоолоор баталсан "яам, тохируулагч агентлагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон эрх зүйн баримт бичгийг хянаж бүртгэх журам"-ын дагуу ХЗДХЯ-аас хянаж бүртгэх эрхийг олгосон боловч нэгдсэн бүртгэл эмх цэгцгүйгээс чухам аль шийдвэр нь хүчинтэй, хүчингүй болсон нь мэдэгдэхгүй болсон. 2002 оны эхний хагас жилийн байдлаар яам агентлаг болон аймаг, нийслэлийн засаг даргын 200 орчим эрх зүйн акт бүртгэл, хяналтгүйгээр "цохиж явсан" нь шалгалтаар илэрсэн байна. Энэ бол ноцтой асуудал, хууль тогтоох онцгой эрх, ажиллагааг бэлэн үе шиг энд тэндгүй асгаж асгасан болгон нь алдаа болж байгааг харахад төвөггүй. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, техникийн бүхий л стандартууд горим, шаардлагыг захиргааны акт өөртөө агуулж энэ дагуу хууль нь амилдаг "арчаагүй" хараат байдал ноёрхов.

Парламентаас нэг хууль гаргасан бол тэр нь "мөнх" настайгаар оршдог. Тухайн хуулийн нэрийг нь л УИХ баталсан болохоос доторхи зохицуулалтын хэм хэмжээ нь бараг бүгд л Засгийн газар, түүний харьяа байгууллагын шийдвэрүүд бөгөөд тухайн харилцааны шинж өөрчлөгдөх тутам түүнд тохируулан эрх зүйн хэм хэмжээг бүтээж буй явдал гэж үзэхээс өөр аргагүй.

Яам, газар, засаг даргын эрх зүйн актыг албан ёсоор нийтлэх, хүчин төгөлдөр болох, улмаар нийтээр дагаж мөрдөх процессийн журамгүй байснаас ийнхүү хуулийн зохицуулбал зохих гол харилцааг өөртөө шилжүүлж авсны хувьд хууль нь мөнх болж он цагийн эргэлтээр хуучин акт, шинэ акт гэж л ярих үндэстэй болсон.

Засгийн газар, түүний харьяа байгууллагын акт хэрхэн хүчин төгөлдөр болох тухай зохицуулалт үгүйгээс түүнийг хүчинтэй эсэх, уншиж судлах, утга агуулгыг нь мэдэж дагаж мөрдөх асуудал үндсэндээ яриглахгүй болж "хязгааргүй ноёлох шинжтэй бага хууль" болон тогтсон нь энэ мөн.

Хууль тогтоогч дээрхи байдалд ер почирдсон шинжгүйгээр хүний эрхийн хязгаарлалт тогтоохдоо "улаан цайм" нөгөөх эрх зүйн актыг дурьдаж буй нь манай парламент чадваргүй, чансаагүй, нөгөө талаар бүрэн эрхэндээ тал өгч "ажил амжуулах" санаа болохоо нэгэнт илтгэсэн хэрэг байжээ.

¹ХЗДХЯ-аас Засгийн газрын хуралданд оруулсан танилцуулгас, 2002 он.

байцаар тайлбарлагдана.

Агууламч хувьд илэрхийлэгдэх гүй төлөлийнөн энэ байна гэж заагч боломж хомс хуулийн хөндөж, түүнийг зөрчилдүүлсэн шинжийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл текстийн бичиглэлийн хувьд үндсэн хуульд харш биш боловч агуулаар үндсэн боловч хууль тогтоох бүрэн эрхийг орлан хуулийн төвшинд шилжүүлж буй нь Хэлцлээр Засгийн газар нь эрх зүйн акт гаргах тухай эрхийн заалт бий энэ байдал чимээгүй хангаж байна.

Боловч дээр парламентал дээрхи агуулаар эрх олохгүй байх тухайг нь нэлэж хуулиар зохицуулна" гэсэн агууламч үндэслэл боловч санаагаа илэрх хэрэггүй боломжгүй, түүнд нэгтгэл төр-ирилэгийн нийтлэл эмээ харилцаат "энэ харилцаат газрын нийтээр латаж мөрдүүдэхээр тогтоосон хэм хэмжээ нь энэ гишүүдийг биедүүлэх нь эрх, эрх чөлөөт зөвхөн хуулиар хянагдаж болно" гэсэн агууламч хүрээнд засгийн болно. Энэ эрхийн акт нь тогтоох хэлбэрээр байна" гэсэн зохицуулалт нь "...хүний эрхийнхээ хүрээнд нийтээр латаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульчид нийцүүлэн бүрэн эрхийн газар нь 30-р зүйлийн 2-т: Засгийн газар нь

Хоёр: Засгийн газрын тухай хуулийн 30-р зүйлийн 2-т: Засгийн газар нь боловч хэт "сул гартай" байх нөхцөл нь харин хаа хаана нь тусгагдай байна. зохицуулах, шалгуурыг хувьд хүлээн зөвшөөрөгдсөн субъект байх нөхцөлийг хангасан Өөрөөр хэлбэл тавигдах шаардлагыг хувьд тухайн харилцаат зөвхөн хуулиар хуулийн дотор "туулайчүүлж" хууль тогтоох бүрэн эрхэд "хүргэж өгөх" болсон хуульч тусгагдайг лавимдуулан гүйцэтгэх эрхийг өөрийн бүрэн эрхэд дүлгүүдэн газарт онгой тохилолд шилжүүлж болох эрх тухай зохицуулалт өнөө хэр Үндсэн Энэ нь хоёр байцаар тайлбарлагдана. Нэгт: хууль тогтоох эрх мэдлийг засгийн үндсэн хууль явагал дүүгдд байх боловч агуулаар авч аргагүй тавигдах учиртай. Засгийн газраас бүрэн харат, түүний "дохио зангаараар" ажиглах болно. Үндс нь дээр энэ тухай яриа ойт байж болохгүй хуурамат зүйл төлөлийг хууль тогтооч нь Энэ бол хэрэгт эрх мэдлийг хуваариласан гэх боловч бодит байдал байж болохгүй агуулаар мөн.

Нөхөн гүйцээж тогтоох эрх олохын хувьд ч тэр, практик хэрэглээний хувьд ч тэр болохоос бүс хууль дахь хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхолын зохицуулалтыг зохинон байгуулалт, төлөвлөгөөний шинжийг агуулаар эрхийн актыг гаргах эрх бий Засгийн газар бол хуулийн биедлийг хангах, хэрэгжүүлэх үүднээс захираа-гүй байдал нэн түрүүнд ажиглагдаж байна.

Мэдлийг өөрт олгогдсон эрхэндээ дүлгүүдэн "наймалцаж", Засгийн газарт шилжүүлж Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн зохицуулалтаас гадуур төрийн эрх

Эцэст нь, хүний эрхийг хуулиар бүс захиргааны байгууллагын эрхийн актанд нэгтгэж хянаж буй нь хүний эрхийг хязгаарлах оноо байдаг зарчмыг, тийм эрхэнд хэмжээ үйлдэхгүй байгаа тул дайны үйлдлийн байдал гэж ойлгохоос өөр ямар ч бусад зарчмыг, хуульчгүй /эрхгүй/ болгодог, хуульчгүй техник/ зарчмыг, үндэслэлгүй “нийт”, “Хүн бүгд” гэх зэрэгтэй хамт байгаа хэмээн тогтооно.

Үүнийг засан сайжруулах, захиргааны дүрэм бүтээж үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа арга зам бол засаглалын байгууллагын өөрийн үйл ажиллагааг хуульч эрхийн зарчмыг тодруулан, түүний бүрэн эрх, үйлдлийн хуульчлах санал

оржиг өгсөн нь дээрхи байдал гол үндэс мөн. Үүнийг хуульчлан, “нийт”, “Хүн бүгд” гэх зэрэгтэй хамт байгаа хуульчлах зарчмыг засан сайжруулах, захиргааны дүрэм бүтээж үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа арга зам бол засаглалын байгууллагын өөрийн үйл ажиллагааг хуульч эрхийн зарчмыг тодруулан, түүний бүрэн эрх, үйлдлийн хуульчлах санал

Түүнтэй тухайлан өмнөх үеийн байгууллагын тогтолцоо, дүрэм, зарчмыг засан сайжруулах, захиргааны дүрэм бүтээж үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа арга зам бол засаглалын байгууллагын өөрийн үйл ажиллагааг хуульч эрхийн зарчмыг тодруулан, түүний бүрэн эрх, үйлдлийн хуульчлах санал

Тухайлан захиргаа, түүний байгууллагын үрэл өмнө үйлдлийг засан сайжруулах, захиргааны дүрэм бүтээж үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа арга зам бол засаглалын байгууллагын өөрийн үйл ажиллагааг хуульч эрхийн зарчмыг тодруулан, түүний бүрэн эрх, үйлдлийн хуульчлах санал

Энэ зарчмыг үрэл өмнөх баталсан хүчин төгөлдөр үйлдлийг бүтээж үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа арга зам бол засаглалын байгууллагын өөрийн үйл ажиллагааг хуульч эрхийн зарчмыг тодруулан, түүний бүрэн эрх, үйлдлийн хуульчлах санал

ЖИШИГ ЭРХ ЗҮЙ

(ХЗҮТ-ийн ОУЭЭС-ын эрдэм шинжилгээний ажилтан) Б. Гурьбасх

Үндэсний эрх зүйг хөгжүүлэхийн тулд хилийн чанадад эрх зүйг хэрхэн хөгжүүлж байна вэ, тэдгээрийн нөлөө Монгол Улсад хэрхэн бууж байна вэ гэдгийг судлах нь чухал. Эрх зүй судлаачид, тэр дундаа харьцуулсан эрх зүй судлаачид эрх зүйн талаар өөр өөрийн гэсэн төсөөлөл, үзэл баримтлалтай байдаг нь нууц биш. Ийнхүү өөр өөрийн төсөөлөлтэй байх нь нийгмийн шинжлэх ухааныг судлаачид хэрхэн яаж тайлбарлаж, хэр үндэслэл, нотолгоотой тайлбарлаж чалаж байна вэ гэдгээс шалтгаалж, үнэнд ойрхон, явцуу, туйлширсан гэх мэтээр ангилагдах боломжтой. Энэхүү нийтлэлд миний бие case law буюу бидний нэрлэж заншсанаар хэвшүүлэн хэрэглэх эрх зүйн тухай ойлголтын зарим асуудлыг тухайлбал, Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд case law-ийн эзлэх байр суурь, нэр томъёоны оноолт, Улсын Дээд шүүхийн тайлбар, мэдээллийг прецедентэд тооцох боломжтой юу гэдэг асуудлыг товч тодорхойлохыг зорив.

Нэр томъёоны асуудал. Case law-ийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох прецедент буюу тухайн харилцаатай төсөөтэй харилцааг урьд өмнө шийдвэрлэж байсан шийдвэр нь латинаар praecedentis, англиар precedent, оросоор прецедент, монголоор “хэвшүүлэх, “жишиг”, “хэвшүүлэн тогтоох хэм хэмжээ”¹, “хэвшүүлэн хэрэглэх хэм хэмжээ”² хэмээн олон янзаар нэрлэгддэг.

Case law гэдэг үгийн орчуулгыг монгол хэлнээ буулгахад түүний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох прецедент гэсэн үгийг орчуулах шаардлагатай. Шүүхийн шийдвэр хэрхэн прецедент болдог вэ гэвэл тухайн хэрэгтэй төсөөтэй хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийг цаг хугацааны хувьд хожим болсон хэрэг шийдвэрлэх ажиллагаанд иш үндэс болгоход л тэрхүү шийдвэр прецедентийн хүчин чадлаа олдог. Түүнээс биш, нэг хэргийг шийдвэрлээд тэр нь дараагийн төсөөтэй хэргийг шийдвэрлэх ажиллагаанд иш үндэс болоогүй бол түүнийг прецедент гэж үзэх нь учир дутагдалтай. Өөрөөр хэлбэл, шүүхийн эсвэл захиргааны байгууллагын шийдвэр болгон хэвших шинж агуулаггүй. Дараагийн хэрэгт эрх зүйн эх сурвалжийн адил хэрэглэгдсэн ч түүнийг хэвших гэж томъёололд оруулах боломжгүй юм. Учир нь

¹ “Англи-Монгол-Орос хууль зүйн толь”, С. Нарангэрэл, УБ-1994

² “Эрх зүйн шинжлэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо” Олон улсын симпозиум, 2000 оны 4 дүгээр сарын 25-27, Ханно-Зайдевийн сан, Б. Чинвад, илтгэл

Прецедент гэдэг үгний хамгийн зөв оноомтой монгол хэлний томъёолол нь жишиг юм. Жишиг гэдэг үгийг орос хэлнээ буулгавал стандарт гэдэг үгээр илэрхийлэгдэж болох талтай. Өөрөөр хэлбэл стандарт эрх зүйг, эрх зүйг стандарчлах үйл явц гэсэн утга илэрхийлэгдэж, эндээс томъёолол буруутаас хийхэд үүсэх боломжтой хэмээн эмээж болох юм. Хэрэв нийгмийн харилцааг стандарчлаж эхэлвэл эрх зүй цаашид хөгжихгүй гэдгийг бид бүтл мэднэ. Иймээс стандарт гэдэг үгний нэг зөвхөөрөө оруулах, нэг түүшиг барих гэдэг утгыг энд тусгаж ойлгож болохгүй юм. Харин түүний өөр нэг утга болох үлгэрчлэх, жиших гэдэг утгаар нь ойлгох хэрэгтэй. Иймээс тухайн хэрэг, маргаан, асуудлыг шийдвэрлэхэд үлгэр авч буй, жишиг буй эх сурвалжийг жишиг хэмээн нэрлэх нь зүйтэй. Тухайлбал, прецедентыг жишиг гээд, case law буюу бичгийн нэрлэж заншсанаар хэвшүүлэн хэрэглэх эрх зүйг жишиг эрх зүй гэж нэрлэх нь зүйтэй болов уу гэж санагдаж байна.

Жишгийн ангилал. Black's law dictionary³ бүтээл "шүүх эрх мэдлийг хэрэгсүүлэх явцдаа шинэ дүрэм журмыг хүлээн зөвшөөрч хэрэглэн хууль бүтээх үйл явц ба урьд шийдвэрлэгдсэн хэрэг нь хожмын ижил төстэй тохиолдол, шүүхээс шийдвэрлэх асуудал бүхий хэргийг шийдвэрлэх нөхцөл болохыг жишиг гэнэ. Дотор нь:

1. Binding precedent буюу шүүх заавал дагаж мөрдөх ёстой прецедент. Жишээлбэл, доод шатны шүүх нь хэрэг хянан шийдвэрлэхдээ дээд шатны шүүхийн уг хэрэгтэй төстэй хэрэг хянан шийдвэрлэснийг дагаж мөрднө.
2. Original precedent буюу шүүх эрх зүйн шинэ зохицуулалт бүтээж, түүнийгээ хэрэглэж буй тохиолдолд үйлчилдэг прецедент. Өөрөөр хэлбэл, тухайн харилцааг зохицуулах шинэ зохицуулалт бий болгож байгаа прецедент гэсэн үг.
3. Persuasive precedent буюу шүүхээс дуган мөрдөж ч болно, мөрдөхгүй ч байж болно гэсэн утга санаатай прецедент. Гэхдээ тухайн хэрэгт харгалзан үзэх шаардлагатай буюу тийм хүчин чалалтай. Жишээ нь, "ижил шатны шүүх дээр шийдэгдэж байсан бол заавал адил шийлтэ гэхгүйгээр шийдвэр гаргасан үндэслэлийг нь харгалзан үзэх боломжтой" гэжээ.

ОХУ-ын эрдэмтэд Л. В. Тихомирова, М. Ю. Тихомиров нар "голорхой төсөөтэй нөхцөл байллыг өөр нэг нөхцөл байдлыг жишиг болгон харьцуулах зан үйл. Төсөөтэй хэргүүдийг шийдвэрлэх үед тухайн буюу доод шатны шүүхийн шийдвэрийг эсвэл хүчин төгөлдөр хуулийг тайлбарлахдаа хэрэглэх зайлшгүй дагаж мөрдөх хүчин чадалгүй жишгийн хэлбэр. Шүүхийн прецедентын зайлшгүй шинэлийг нь хүлээн зөвшөөрч буй үед оронд эрх зүйн эх сурвалж нь болдог"⁴ хэмээн тайлбарласан байна.

³Black's law dictionary, seventh edition, Bryan Garner editor in chief, 1999, ISBN 0-314-22864-0

⁴"Суддеятельность и прецедент", автор: Тихомирова Л. В., Тихомиров М. Ю., издат. ЮРГИДИЦИУМЦЕНТР, Москва 2001, стр.695

Эндээс харахад жишгийг дотор нь хүчин чадлаар нь заавал дагаж мөрдөх, иш татах буюу тунхагласан шинжтэй гэж хоёр хэсэгт хуваан ойлгож болох юм. Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд иш татах буюу тунхагласан шинжтэй жишиг үйлчилж байгаа юм.

Мөн жишиг тогтоож буй субъектээр нь шүүхийн ба захиргааны гэж ангилж болно. ОХУ-ын эрдэмтдийн бичсэн Хууль зүйн тайлбар тольд¹ “Францын парламентын дотоод дүрмийг прецедентээр тогтоодог. Үүнээс гадна захиргааны байгууллагууд өөрийн үйл ажиллагаанд прецедентийг хэрэглэж байна” гэж бичсэн байна.

Жишиг ба заншил. Жишиг хэм хэмжээ ба заншлын хэм хэмжээний хоорондын ялгаа, төсөөний талаар судлаачид олон санаа дэвшүүлдэг. Зарим нэг нь энэ хоёр бараг ижил зүйлс гэдэг бол зарим нь хоёр өөр туйл руу зааглах жишээтэй. Эдгээр нь хоёул давтамж, хэрэглээний хувьд төсөөтэй мэт боловч яг үнэндээ бол тийм бус.

1994

1995

1996

1997

1998

1999

2000

2001

2002

2003

2004

2005

2006

2007

2008

2009

2010

2011

2012

2013

2014

2015

2016

2017

2018

2019

2020

2021

2022

2023

1994

1995

Жишиг хэрэглэх тухай заасан Монгол Улсын эрх зүйн эх сурвалж. Монгол Улсын 1994 оны шинэчлэн найруулсан Иргэний хуулийн 424 дүгээр зүйлд “Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэж болно” гэж заажээ. Энэ зүйлээс харахад гадаад улсын хууль, нийтээр хүлээн зөвшөөрсөн заншил хэмээн тодорхой заасан учраас жишгийг хэрэглэх боломжгүй болж байна. Гэвч уг хуулийн 425 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх, арбитр гадаад улсын хуулийг хэрэглэхдээ түүний хэм хэмжээний агуулгыг

¹“Юридическая Энциклопедия”, автор: Бойцков,В.В,Бойцова,Л.В. Москва 2000, стр. 800-803

гэдгээрийн албан ёсны тайлбар, хэрэглэдэг практикт нийцүүлэн тогтооно” гэж заасан учраас жишээ нь, ИБУИНВУ болон Нэгдсэн Вант Улсын хамтын нөхөрлөлийн орнуудын хуулийг хэрэглэх тохиолдолд тухайн шүүхийн жишгийг зайлшгүй авч үзэх хэрэгтэй болж байна гэсэн үг. Учир нь эдгээр зарим улсын хуулийн албан ёсны тайлбар, хэрэглэдэг практик нь жишгээр илэрдэг билээ.

Монгол Улсын 2002 оны Иргэний хуулийн 540 дүгээр зүйлд “гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх” гэсэн зохицуулалт хийжээ. Үүнд, “1. Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно” гэсэн нь шаардлагатай тохиолдолд гадаад улсын шүүхийн практик болон прецедентийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлаагүй бол Монгол Улсын хуулийн нэгэн адил хэрэглэж болно гэсэн утга санааг илэрхийлж байна. Түүнчлэн мөн зүйлийн гуравт “Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээнд ямарваа нэгэн эрх зүйн харилцааг тодорхойлоогүй, эсхүл түүнийг өөр нэрийн дор ялгаатай агуулгаар тодорхойлсон бөгөөд Монгол Улсын эрх зүйн хэмжээг тайлбарлах аргаар тодорхойлж болохооргүй бол түүний эрх зүйн ангиллыг тогтооход тухайн эрх зүйн харилцаа зохицуулсан гадаад улсын эрх зүйн хэм хэмжээг харгалзаж болно” хэмээн нарийвчлан тусгаж өгчээ.

Гадаад улсын эрх зүйн хэм хэмжээ гэдэгт тухайлбал ИБУИНВУ-ын эрх зүйн хэм хэмжээ, эх сурвалжийг аваад үзвэл парламентаар баталсан хууль буюу статут, олон улсын гэрээ, заншил, жишиг эрх зүй, хүлээн зөвшөөрөгдсөн хуульчдын бүтээл зэргийг эх сурвалжид тооцсон байдаг. Иймээс Монгол Улсын шүүх хуульд заасан энэхүү үндэслэлээр жишиг хэрэглэж болно. Мөн Иргэний хуульд заасан зөрчидөөний хэм хэмжээнүүд тухайн гадаад улсын жишиг хэрэглэж болохыг үгүйсгээгүй гэж хэлж болно. Тухайлбал, Иргэний хуулийн 546.1-д “Иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлахад тухайн этгээд алга болохоосоо өмнө, амьд байгаа тухай хамгийн сүүлчийн мэдээ ирэх үед харьяалагдаж байсан улсын хуулийг баримтална” гэсний харьяалагдаж байсан улсын шүүхийн жишгээр энэ холболтын зүйлийг тодорхойлж болж байгаа юм.

Тэгэхлээр Монгол Улсын хуульчид зөвхөн гадаад улсын хууль болон олон улсын гэрээ төдийгүй, заншил, шүүхийн практик болон прецедентийн бүтэц, ангилал, ойлголт, хүлээн зөвшөөрөгдсөн хуульчдын бүтээл, онол зэргийг нарийвчлан судлах шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Одоо шүүх дээр хэрхэн ямар жишиг тогтож байгааг харъя.

Жишээ. ⁶ Нэхэмжилж байгаа мөнгөний хэмжээний тухайд нэхэмжлэгчийн санаа зориг болон эд хөрөнгийн бус гэм хорыг арилгахад шаардагдах зардал зэргээс шалтгаалан харилцан адилгүй байна. Түүнчлэн хариуцагч нэр төрийг гутаасан мэдээлэлдээ тодорхой хэмжээний мөнгөтэй холбож гүтгэсэн тохиолдолд тэр тоогоор нь эргүүлэн нэхэмжлэх явдал гарчээ. “Хүмүүсийн амьдрал” сонины 2000 оны дугаар 28 “УГЖ Чимэдшээ эротик дүрд тогложээ”, “М. Батболд: Чимэдшээ эгч яг 18-г шиг маяглаж байсан” гэх мэтээр бичиж нэр төр гутаасан хэмээн Монгол Улсын гавьяат жүжигчин Ш. Чимэдшээ уг сонины газраас 5 сая төгрөг нэхэмжилснийг шүүх хариуцагч болох “Хүмүүсийн амьдрал” сонинноос 1 сая 485000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн нь сүүлийн 3 жилийн хугацаанд шүүх хариуцагчаас гаргуулахаар шийдвэрлэсэн хамгийн-их хэмжээний мөнгө болж байна.

Мөн зарим тохиолдолд /10 орчим хэрэг/ нэхэмжлэгчээс “...миний нэр төрийг мөнгөөр үнэлэх аргагүй” эсхүл “...хариуцагчийн санхүүгийн боломжийг харгалзан” гэх мэтээр эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг мөнгөөр үнэлэлгүйгээр нэр төрөө өөр аргаар сэргээлгэхээр шүүхэд хандсан ч тохиолдол бий.

1999-2002 оны хугацаанд хариуцагчаас нэхэмжилсэн мөнгөний дээд, доод, дундаж хэмжээ, мөн нэхэмжлэлийг хангасан шүүхийн шийдвэрийн эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг тогтоосон доод болон дээд, дундаж хэмжээ байдлаар гарсан байх юм.

д/д	Хаанаас тогтоосон/мөнгөн дүн/	Доод хэмжээ	Дундаж хэмжээ	Дээд хэмжээ
1.	Нэхэмжлэгчийн нэхэмжилсэн /мөнгөн дүн/	100000 төг	2 сая-30 сая төг	400 сая төг
2.	Шүүхийн шийдвэрээр хариуцагчаас гаргуулахаар тогтоосон /мөнгөн дүн/	42000 төг	200000- 500000 төг	1485000 төг

Энэ мэтчилэнгээр сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэх шүүхийн үйлдэл нь статут буюу бичмэл хуулиар шууд зохицуулж өгөөгүй байдаг. Харин судалгаанаас харахад 1 сая 485000 төгрөг хүртэлх эдгээр мөнгөний хэмжээг шүүгчид өөрсдийн дотоод итгэлээ ашиглан тогтоосон болж байгаа юм. Иймээс шүүгч хуульд заасан хэмжээ хязгаарт өөр өөрсдийн жишгийг гаргаж байна гэсэн үг.

⁶“Сэтгүүл ба хууль” цуврал. Дугаар-5 “Нэр төр гүтгэлтэ”, “Глоб Интернетшил” ТББ, УБ 2002, 64-65 дахь тал

Мөн Дээд шүүхийн тайлбар, мэдээлэл жишигт тооцогдох боломжтой юу гэдэг асуудал урган гарна. Дээд шүүхийн тайлбар нь хуулийн тухайн зүйл заалтын тогтоосон тэрхүү хүрээнд жишиг тогтоож байгаа юм. Мөн хэрэг хэрхэн шийдвэрлэснийг тайлбарласан мэдээлэл ч мөн адил. Энэ хоёр нь хоёул иш татах буюу тунхагласан шинжтэй жишигт тооцогдоно.

Эрдэмтэн багш Б. Чимид⁷ “Өөрийгөө таних гэвэл өрөөл бусадтай жиш гэдэг. Монголдоо тийм урт настай биш /1930-1992, 1992-өнөө/ эл тогтолцооны хөгжлийн хандлагыг төсөөлөхдөө өөрийнхөөс гадна өмнө, хойноо яваа болон бидэнтэй адил алдаж онож, адил бэрхшээл туулж буй бусад орны туршлага, сургамжийг судлаж харгалзах нь чухал. Бусад орны жишгийг судлаагүйгээ “Монголын онцлог” гэж хаацайлах, ойлгоогүйгээ “Монгол ухаан” гэж мунхаглах явдал үзэгдлийг нуугаад яах вэ, зайлшгүй харгалзах өөрийн онцлог гэж өч төчнөөн байлгүй яахав. Гэлээ ч хүн төрөлхтний олон зууны онол, туршлагаар нээж нотолсон нийтлэг жишиг байх шүү дээ” гэж хэлсэн байдаг.

Эртний Ромд магистрат болон преторуудын шийдвэрлэсэн хэргүүдийг жишиг хэмээн тооцож төсөөтэй хэрэг шийдвэрлэхэд заавал тулгаж үзэх ёстой байжээ. Мөн преторын шийдвэрүүд өргөжсөөр преторын бие даасан эрх зүйг бий болгосон байна. Ромын эрх зүйн олон институт шүүхийн жишигт суурилсан юм. Учир нь тухайн үед нийгмийн бүхий л харилцааг статутаар зохицуулах боломжгүй байсан ба эрх зүйн зохицуулалтыг шүүх бий олгож байв. Хожим тэдгээрийг төрөлжүүлж, статутын хэлбэрт оруулсан байна. Тэгэхлээр жишиг гэдэг нь ерөөс дан ганц далайн эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд эх газрын эрх зүйд ч мөн адил хамаарах боломжтой ба хүссэн, хүсээгүй түүний нэг бүрэлдэхүүн хэсэг болж байгаа юм.

Прецедентийг эрх зүйн эх сурвалжид тооцсоноор шүүхийн бүтээлч чанар зөвхөн зохицуулалтгүй тохиолдолд шинэ зохицуулалт гаргах явдлаар илрэх бус мөн зохицуулалт байсан ч гэсэн тухайн харилцаанд шинэ зохицуулалт бий болгож өгдгөөрөө онцлог ач холбогдолтой.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд жишиг эрх зүй үйлчилдэг, эсэх тухай маргах шаардлагагүй бөгөөд харин одоо бодитоор оршиж байгаа энэхүү эрх зүйг хэрхэн, яаж ойлгох, түүний шинж, хэмжээ, хамрах хүрээг тодорхойлох, эрх зүйн эх сурвалжид албан ёсоор тооцоход хангалттай хүчин зүйлс байна уу, үгүй юу гэдэг нь бидний өмнө тавигдаад байгаа ач холбогдол тавих шаардлага бүхий асуудлуудын нэг болоод байна.

⁷ Үндсэн хуулийн үзэл баримтлал, Б. Чимид, УБ 2002, 150 дүх тал

БНХАУ-ЫН ХӨДӨӨ ТОСГОНЫ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

*Өвөр Монголын Их сургуулийн Хууль судлалын хүргэлтийн
дэд профессор, МУИС-ийн докторант О.Хайтан*

БНХАУ бол газар тариалангийн том гүрэн мөн. Тариалангийн аж ахуй нь улс орны аж ахуйн салбарт тун чухал байр суурь эзэлж байдаг. Газар нь хөдөө тосгоны хамаг үндсэн үйлдвэрлэлийн хэрэгсэл байж, тариачдын аж төрж оршин тогнохын эх сурвалж мөн. Тариалангийн аж ахуйн ач холбогдлоос шалтгаалан газрын харилцааны өөрчлөлтийн хандлага хятад орны хөдөө тосгоны бүхий л өөрчлөлт, хөгжилтийн үндэс болж байдаг. Иймээс хөдөө тосгоны газрын эрх зүйн харилцааны төгөлдөржилт нь газрыг бүрэн гүйцэд ашиглаж, улс ардын аж ахуйг тогтвортой үргэлжлэн хөгжүүлэх, нийгмийг бүхэлд нь амар түвшин батлан хамгаалахад туйлын чухал эх сурвалж гэж үзнэ.

Хятад улсын хөдөө тосгоны газрын эрх зүйн тогтолцоо

Шинэ дундад улс байгуулагдсанаас эхлэн улс төр, аж ахуйн хөгжилийг дагалдан, улсын газрыг эзэмшин ашиглах дүрэм зэрэг газрын асуудалтай уяалдуулсан маш олон өөрчлөлт хийж, хятад улсын онцлог бүхий хөдөө тосгоны газрын харилцааг шингээр цогцлон хөгжүүлсэн байна.

Тавиад оны эхэнд газрын өөрчлөлт хийж, хөдөө тосгоны газрыг феодалын эзний өмчлөлөөс тариачдын анхан шатны хоршоодод хувь таслан өгч, тэд газраа өмчилж, ашиг шимийг нь хүртэх эрх бүхий газрын хамтын эзэмшлийн хэлбэрээр анхан шатны хоршоолол байгуулагдсанаар газрын эрх зүйн тогтолцоог буй болгов. Тавиад оны дунд үеэс далаад оны сүүлч хүртэл дээд зэргийн тариалангийн хоршоолол-ардын нэгдлийг байгуулж, хамт нийтээс газрыг эзэмшин ашиглах шинэ харилцаа төлөвшин тогтов.

1978 оны намраас эхэлж, газрыг өрх (гэр бүлд) урт хугацаагаар тогтвортой эзэмшүүлэх (даачлуулах) хамтран эзэгнэх хариуцлагын дүрмийг батлан хэрэгжүүлж эхлэн 1984 он гэхэд бүх улсын хэмжээнд үндсэндээ хэрэгжиж дууссан байна. Газрыг тариачдын өрхөд даачлуулах шинэ журам нь тариалангийн газарт “Хоёр эрхийг салгах” хууль зүйн бололцоо олгов. Тухайлбал газар өмчлөх эрх болон даачдан эзэгнэх эрхийг хамт нийтэд болон тариачин тус бүрт олгож, уул толгодын аливаа

- 4. Давчлуулсан этгээ газар даачлан эзэгнэх эрхийг зохицуулж, эсрэгээр нь хуульч ах холбогдолтой.
- 3. Газрыг тогтвортой эзэмшүүлэхийн тулд "үндсэн эгээ тогтвортой байж даачлан хугацаа 30 жил, бэлчээрийн газрыг даачлах хугацаа 30-аас 50 жил байхаар тогтоосон. Энэ нь тариачдын газрын эрх тогтвортой байхыг хуулиар тодорхой баталж, даачлуулсан этгээ (тогтооны зөвлөл)-ийн тани талач газрыг даачлан дураар дулаж, тариачдын эрх ашгийг хохируулахаас сэргийлсэн чухал ач холбогдолтой.
- 2. Даачлан эзэгнэх эрхээ гүйцэтгэх аргаар оруулах хэлбэрийг тодорхой тогтоосон. Үндс газар даачлан эзэгнэсэн этгээ газра өөрөө даачлан эзэгнэх, хуульч ёсоор шилжүүлж даачлуулах, түрээслэх, солилцох буюу бусад хэлбэрээр гүйцэтгэх аргаар оруулах эрх олгоосон аята хамаарна.
- 1. Даачлан эзэгнэх эрхийг гүнхэлэлтэй шинж чанараар биш, жинхэнэ боалттойгоор тогтоосон. Ингээс тариачдын газрыг даруй даачлан эзэгнэх эрхийг шүүд элэж, тэр нь хуулиар байх болсон.

Хөгөө тогтооны газрыг даачлах хууль нь дээрхи хэсэг тэрийг онцгой :

Хатаг улсын хөгөө тогтооны газрын эрх зүйн тогтооноос нэрт нэртэй тогтолёржсөн хууль зүйн тогтоолоотой болсонд "Иргэний хуулийн эрөнхий дүрэм"-д улам бүр баталж, хөгөө тогтооны газрын эрх зүйн харилцааны болит нотл багцлыг бүрдүүлж, эрх, үүргийн агуулгыг тогтоож өгөв. Үүний дотор 2003 оны 3 сараас эхлэн хэрэгжүүлсэн "Хөгөө тогтооны газар даачлах хууль"-ийг онцлон тэмцлэх нь онол, арга зүйн чухал ач холбогдолтой болно. Энэ хууль хөгөө тогтооны тариачин газар эзэмшиж ашиглах эрхийг хуульч ёсоор боалттойгоор амчлал хэрэгжүүлэх баталгаат хангасан бөгөөд төгс зарчим, үр ашгийг өөр хооронд нь уяагуулан, тариачдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж хөгөө тогтооны газрын харилцааг эрх зүйн шинэ зохицуулалтад оруулахад түүхэн шинэ үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Хатаг улсын хөгөө тогтооны газрын эрх зүйн тогтооноос нэрт нэртэй тогтолёржсөн хууль зүйн тогтоолоотой болсонд "Иргэний хуулийн эрөнхий дүрэм"-д улам бүр баталж, хөгөө тогтооны газрын эрх зүйн харилцааны болит нотл багцлыг бүрдүүлж, эрх, үүргийн агуулгыг тогтоож өгөв. Үүний дотор 2003 оны 3 сараас эхлэн хэрэгжүүлсэн "Хөгөө тогтооны газар даачлах хууль"-ийг онцлон тэмцлэх нь онол, арга зүйн чухал ач холбогдолтой болно. Энэ хууль хөгөө тогтооны тариачин газар эзэмшиж ашиглах эрхийг хуульч ёсоор боалттойгоор амчлал хэрэгжүүлэх баталгаат хангасан бөгөөд төгс зарчим, үр ашгийг өөр хооронд нь уяагуулан, тариачдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж хөгөө тогтооны газрын харилцааг эрх зүйн шинэ зохицуулалтад оруулахад түүхэн шинэ үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Тус хуульд зааснаар газар даачлан авагч нь даачлах эрхээ гүйлгээнд оруулах эсэх ямар хэлбэрээр гүйлгээнд оруулах тухайгаа өөрөө мэдэж шийдвэрлэнэ. Гагцхүү шилжүүлэх үед даачлан өгсөн этгээдээс (тосгоны зөвлөлөөс) зөвшөөрөл авч зохих бүртгэл хийлгэхээр заажээ. Ер нь БНХАУ-ын хөдөө тосгоны газрын эрхийн тогтолцоо нь улсын газар өмчлөлийн эрх, хамт нийтийн газар өмчлөлийн эрх, газар даачлах эрх, түрээслэх эрх, "дөрвөн атар"-ийн газрыг хэрэглэх эрхийг барьцаалах эрх, бусад сууц газрын эрх зэргээс бүрдэж байгаа болно.

Хөдөө тосгоны газрын эрх зүйн харилцаан дахь зарим шийдвэрлэвэл зохих асуудал

Хэдийгээр хятад улсын газрын хууль тогтоомж өдөр ирэхүйсэ төгөлдөржиж байгаа боловч онол, практикийн хувьд төдийлөн нэгдэлгүй байдал буюу шинжлэх ухаанч бус асуудал оршиж байх нь ажиглагдана. Энэ бүхнийг бид үргэлжлүүлэн судлах ёстой.

Юуны өмнө газар өмчлөлийн эрхийн субъект тодорхой бус байна. Тухайлбал Хятад Улсын Үндсэн хууль, "Газар зохион байгуулалтын хууль"-д хөдөө тосгоны газар нь тариачдын хамт нийтэд өмчлөгдөнө гэж тодорхой тогтоожээ. Гэвч тариачдын хамт нийтийн агуулга, зохион байгуулалт, удирдлага төв тодорхой байдаг хэдий ч бодит амьдрал дээр газрыг ихэвчлэн тосгонын зөвлөл, сумын захиргааны ордон өмчилж, өмчлөгчийн байранд байж, өмчлөлийн эрхийг хэрэгжүүлж байна. "Тосгоны зөвлөлийн зохион байгуулалтын хууль"-д тодорхойлоон байдгаас үзэхэд тосгоны зөвлөл нь хөдөө тосгоны хамт нийтийн газрын өмчлөгч болох ёс ер нь байдаггүй. Гэтэл тосгоны эрх баригч нь үнэндээн хөдөө тосгоны хамт нийтийн газрын эзэн мэт болчихсон, дур зоргоороо авирлах үзэгдэл орших болсон байна.

Улсын газар өмчлөх эрхтэй харьцуулбал хөдөө тосгоны хамт нийтийн газар өмчлөх эрх нь олон зүйлийн хязгаарлалтай байж, зөвхөн харьцангуй хуулийн хамгаалалтыг хүртэж байдаг. Улсаас түүний хэрэгцээ, гүйлгээ, шийдвэрлэлт зэрэг талд чанга хязгаарлалт тогтоосноос өмчлөлийн эрхийн зөвхөн нэгийг л эдлэж, үлдэх эрхүүд бүрэн бус байдаг. Энэ нь өмчлөлийн эрх тэгш шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.

Тариалангийн газрыг эзэгнэн даачлах эрхийн шинж чанар нь тодорхой бус байна. Энэ асуудалар эрдэмтэд, судлаачдын үзэл бодол адил бус буй. Энд голдуу өөрөө мэдэж захиран зарцуулах бодит эрх эдлүүлэх, эсвэл гэрээний хэлбэрт оруулж гэрээний үндсэн дээр эрх эдлүүлэх гэсэн хоёр өөр үзэл бодол явж байгаа юм.

Хэдийгээр "Хөдөө тосгоны газар даачлах хууль"-д газар эзэгнэн даачлах эрхийг эдлэхлээ хууль ёсоор шилжүүлэн даачлуулах, түрээслүүлэх, солилцох,

болголт мүүдэл, шинэ үзэхээр, хөдөө төстөний хамт нийтийн газрын өмчлөлийн үзэж болголт болгох. Одоо энэ асуудал маш их байртай байгаа юм. Тариачид 1. Хөдөө төстөний газар өмчлөх эрхийн зурьцааны асуудлыг нарийвчлан авч үзжээ. Хята улсын хөдөө төстөний тэрийн эрхийг үндсэндээ өөрчлөхгүй (ажмаар), эрхээр өргүүлж өгөхгүй гэж үзжээ.

Хята улсын хөдөө төстөний тэрийн эрхийг үндсэндээ өөрчлөхгүй (ажмаар), эрхээр өргүүлж өгөхгүй гэж үзжээ.

Үүнээс гадна зарим эрх зөрчилд өргөгдөж байгаа эрхийг өндөр үзэхгүй гэж үзжээ. Харин өөрсдийн байдалд зохих өөрчлөлт хийж нь хийж үзэхгүй өмчлөх үзэж байгаагаар газар танил өмчлөх хууль тогтоонолыг өөрчлөхгүй гэсэн асуудлыг байгаа билээ.

- Хөдөө төстөний газрыг хамт нийт өмчлөх замаар газрын эрх зүйн бүлэг хамт нийт ба тариачид өмчлөх
- Хөдөө төстөний газрыг үзэж, хамт нийт ба тариачид өмчлөх
- Хөдөө төстөний газрыг хувиулж өмчлөх
- Хамт нийтийн газрыг үзэж өмчлөх

Төсвийн хөрөнгийг хэсэг зүйлийн төлөв байлгах бий.

Төсвийн хөрөнгийг өргөжүүлж үндсэн сандаа болгож үзэх талаар газрын эрхийн хууль эргэлт, эргэлтийг хятад улсын хөдөө төстөний тэрийн эрхийн хууль болгох талаар хэлэлцсэн байна. Үүнд: Гол

Хөдөө төстөний тэрийн харилцаа

Хөдөө төстөний тэрийн харилцаа, хамтын ажиллагаа

Газрын үр шимийг дүүрэн ашиглаж эдийн засаагаа өргөжүүлж байгаа билээ. харьцааг нэмж зохих хууль зэрэг үйл ажиллагааг баруулах байдал хүрээ тариачид нийт аж ахуйн бүтцийг тохируулахад хэрэглэж, эсвэл газар даахад Үүнээс болж үйлдвэрийн хүчийг нэмж зохих хууль эргэлт хийж, болохыг зөвшөөрсөн болон барилдахад зөвшөөрөхгүй байх нь зохимжгүй. Газрын үзэж байгаагаар тариачид газар хэрэглэх эрхийг хийж байгаагийн өмчлөх эрх газар хэрэглэх эрхийг барилдах болохгүй гүйцэтгэсэн хамт 2. Хятад улсын "Газрын хууль" нь 27 дүгээр зүйл төстөний хамт (төстөний зөвлөлийн) зөвшөөрөл авах хэрэгтэй.

1. Дааргах эрх бүхий хууль зэрэг нийтлэгээр эрх шийдвэрлэх эрхийн байгаа юм.

Хятад улсын "Газрын хууль" нь 27 дүгээр зүйл төстөний хамт (төстөний зөвлөлийн) зөвшөөрөл авах хэрэгтэй. Хятадын хууль зөрчлөхгүй байх нь зохимжгүй. Газрын үзэж байгаагаар тариачид газар хэрэглэх эрхийг хийж байгаагийн өмчлөх эрх газар хэрэглэх эрхийг барилдах болохгүй гүйцэтгэсэн хамт

эрхийн субъектийн асуудлаар эрс өөрчлөлт хийж тийм субъектийг хуулийн эрхтэй байгууллагын хэв загварт оруулсан өөрчлөлт хийж, тариачдын хамт нийтийн хуулийн этгээд бий болговол зохистой гэж бодож байна. Хуулийн этгээдийн эрхтэй байгууллага нь тариачдын төлөөллийн байгууллагын хэлбэрээр зохион байгуулагдахын хамт эд хөрөнгийн зохих эрхийг ч эдэлдэг байх нь зүйтэй. Тийм байгууллага нь үлгэрлэвэл тариачдын хамт нийтийн гишүүдийн их хурал буюу төлөөлөгчдийн хурал байж болно. Тэрхүү хурал тариачдын хамт нийтийн өмчлөлийн эрх бүхий субъект байж энэ эрхээ бүрэн хэрэгжүүлэх хуулийн этгээдийн байгууллага байх болно. Тус зохион байгуулалт нь бүх тосгоны газрыг ашиглах хэлбэр, хувиарлалт, даачлах журам, газар ашиглалт зэрэг хүний амин чухал асуудлаар шийдвэр гаргаж, тариачдын эрх ашгийг төлөөлж, үзэл бодлыг тусгасан байгууллага байх ёстой. Нөгөө талаар дурьдсан зохион байгуулалт нь тариачдын хамт нийтийн хувьд хамгийн дээд шатны байгууллага болохын зэрэгцээ тосгоны зөвлөлийн хувьд гүйцэтгэх байгууллага байх хоёр шинжийг нэг зэрэг хадгалах болно. Гүйцэтгэх байгууллага болохын хувьд тосгоны ардын зориг санааг илэрхийлэн хэрэгжүүлэхээр барахгүй бас тосгоны зөвлөлийн зарлиг шийдвэрийг хэрэгжүүлэн биелүүлэгч болно. Ингэснээр тосгоны зөвлөлийн үүрэг, чадамж, шинж чанарыг хувиргаж, тариачдын төлөөлөгчдийн хурлын үзэл бодлыг илэрхийлэн төлөөлж, тариачдын хамт нийтийн эрх бүхий байгууллага, хяналт тавих байгууллага, гүйцэтгэх байгууллагын харилцаа уялдааг холбосон нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

- Газрын эрхийн агуулгыг тодорхойжуулж хуульчлах. Хятад улсын “Иргэний хуулийн ерөнхий дүрэм”-ийн 3-р зүйлд: “Эд хөрөнгийн өмчлөгчийн эрх бол өмчлөгч нь өөрийн эд хөрөнгийг эзэмших, хэрэглэх, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль ёсоор эдлэн даана” гэж заажээ. Тариачдын хамт нийтийн өмчлөлийн эрхийн өмчлөгч хамт нийт нь газраа үнэнхүү эзэмших, хэрэглэх, ашиглах, захиран зарцуулах эрхийн чадамжтай байх хэрэгтэй. Тариачид газрынхаа хамт нийтийн өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэх явцдаа, уг газрыг эзэгнэн даачлах эрхийн бодит шинж чанарыг хадгалан баталж, түүний агуулгыг бүрнээ хэрэглэж чалахыг хуулиар тогтоох ёстой, харин зөвхөн хоёр этгээдийн хэлцэл болзолгоор тогтоох ёсгүй. Жишээлбэл: хууль ёсоор даачлах эрх бүхий хүн газрыг эзэгнэх эрх, ашиг шим хүртэх эрх, бүтээгдэхүүнийг захиран зарцуулах эрх зэргийг эдлэж байх ёстойг хуулиар тодорхой тогтоох хэрэгтэй юм.
- Газрын гүйлгээний тогтолцоог төгөлдөржүүлэх. Тариачдын зохих нөхцөлийн доор газар эзэгнэн даачлах эрхээ барьцаалж болохыг зөвшөөрөх ёстой. “Зохих нөхцөл” гэдэг нь барьцаалахад чухал бүхий хязгаарлал тогтоож өгөхийг хэлж буй. Тухайлбал, даачлах эрхийг эдлүүлэхэд тариалангийн ажил тогтмол

эрхлэдэггүй байх, мэргэжилтэй буюу тогтмол орлоготой байх, даачлуулах этгээдийн зөвшөөрөл авч байх, даачлах эрхийг бүрнээр буюу хэсгээр зохих хугацаагаар тариалан эрхлэж буй тариачдад барьцаалах зэрэг хязгаарлалтууд байж болно. Эдгээр нь тариачдын үндсэн амьдралд сүйтгэлийн чанартай цохилт өгөх боломж бүрдүүлэхгүй, харин тэдэнд өөрийн газар эзэгнэн даачлах эрхээ зохистой ашиглаж үр шимийг олох идэвхжлийг дээшлүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлж өгнө.

4. Засаг захиргааны зохисгүй харшил (хүнд суртал)-ыг арилгаж, тариалангийн газрын ашиглалтыг шуурхай шийдвэрлэх эрх зүйн харилцааг баталгаатай болгох. Тариачид хамт нийтийн өмчлөл дэх эд хөрөнгөө тариачдын өөртөө засах байгууллагаар, өөрөөр хэлбэл гишүүдийн их хурлаас шийдвэр гарган эзэгнэхэд шааргдагдах санхүүгийн төсөвтэй байх, бэлэн мөнгөөр хувь оруулах зэрэг асуудлыг өөрсдөө шийдвэрлэдэг байх нь зүйтэй. Гишүүдийн их хурал нь хамт нийтийн эд хөрөнгийн хамааралтын дүрмийг тогтоож, өөртөө засах байгууллагыг байгуулж байх эрхээ баттай хэрэгжүүлэх ёстой.

Тариачдын өөртөө засах байгууллага нь тариачдын хамт нийтийн эд хөрөнгийг шууд хэрэглэснээс үүссэн үр шимийг тариачдын хамт нийт өмчилж, захиран зарцуулдаг байвал зохино. Ер нь тариачдын хамт нийтийн өмчлөлийн эрхийг хэрэгжүүлж зарим онц чухал эд хөрөнгийг захиран зарцуулах эрхийг гишүүдийн их хурал шийдвэрлэж байгаа нөхцөлд л тариачдын өөртөө засах байгууллага бодитой оршиж, ажиллаж чадна. Тариачдын өөртөө засах байгууллага нь гишүүдийн их хурлаас олгосон эрх хэмжээн дотор шийдвэр гаргаж өөрийн эрхийг хэрэгжүүлэх болно.

Тариачдын хамт нийтийн эд хөрөнгө ямарваа нэг хууль бус халдлагад өртөх үед тэрхүү халдлагыг зогсоох талаар тариачдын өөртөө засах байгууллага шүүхэд хандаж байх ёстой. Хэрэв шүүхэд нэхэмжлэл гаргахгүй тохиолдолд эд хөрөнгийг хариуцагч ажилтан буюу бусад этгээдээс хохирлыг гаргуулах асуудлыг тариачдын өөртөө засах байгууллага хариуцан гүйцэтгэвэл зохино. Ингээгүй тохиолдолд тариачдын хамт нийтийн гишүүн өөрөө шүүхэд нэхэмжлэл гаргаж эрхээ хамгаалуулах нь зүйтэй.

Ашигласан ном зохиол:

- Нийтийн өмчлөл болоод хятад улсын бүтцийн эрхийн хууль
- Менд чи гуо. "Хууль зүй" сэтгүүлийн 2004 оны №2
- Ван вуй гуо. Хятад улсын газрын эрхийн судлал, Бээжин, Хятад улсын хууль зүйн их сургуулийн хэвлэлийн хороо 1997 он

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОЛБОГДОЛТОЙ НЭР ТОМЪЁОНЫ ХАРЬЦУУЛАЛТ

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн
төвлөлийн багш, докторант Д.Яковлевсүржээ*

Монгол Улсын шинэ иргэний хуулийг боловсруулахдаа зах зээлийн харилцаа гүнзгий хөгжсөн олон орны хуулийг харьцуулан судалж жишээ авсны дотор германы Иргэний хууль жинтэй хувь нэмэр эзэлнэ. Иймд судлаачид болон хуулийн ангийн оюутнуудад шинэ хуулийнхаа зарим нэр томъёог Германы иргэний эрх зүй дэх өдөр тутмын хэлцэлтэй холбоотой хамгийн өргөн хэрэглэгддэг зарим нэр томъёотой харьцуулан ойлгоход дөхөм болгох үүднээс доорхи ойлголтуудыг толилуулж байна.

Иргэн хүний шаардах эрх

Иргэд ямар нэгэн эрхийнхээ талаар маргалдана гэдэг нь шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдүүлэх шаардах эрхээ хэрэгжүүлж байна гэсэн үг. Иргэн хүн нэхэмжлэгчийн хувиар өөр нэг иргэний эсрэг, эсвэл тодорхой байгууллагыг хариуцагчаар татаж нэхэмжлэл гаргахдаа юуны өмнө доорхи асуудлуудыг шийлэх ёстой болдог:

Би юу хүсч байгаа билээ? /Үүрэг гүйцэтгүүлэх, бараа бүтээгдхүүн нийлүүлэх, төлбөр төлөх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, тодорхой үйлдэл хийлгэх, хүсэл зоригийн илэрхийлэл, буцаан олгох, нөхөн сэргээх гэх мэт/

Хариуцагч нь хэн бэ? /насанд хүрсэн хүн, насанд хүрээгүй этгээд, албан байгууллага, эсвэл нэгдэл гэх мэт хуулийн этгээд/

Шаардах эрхийн үндэслэл нь юу вэ? /жишээлбэл гэрээ/

Шаардах эрхтэй болохоо юугаар батлах вэ? /тухайлбал гэрээ байгуулагдсаныг батлах/

Иргэний эрх зүйн үндсэн ойлголтууд

Дээрхи асуудлуудад хариулахад удирдлага болгох ихэнх журам хувийн эрх зүйд хамаарна. Тэдгээрийг тайлбарлахад шаардагдах үндсэн ойлголтуудыг тодруулья.

Хүчин төгөлдөр бусад тооцуулах гэдэг нь уг нь хүчин төгөлдөр боловч байгуулахад учир дутагдалтай байсан хэлцлийг нэг тал хүсэл зоригоо илэрхийлснээр болиулах гэсэн буцах үр дагавар бүхий үйлдэл юм. Хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэлд төөрөгдөх, хууран мэхлэх, айлган сүрдүүлэх замаар хийсэн хэлцлүүд орно. Хүчин төгөлдөр бусад тооцох өөр үндэслэл

тусгай хуулиудад мөн зохицуулагдсан байж болно. Тухайлбал: Дампырч буй аж ахуйн эрхжилт бусдад хийсэн нийцсэн бэлтгэлийн гэрээ гэх мэт.

Шардах эрх гэдэг нь бусдаас тодорхой үйлдэл/үйлсэл, хүсэл зорилгын нэрхнийг, үүрэг гүйцэтгэх, буцааж өгөх/эсвэл эс үйлдэхгүй хийхийг шаардах эрх юм.

Болов гэдэг нь ирээдүйд болох эсэх нь тодорхойгүй байгаа үйл явцтай хэлнэ. Хэсэг нийц төлөлдөр болох эсэх нь тодорхой боловч хамаралтай байж болно. Харин тодорхой боловч хамарч болохгүй нь. Ер бүй болох, хүүхэд үрчэх, хүүхдэд төлөлдөр бусал тооцуулах, гэрээ гүйцэх, гэрээгээс татгалзах, үл хөлтөх хөрөнгийн Aufrechnung, Auflassung.

Эрх зүйн хамаралтай чөлөөтэй хүмүүс гэдэг нь 7-18 насны иргэд юм. Насанд хүрсэн хүний эрх зүйн чөлөөтэй тодорхой шалтгааны улмаас/эцэг төрийн дон, сэтгэлийн эмгэг, хэт хөнгөрлийн шинж тэмдгүүд гэх мэт/шүүхийн журмаар хянагдаж болно. Тухайн эрх зүйн өөрөө бие даан гүйцэтгэх боломжгүй үүргийн хувьд асар хамгаалагчид шүүхээс халамжлага

томилж өгдөг байна.

Эзэмшил гэдэг ойгогчид өмчлөхөөс ялгаж ойлгох шаардлагатай. Тухайн эзэмчид өмчлөгч нь хэн байхаас үл хамараар эзэмчид болит хүний дорно байдлаар олгоно. **Өмчлөл** гэдэг нь өмчлөгчид тухайн эзэмчид захирал зарлуулах/устгах, эзэмчид аргаар хүлээх эсвэл бусад шилжүүлэх гэх мэтээр/хятааргүй эрх өгдөг ололт эрх юм.

Өмчлөл гэдэг нь нас барагчийн эрхийг залмаж ямаа юм. Нас барагчийн эз хөрөнгө нь бусдад төлөх ёстой өр, бусдаас авах авчгаж хамт өлгөгчид шилжинэ.

Биегүй гэдэг нь гэрээнд заасны дагуу үүрэг гүйцэтгэхийг хэлнэ.

Гэрээний хуяанга Fidelity гэдэг нь үүрэг биегүйгэх пат үерийг хэлнэ.

Эрх зүйн чөлөөтэй гэдэг нь бие даан хүний төлөлдөр хэлэл байгуулах явцарь хэлэх бөгөөд 18 насанд хүрсээр эхэлнэ.

Эрх зүйн чөлөөтэй этгэд гэдэг нь 7 насанд хүрээгүй хүмүүс болоно сэтгэл мэдрэлийн өвчний улмаас хүний төлөлдөр хүсэл зорилгын эрхийг боловч хүмүүсийн хэлэх, Ийм хүмүүсийн илэрхийлсэн хүсэл зорилгын шүүхийн эрх зүйн онолтойгоо.

Баталгаа гэдэг нь худалдаа, эсвэл үйлдвэрлэл хуулиар авчгаж захиалагчийн

өмчнө тухайн эзэмчид биед байхгүй, тухайн хэлэх буй шинж явцаарь агуулаж байгаа болохыг баталж буй хэрэг юм.

Хүлээгдэж буй үйлдэл гэдэг нь бусдад гэм хор үрхүүлснээр үйлдэл, нөхцөл байдалыхаа төлөө

зохиж харилцал хуулиар гэгсэн үл.

Харилцаа гэдэг нь бусдад гэм хор үрхүүлснээр үйлдэл, нөхцөл байдалыхаа төлөө зохиж

Хэрэв байшин гал түймэрт шатсан гэж үзвэл гал түймэр тавьсан гэм буруутай этгээд өмнөх байдлыг нь сэргээхдээ тухайн барилгаар зогсохгүй, үл хөдлөх хөрөнгө /газрыг/ мөн нөхөн сэргээнэ. Шатсан барилга хэдэн арван жил болсон хуучин барилга байсан ч түүнийг нь засан сайжруулах үүрэг үүснэ. Харин энэ тохиолдолд шинээр барилга барьж өгөх нь эдийн засгийн хувьд өөр нөхцөл байдал /хэт давуу байдал/ үүсгэхээр бол мөнгөөр нөхөн төлүүлдэг байна. Ер нь хохирлыг нөхөн төлснөөр байшингийн үнэ цэнэ өмнөхөөсөө нэмэгдэхээр бол ийнхүү нэмэгдсэн хэсгээр нь хохирогч хамт хариуцдаг байна.

Ерөнхийдөө нөхөн төлөх ёстой хохиролд тухайн нөхцөл байдлаас шалтгаалан олох ёстой байсан ашиг орлогыг мөн оруулан тооцдог.

Бусдын хувийн эрхийг зөрчсөн /үүнд худал мэдээ тараахаас эхлээд эр эмийн харьцаанд орсон мөртөө шалтгаангүйгээр сүйгээ цуцлах хүртэл ордог/ -өөс гэм хор учрах тохиолдолд зохих хуулиудад заасан хориотой үйлдэл хийсэн бол "өвчин шанлалын мөнгө" нэртэйгээр эдийн бус хохирлоо нөхөн төлүүлж болно.

Нэхэмжлэгч өөрөө нотолж учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээс гадна гэрээний торгууль болон бусад төрлийн хохирлыг /тухайлбал гэрээний үүргийн зарим хэсгийг биелүүлээгүйгээс гэрээг бүхэлд нь биелүүлэх боломжгүй болсноос учирсан хохирол/ нөхөн төлөхөөр урьдчилан тохиролцсон тохиолдолд тэдгээрийг шаардах эрхтэй.

Хэд хэдэн шаардах эрх нэгэн зэрэг үүсдэг бөгөөд тэдгээрийг зэрэг хэрэгжүүлэх боломжтой.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТ (Монгол, Японы үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн харьцуулалт)

Шинэсүтүг ХЗ/С-ийн бэлтгэгч, докторант О.Цэцэгмаа

Монгол улс 1992 оны шинэ үндсэн хуулинд үл хөдлөх хөрөнгийн суурь ухаглахуун болох газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлэх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах, өв залгамжлах эрхийг баталгаатай эдлүүлэх тухай хуульчлан баталгаажуулсан билээ.

Ийнхүү үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой эрх зүйн харилцааны зохицуулалтыг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай зэрэг хуулиудад бэхжүүлж, иргэдэд хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх бодит боломжийг олгосон билээ.

Эдүгээ үл хөдлөх эд хөрөнгө, түүний бүртгэл, түүнтэй холбоотой асуудал иргэний эрх зүйн харилцаанд чухал байр суурийг эзлэх болж цаашдын хөгжлийн үйл явц эрчимжих боллоо. Үл хөдлөх эд хөрөнгө иргэний гүйлгээнд идэвхтэй оролцох болсонтой холбоотой гэрээний эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Ийм учраас бусад орны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалттай харьцуулахыг зорилго.

а/ Япон улсын хувд үл хөдлөх хөрөнгийн бүртгэл нь олон жилийн түүхтэй бөгөөд газар болон барилга байгууламжийг тус тусад нь бүртгэлэг байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн зорилго нь субъектын эрхийг хуулиар хамгаалахаас гадна үл хөдлөх эд хөрөнгийн гүйлгээ, гэрээ зэргийн эрсдэлгүй, байдлыг хангаж баталгаажуулах гэсэн нийгмийн чухал үүргийг гүйцэтгэж байна.

Япон улсад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг төрийн байгууллага хариуцан ажилладаг. Японы иргэний хуулийн 176 дугаар зүйлд зааснаар үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдсон эрх нь субъектын хүсэл зоригийн илэрхийллээр өөрчлөлт, хөдөлгөөнд орно. Жишээлбэл: "Х" байшингийн эзэмшигч, "А" тухайн байшинг "В"-д худалдах тохиолдолд "Х"-ийн байшин нь зөвхөн "А". "В"-ын хоорондын тохиролцоогоор л "В"-ын эзэмшилд шилжинэ.

Тухайн гэрээг нотариатаар баталгаажуулах шаардлага байхгүй.

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл нь тус улсын Иргэний хуулийн 177 дугаар зүйлд зааснаар гуравдагч этгээдээс хууль ёсны эзэмшигчийг хамгаалах үүрэгтэй.

Өөрөөр хэлбэл “В” нь “Х” байшинг “А”-аас худалдан авч, бүртгэлийг өөрийн нэр дээр шилжүүлсний дараагаар “С” гарч ирж “Х” байшинг өөрийн өмч хэмээн маргаан үүсгэсэн тохиолдолд “В” нь бүртгэлийн үйлчлэлээр эзэмших эрх хамгаалагдах болно.

Гэтэл монголд үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой гэрээг нотариатаар батлуулж байж хүчин төгөлдөр болдог ба Японд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сонирхогч этгээдийн мэдүүлгийг үндэслэж төрийн байгууллага болох Хууль зүйн яамны харьяаны Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар гүйцэтгэдэг бөгөөд холбогдох бүх журам нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн хуулиар зохицуулагдсан байна.

Япон улсад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль болон Хууль зүйн яамнаас батлан гаргасан журмын дагуу явагддаг.

Тус улсад газар ба байшин барилгыг тус тусад нь бүртгэдэг тул нэг мужид 10-аас дээш тооны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газартай.

Үл хөдлөх эд хөрөнгийн мэдүүлгийг гаргахдаа эрхийг шилжүүлэн өгч буй этгээд болон эрхийг шилжүүлэн авч буй этгээд хамгарч гаргана. Жишээ нь: байшин худалдсан хүн ба худалдан авсан хүн хамгарч зохих мэдүүлгийг бүрдүүлж, шаардлагатай баримт бичгийг хавсарган харьяаллынхаа үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт өгөх ёстой. Ийнхүү бүртгүүлэх үед үл хөдлөх эд хөрөнгийн зөвшөөрлийн татвар /хураамж/ хэмээх улсын татварыг төлнө.

Үл хөдлөх хөрөнгийн бүртгэгч мэдүүлгийг хүлээн аваад дугаар олгож, мэдүүлгийн агуулга ба бүртгэлийн дэвтрийг харьцуулан алдаа малаг байвал мэдүүлгийг буцааж, хэрэв ийм бус бол бүртгэлийг гүйцээх ёстой.

Бүртгэл дууссан тохиолдолд мэдүүлэгт хавсаргасан бичиг баримтанд бүртгэгдсэн тухай тамга дарж, мэдүүлэг гаргагчид буцааж өгнө. Мэдүүлэг нь бүртгэлийн дэвтрээс тусдаа хадгалагддаг. Тэдгээр нь тус тусын хувийн дугаарын дэс дарааллын дагуу хадгалагдаж байдаг тул хайж олоход маш хялбар юм.

Японд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлээр зогсохгүй ер нь ямар ч гэрээг нотариатаар батлуулах шаардлагагүй. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг даалгаврын гэрээгээр бусдаар төлөөлүүлэн хийлгэж болох боловч түүнийг зөвхөн мэргэжлийн хүн л хийх эрхтэй. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн бараг бүгдийг нь шихо шоши¹ нар төлөөлөн гүйцэтгэдэг.

¹ Өвөг эсргийн хууль

Эр нь гэнэ Японор зогсохгүй барыга гэдэг нь аливаа эдийн засгийн үйл ажиллагаатай
 байна. Мөн ихэнх иргэн орон сууц, газар зэргийг худалдан авалтаа барыганы эрхийг ашигладаг
 барыганы эрх нь урт түүхтэй учир хууль зүйн орчин нь ч нэлээд боловсролгүй болсон
 орлууд, мөнхийг нь эзэлүүдэг буюу барыгалагчид олгодог.
 Биедүүдэггүй тохиолдолд барыгалагчид үйл хөдлөх эд хөрөнгийг шүүхээс лудуулаа худалдаанад
 эзэлүүдэг, эзэлдэг хоёронд нь гэрээг үүсгэнэ. Жишээ нь: Гэрээний үүдгээ
 барыганы эрх нь барыганы объект болон үйл хөдлөх эд хөрөнгийн эзэмшигч,
 хамгийн өргөн хэрэглэгч нь /эдийн/ барыга юм.
 Япония иргэний хуульд төрлийн барыганы эрхийн талаар зохилуулагдсан байна. Үүдгээ
 эд хөрөнгийг гүйцэтгэлийн эрх зүйн баталгаатай, эрсдэлгүй орчин нөхцлийг хангалтад
 хөрөнгийг эрх зүйн байдлыг сонирхсон хүнд мэдээлгээр хангахыг зорилго болгож, үйл хөдлөх
 зүйн үүдгээс баталгаажуулан хамгаалах зорилготой боловч талаар гухайн үйл хөдлөх эд
 Япония үйл хөдлөх эд хөрөнгийг бүртгэл нь эдг талаар хууль ёсны эзэмшигчийн эрх
 шашингийн нийтлэг гэж байдаг.
 Шихо шогийн орон нутгийн холбоонуудыг нэгтгэсэн Япония шихо
 шогийг эгч үйл ажиллагаатаа явуулна.
 зүйн сайдын тусгай зөвшөөрөл авсан хүн засаг захиргааны нэгж бүрд байдаг шихо
 Шихо шогийн нь хууль зүйн сайдын шалгалтанд тэнцсэн хүн юм хууль

2004 ОНД БАТЛАГДСАН ЗАРИМ ХУУЛЬ

1. Төрийн нууцын жагсаалт батлах тухай	2004.1.02
2. Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай	2004.4.15
3. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай	2004.4.15
4. Тариалангийн тухай	2004.4.22
5. Усны тухай	2004.4.22
6. Терроризмтой тэмцэх тухай	2004.4.23
7. Даатгалын мэрэгжлийн оролцогчийн тухай	2004.4.30
8. Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэнд хяналт тавих тухай	2004.5.06
9. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлал олдмолын хомсдолоос сэргийлэх тухай	2004.05.11
10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	2004.05.13
11. Үндэсний их баяр наадмын тухай	2004.05.13
12. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	2004.05.14

ЗАРИМ ХУУЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- Төрийн нууцын жагсаалт батлах тухай Монгол Улсын хуульд “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийн томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ гэжээ.

Энэ хуулиар төрийн нууцыг Үндэсний аюулгүй байдлын хүрээнд хамаарах, батлан хамгаалах хүрээнд, эдийн засаг, техник, технологийн хүрээнд, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд хамаарах нууц гэж ангилж авч үзсэн байна.

- Усны тухай Монгол Улсын хуулийн зорилт нь усыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Манай улсын усны нөөц жилээс жилд хомсдож олон зуун гол, мөрөн ширгэсэн нь усны тухай төрийн бодлогыг шинэчлэхэд хүргэсэн байна. Усыг хэрэглээний зүйл болон байгалийн нөөц болох талаас нь авч үзвэл хуулийн гүйцэтгэх үүрэг өндөр гэдэг нь эргэлзээгүй. Усны талаар гарсан хууль тогтоомжууд харилцан адилгүй ч үндсэн зарчим хаана ч ижил байна. Учир нь ус байнга хөдөлгөөнтэй шилжиж байдаг нийтийн ашиг сонирхол болон бусад ашиглагчдын эрх ашгийн үүднээс ус ашиглагч, эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт тавих зайлшгүй шаардлагатай байдаг.
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль нь тус улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилттой. Төрийн эрүүгийн бодлогын нэг чиглэл нь малын хулгайтай тэмцэхээр тодорхойлогдож байгаа бөгөөд энэ хууль батлагдсантай холбогдож Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт орсон билээ. Өөрөөр хэлбэл халдлагын зүйл болох малаас хамаарч ял шийтгэлийг ердийн хулгайлах гэмт хэргээс хүндрүүлэн авч үзэх болсон.
- Яам болон Засгийн газрын агентлагийн тухай Монгол Улсын хоёр хуулийн зорилт нь Монгол Улсын яам, Засгийн газрын агентлагийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлон, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Яам, агентлагийн эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлсон нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бодлого, удирдлага, төрөөс иргэнд үйлчлэх үйл ажиллагааг үндсэн хуультай ёсны хийгээд эрх зүйт төрийн нөхцөлд чандлан хэрэгжүүлж, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан байгуулах Үндсэн хуулийн зорилтыг хангах арга ажиллагаанд чухал алхам болно.

АШИГЛАХ
 ТУХАЙ
 ХУУЛЬ

ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ 2004-2005 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД

- ❖ Тус сургууль хичээлийн 5 давхар шинэ байраа ашиглалтад хүлээн авлаа. Бид нэг ээлжинд 500 гаруй оюутан зэрэг хичээллэх боломжтой болов. Энэ хичээлийн жилд эхлэн бизнесийн эрх зүйн анги, эрх зүйн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөх оройн ангийг тус тус шинээр нээн хичээллэж байна. Сургуулийн хичээлийн шинэ байр хичээллэх ангиуд, лекцийн болон алдарын танхим, нэг ээлжинд 50 гаруй суудал бүхий номын сангийн уншлагын танхим, багш, захирал, сургалтын алба, тэнхимийн гээд албан ажлын өрөөнүүд, цайны газартай боллоо. Ингэснээр оюутан, багш, ажилчид тав тухтай орчинд суралцах, ажиллах гаатай нөхцөл бүрлэв.



Шихихуруг ХЗДС-ийн байр

- ❖ Дэлхийн банкны "Шүүх, эрх зүйн шинэчилэл" төслийн санхүүжилтээр манай сургууль-Хууль Зүй Дотоод Хэргийн Сайд, Егловсрол Соёл Шинжлэх Улсын сайдын хамтарсан 2004 оны 185/351 тоот тушаалд зөвснээр 2004-2008 онд сургалтын шинэчилсэн залуур хөтөлбөрөөр хичээллэх болов. Шинэ хөтөлбөрийн гол зорилго нь хууль зүйн сургалтын агуулгыг хэрэглээний чиглэлд илүү хандуулж, олон улсын стандартад ойртуулах, оюутанд мэдлэг, чадвар, хандлагыг цогц байдлаар төлөвшүүлэх эхний ахламуудыг хийх, оюутанд англи хэл, компьютерийн гүнзгийрүүлсэн мэдлэг, чадвар олгоход оршино. Хичээлийн мэргэжлийн суурь хичээл, мэргэшүүлэх хичээл гэж ангилан үзэхийн хамт сонгон суралцах хичээлийн тоо, клиник сургалтын хичээлийн цагийг нэмэгдүүлж байгаа болно.

Сонгон суралцах хичээл гэхэд л:

- Ерөнхий суурь 4 хичээлээс 2-ыг
- Мэргэжлийн суурь 6 хичээлээс 2-ыг
- Мэргэшүүлэх 22 хичээлээс 5-ыг оюутанд өөрийн сонирхолын дагуу тус тус сонгох боломжтой юм.

Хичээл заах арга, арга зүй, үнэлгээнд шинэчлэлийн эхлэлийг тавьж, оюутны идэвхи, санаачлага, бие дааж ажиллах чадварыг дээшлүүлэх асуудал ч манай шинэчлэлийн бас нэг гол чиглэл байх болов.

- ❖ Багш нарыг эрдэмжүүлэх асуудалд илүү анхаарал тавьж, тэднийг судалгаа шинжилгээний ажлын бие даасан төлөвлөгөөтэй ажиллуулж байна. Энэ хичээлийн жилд нэг багш хууль зүйн ухааны докторын (PhD) зэрэг горилсон бүтээлээ бичиж дуусгана. Нэг багш докторантурт элсэн суралцаж байна. Хоёр багш хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалав. Сургуулийн магистрантурын сургалтад одоо 20 гаруй хүн хичээллэж байна.
- ❖ Хуульч, судлаач, эрдэмтэд хийгээд суралцагчид, нийт уншигчдад зориулан сургуулиас эрхлэн гаргадаг “Сихихутуг” сэтгүүлийн нийтлэлийн боллого, чанар, дизайнд зохих шинэчлэл хийж, уншигчдын эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцэхүйц онол, арга зүй, мэдээлэлийн уншуур сайтай материалыг орчин цагийн сэтгэлгээ, хэрэглээийг шаардлагаар бэлтгэж, гаргалтын тоог нэмэгдүүлэв.
- ❖ Манай оюутнууд улсын хэмжээнд зохиогдож буй судалгаа шинжилгээний ажлын болон урлаг, спортын уралдаан, тэмцээнд амжилттай оролцож байна. Хүний эрхийн комиссоос зохион байгуулсан “Эрүү шүүлт ба хүний эрх” сэдэвт тэмцээнд багш Д.Отгонтуяа, багш Ч.Эрхэмбаярын удирдлагаар 4 дүгээр курсын оюутан Ч.Ганбаатар, Э.Цэнгүүн, 3 дугаар курсын оюутан Б.Ганпүрэв, С.Нарантуяа, Х.Түвшинбаяр, 2 дугаар курсын оюутан Б.Билгүүн нарын бүрэлдэхүүнтэй “Хийдлийн ангуучид” баг амжилттай оролцож шагналт байр эзлэв.



“Хийдлийн ангуучид” багийнхан
 өмөр эгжсэн дүү гэрээс: Б.Ганпүрэв, Ч.Ганбаатар, Б.Билгүүн
 арын эгжсэн дүү гэрээс: С.Нарантуяа, Х.Түвшинбаяр, Э.Цэнгүүн



Хууль зүйн Үндэсний төв, Дэлхийн банкны “Шүүх эрх мэдлийн шинэчлэлт” төсөл, Нээлттэй академид Монгол Улсын анхдугаар үндсэн хууль батлагдсаны 80 жилийн ойд зориулан хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан эрдэм шинжилгээний бага хуралд 4 дүгээр курсын оюутан Д.Аянагулийн тавьсан “Эрүүгийн байцлан шийтгэх ажиллагаан дахь гэрчийн хамгаалалт, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал” сэдэвт илтгэл “Шилдэгийн шилдэг” илтгэлээр шалгарав.

4 дүгээр курсын оюутан Д.Мөнхсахъяа
Монголын оюутны холбооны дээд шагнал
“Эрх ашгийн төлөө тэмцэгч оюутан”
өргөмжлэл;

4 дүгээр курсын оюутан Б.Халиун сагсан
бөмбөгийн Улсын аврага шалгаруулах
тэмцээнээс мөнгөн медаль;

3 дугаар курсын оюутан С.Нарантуяа
Нийслэлийн хүүхэд, залуучуудын
хөгжлийн газрын “Шилдэг залуу” алтан
медаль;

3 дугаар курсын оюутан Г.Золжаргал Бүх
ард түмний урлагын бага наадмын тусгай
байр, Хүүхэд залуучуудын хөгжлийн газрын
нэрэмжит “Ирээдүйн од” алтан медаль;

1 дүгээр курсын оюутан Д.Алъяабазар Дэлхийн урлагийн нээлттэй фестивалд
оролцон гранфри шагнал

ХУУЛЬЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

- ◆ **Иргэн:** Би 2003 оны 11 сарын 10-нд нэгэн таксины компанитай автомашин зээлээр худалдах, худалдан авах гэрээ байгуулж урьдчилгаанд 500 доллар өгч хоногийн 20000 төгрөг тушаах болсон юм. Ингээд саяхан машинаа авахад 1 сарын хугацаа үлдээд байхад жижиг автын осолд орж машинд нэлээд хэмжээний эвдрэл учирсан ба цагдаагийн газраас миний буруугүйг тогтоосон. Гэтэл компаний захирал Н, дүүгийнхээ хамт манай гэрт ирж миний машиныг хүчээр авч явсан бөгөөд шалтгаанаа ...машинд их хэмжээний хохирол учруулсан, 3 хоног орлогын мөнгө тушаагаагүй гэж тайлбарлалаа. Би орлого гэж 7,5 сая төгрөг, 500 ам.доллар компанид тушаасан, тэгвэл мөнгөө авъя гэхэд “Н” өөдөөс “хөлөө хүрэх газраа яв” гэж тавлаад миний машиныг өөр хүнд түрээслэсэн гэлээ. Би хаана, хэнд хандаж хохирлоо нэхэмжлэх вэ ?
- **Хуульч:** Та дээрх компаний үйл ажиллагаа явуулдаг болон удирдлага нь байрладаг дүүргийн шүүхэд хандаж нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд урьдчилгаа өгсөн болон орлого тушаасан баримтууд, гэрээнийхээ эхнийг нэхэмжлэлдээ хавсаргана. Таксины компаниуд яльгүй зүйлээр шалтаглан автомашин түрээслэж авсан жолоочийн эрх ашгийг хохироох явдал цөөнгүй гарч байгаа тул мэргэжлийн өмгөөлөгчийн туслалцаа авахыг танд зөвлөж байна.
- ◆ **Иргэн:** Би 2 жилийн өмнө өөрийн найз Д-д итгээд 3 сая төгрөгөө сарын 2 хувийн хүүтэй зээлдүүлсэн, найздаа итгээд гэрээ байгуулаагүй, ямар нэгэн баримт авч үлдээгүй бөгөөд одоо хүү алдангийн хамт 5 сая төгрөг болоод байна. Шүүхэд хандаж үзсэн боловч баримтгүй гээд миний нэхэмжлэлийг хүлээн авсангүй. Хохирлоо хэрхэн барагдуулах боломжтой талаар надад зөвлөнө үү !
- **Хуульч:** Иргэний хуулийн 282 дугаар зүйлд зааснаар хүү тогтоосон зээлийн гэрээг бичгээр хийнэ, энэ шаардлагыг хангаагүй бол хүү авах эрхээ алдана, мөн хуулийн 232.3 дугаар зүйлд зааснаар анзын гэрээг бичгээр хийнэ гэсэн шаардлагын дагуу та үндсэн зээлээс гадна хүү, алданги нэхэмжлэх эрхгүй. Харин анх зээлдүүлсэн 3 сая төгрөгөө баримтжуулж байж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болно. Та Д-тэй уулзаж тодорхой өрөө төлөх тодорхой хугацаа тогтоож байгаагаа мэдэгдэж, энэ хугацаанд төлнө гэсэн баталгааг бичгээр гаргуулан авч болно, эсвэл хөндлөнгийн хүнтэй хамт Д-гийн гэрт очиж өрөө нэхэх /дараа нь шүүхэд гэрчээр дуудахын тулд/, түүнчлэн диктафон, гар утасны

дуу хураагуурт өр авлагын тухай тодорхой ярьсан бичлэгээ буулгаж авч болох юм.

- ◆ **Иргэн:** Би Америкийн виз найдвартай гаргаж өгнө гэсэн зарлалын дагуу “Ө” гэдэг нас тогтсон эмэгтэйтэй танилцаж ажил гүйцэтгэх гэрээ байгуулан урьдчилгаанд 2 сая төгрөг, гадаад паспортын хамт өгч виз даруулахаар тохирсон юм. Гэрээ ёсоор 1 сарын дотор виз даруулж өгөх, чадахгүй бол миний 2 сая төгрөгийг 3 сая төгрөг болгож өгөхөөр тохирсон боловч өнөөдөр 3 сарын хугацаа өнгөрсөн боловч “Ө”-с сураг чимээ алга. Шүүхэд өгье гэхээр хаягийг нь мэдэхгүй юм, би хаана хэрхэн хандах вэ ?
- **Хуульч:** “Ө”-тэй хийсэн таны гэрээ хуулийн хүчин төгөлдөр бус хэлцэл бөгөөд АНУ-ын Элчин Сайдын Яам, консулаас өөр ямар ч байгууллага, хувь хүн тухайн улсын визийг гаргаж өгөхөөр амлах, үүрэг хүлээх ёсгүй. Та “Ө”-д залилан мэхлэгдэж 2 сая төгрөгөө алдсан учир даруй цагдаагийн байгууллагад хандаж өргөдлөө гаргах хэрэгтэй. Энэ асуудал нь гэмт хэргийн шинжтэй учир эхлээд шүүхэд хандах хэрэггүй.

- ◆ **Иргэн:** Хэд хоногийн өмнө би бааранд нэгэн охинтой танилцаж улмаар бид тэр оройдоо манай гэрт очиж бэлгийн харьцаанд орсон, өглөө нь тэр охин надаас 50000 төгрөг өгөөч гэхээр нь би дургүйцэж гэрээсээ хөөсөн юм. Гэтэл тэр охин миний иргэний үнэмлэхийг сэм авсанаас гадна намайг хүчиндлээ гэж цагдаагийн байгууллагад өргөдөл гаргаж, “1 сая төгрөг өгөхгүй бол чамайг шоронд хатаана” гэх зэргээр заналхийлэх боллоо. Би ч өдөр болгон цагдаагийн газрын үүд сахиж, хийгээгүй хэргийн төлөө сэтгэл санаа, ажил төрлийн хувьд их хохирч байна. Би нэхсэн мөнгийг нь өгөөд салах уу, эсвэл шүүхээр орж эцсээ үзэх үү, надад зөвлөөч.
- **Хуульч:** Шинэ Эрүүгийн хуулийн 126.1-д зааснаар хүчингийн гэмт хэрэг нь хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарч байгаа тул хохирогчтой эвлэрсэн гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болохгүй учир чин түүний шаардсан мөнгийг өглөө ч асуудал шийшгэгдэхгүй.

Та сайн өмгөөлөгч хөлслөн авч гэмт хэрэгт холбогдуулан гүтгэж байгаа тэр хүүхнийг өөрийг нь шалгуулахаар /Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйл/ өргөдлөө гарга. Тэр хүүхний урьдын явдал, биеэ үнэлдэг эсэх, яагаад танихгүй айлд дагаж очсон зэрэг нөхцөл байдлуудыг тодруулж өгөх хүсэлтийг байцаагч болон өмгөөлөгчдөө тавинарай. Манай шүүгчид энэ хэргийн учрыг олж чамайг цагаатгана гэдэгт хуульчийн хувьд найдаж байгаа боловч асуудал буруугаар эргэвэл дээд шатны шүүхэд, Хүний эрхийн Үндэсний комисст заавал хандаарай.

ШИНЭ НОМ

Хууль зүйн их, дээд сургуулийн оюутан, багш, хуулийн байгууллагын ажилтан, магистрант, доктронг судлаачидад зориулан 2004 онд дараах ном бүтээлүүд хэвлэгдэн та бүхний гар дээр очиж байна.

1. “Монголын орчин цагийн экологийн эрх зүй” Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор О.Амархүү
 - Зохиогч энэхүү бүтээлдээ боловсролын өнөөгийн болон цаашдын хөгжлийн чиг хандлагыг харгалзан Монголын байгаль орчны эрх зүйн асуудлыг онол, хэрэглээний мэдлэгийн хослол дунд авч үзэн түүх, уламжлал, шинэчлэлийн залгамж холбоогоор дэлгэрэнгүй судлан үзсэн нь онол, практикийн өндөр ач холбогдолтой болсон байна.

2. “Монгол Улсын засгийн газрын тэргүүн” – нэг сэдэвт бүтээл. Академч Ж.Болдбаатар.
 - Төрийн эрх мэдэл хуваарилалтын онол, практикийн хүрээнд Засгийн газар, түүний тэргүүн томоохон байр суурь эзэлдэг. Энэ утгаар зохиогч номондоо Монгол Улсын Засгийн газрын тэргүүний статус, түүний түүхэн хөгжлийг төрийн онол, улс төрийн шинжлэх ухааны үүднээс түүхэн цаг хугацааны үе шатуудаар залгамжлуулан өгүүлсэн нь онол, практикийн чухал бөгөөд сонирхолтой асуудлыг анх удаа задлан шинжилж үзсэн байна.

Энэ бүтээлд Олноо өргөгдсөн Монгол Улсын Засгийн газрын тэргүүнүүдээс эхлээд Монгол Улсын шинэ Үндсэн хууль үйлчилж буй үеийн Засгийн газрын тэргүүнүүдийг хамарсан нийт 22 удирдагчийн үйл ажиллагааны төлөв байдалд дүн шинжилгээ хийсэн нь уншигчдын сонирхолыг зүй ёсоор татаж байгаа юм.

3. “Эрх зүй, төрийн ерөнхий онол” докторант Ч.Нямсүрэн
 - Шинэчлэгдсэн 4 дэх удаагийн бүтээлдээ зохиогч эрх зүй, төрийн ерөнхий онолын асуудлуудад онцгой ач холбогдол өгч урьд өмнөх сурах бичгүүдээс боловсронгуй болгох зорилт тавин нэмэн засварлаж хэвлүүлжээ.

4. **“Монгол Улсын иргэний эрх зүй” I дэвтэр. доктор(PhD), профессор О.Жамбалдорж**
 - Зохиогч бүтээлдээ иргэний эрх зүйн ойлголт, категори, институт зэргийг тодорхой сэдвүүдэд ангилж, аль болохоор анхаарал татсан, шинэлэг маргаантай асуудлыг тусгасан байна.
5. **“Криминологи” доктор(PhD), профессор Н.Жанцан**
 - Зохиогч энэхүү бүтээлдээ гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг олж тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх криминологийн шинжлэх ухааны үндсэн асуудлуудыг онол-практик, харьцуулалтын зохих түвшинд бэлтгэн боловсруулсан байна.
6. **“Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа” нэг сэдэвт бүтээл, докторант Г.Ганбаатар, магистр О.Амарсайхан**
 - Зохиогчид энэхүү бүтээлдээ Монгол Улсын эрүүгийн эрх зүй дэх цаг хугацаа, түүний төрлүүдийн ойлголт, мөн чанар, эрүүгийн эрх зүйн учир холбогдол, түүнийг боловсронгуй болгох асуудлыг иж бүрдлээр нь тодорхойлсон байна.
7. **“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийн нотлох ажиллагаа” доктор (PhD) Ж.Болдбаатар**
 - Зохиогч номондоо мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагааны онцлогийг онол, арга зүйн зохих түвшинд авч үзсэнээр уг гэмт хэрэгтэй тэмцэх өвөрмөц арга зүйг боловсруулсан ач холбогдолтой болжээ.
8. **“Эрүүгийн эрх зүй” - онол, практик докторант Ц.Цэлмэг**
 - Зохиогчийн энэхүү бүтээл нь зөвхөн хуульчид төдийгүй жирийн иргэд ч ашиглах боломжтой болсноороо онцлогтой бөгөөд онолын мэдлэгээ практикт хэрэглэх чадвар эзэмшихэд тус дөхөм болгох зорилгоор эрүүгийн хуулийн олон тооны бодлого оруулсан нь уншигчдын мэдлэг, чадвар, дадлагын хэрэгцээнд илүү нийлэмжтэй болжээ.

ТЭМДЭГЛЭЛ

“ШИХИХУТУГ” номыг
Жанжин Сүхбаатарын Нэрэмжит Хөдөлмөрийн Гавьяаны
Улаан тугийн одонт “СҮХБААТАРПРИНТ” ХХК-д хэвлэв.
Хэвлэлийн хуудас 995х720/32
Хуудасны тоо 134